

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 2 дугаар хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

№	Үндэслэж буй бодлогын баримт бичиг, зорилт	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)
				Он	Түвшин		
1	2	3	4	5	6	7	8
<b>НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ</b>							
<b>Зорилго: Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын хамрах хүрээг өргөжүүлэн, гэр бүлд ээлтэй жендэрийн мэдрэмжтэй цогц бодлого хэрэгжүүлнэ.</b>							
<b>ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ</b>							
<b>Зорилт 1.1. Эх хэл, соёл, ёс заншлаа дээдэлсэн эх оронч үзэлтэй эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг төлөвшүүлэн хөгжүүлж, түүх, соёлын өвөө хамгаалан, үндэсний бахархлаа түгээн дэлгэрүүлж, соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.</b>							
1	Биет бус өвийг өвлөн уламжлуулах шавь сургалтыг хөгжүүлж, шилдэг өвлөн уламжлагчдыг дэмжин, төв халхын болон нутгийн онцлогтой өвийг хамгаалах арга хэмжээг зохион байгуулна.	28 сая төгрөг	Урамшуулсан, дэмжсэн өвлөн уламжлагчийн тоо	2021	18	5	Төв халхын уртын дууны өв санг хамгаалах, шавь сургалтыг хөгжүүлэх, сурталчлан түгээн дэлгэрүүлэхээр “Уртын дуугаа дээдлэн дэлгэрүүлцгээе” нэг сарын аяныг аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Аяны хүрээнд Оломгүй далай, Нарийн сайхан хээр, Хүрэн толгойн сүүдэр зэрэг дууг иргэд олон нийтэд сурталчлан 1500 гаруй хүүхэд, залуучууд, иргэд сурчээ. Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн секторын эрхлэгчтэй хамтран “Уртын дууны тархалт, хамгаалалтын өнөөгийн байдал” сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, соёлын өвийн ажилтнуудад зөвлөмж өгч ажилласан. Аймгийн биет бус өв, өвлөн уламжлагчийг үндэсний мэдээллийн санд бүртгэн баримтжуулах ажлыг зохион байгуулж Уянга, Богд, Гучин-Ус, Арвайхээр, Тарагт, Өлзийт, Бүрд сумдын нийт 42 өвлөн уламжлагчийг хамруулсан. Соёлын өвийн Үндэсний төвөөс “Шавь сургалтыг хөгжүүлэх, өвлөн уламжлагчийг дэмжих журам”-ын саналыг авсан бөгөөд журмын төслийг аймгийн соёлын ажилтнуудын дунд хэлэлцүүлсэн. Нүүдэлчин Монгол-2022 биет бус өвийн их наадамд аймгийн 57 өвлөн уламжлагчид оролцож, 2 өвлөн уламжлагч шилдэг өвлөн уламжлагчийн шагнал хүртсэн. Мөн шавь сургалтыг хөгжүүлэх зорилгоор Уянга сумын өвлөн уламжлагч, уртын дуучин нь 400 гаруй иргэдэд уртын дуу зааж, соёлын өвийг сурталчилж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
2	“Өвөрхангайн авьяас” залуучуудын урлагийн	13,5 сая төгрөг	Урлагийн наадамд	2021	300	500	“Өвөрхангайн авьяас” урлагийн наадмыг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан энэ онд бүжгийн чиглэлээр зохион байгуулахаар

	наадмыг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулна.		оролцсон оролцогчдын тоо				шийдвэрлэсэн. Энэ хүрээнд хүүхэд, залуучуудын авьяас билгийг нээх, бүжгийн урлагийг орон нутагт хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэхээр “Хаврын баяр” наадмыг цэнгээнт, спорт, нийтийн, орчин үеийн, ардын бүжгийн нийт 5 төрлөөр зохион байгууллаа. Төрөл тус бүрд бага, дунд, өсвөр үе, залуучууд, ахмад гэсэн насны ангиллаар 800 гаруй хүн өрсөлдөж, 128 оролцогчдыг шагнаж урамшуулсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
3	Өндөр Гэгээний соёлын өвийг сурталчлах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор "Zanabazar Art Festival" урлагийн олон улсын наадмыг зохион байгуулна.	-	Урлагийн олон улсын наадмыг зохион байгуулсан эсэх	2021	Урлагийн наадмыг зохион байгуулж, 230 уран бүтээлч оролцсон.	Урлагийн наадмыг зохион байгуулсан байна.	Соёлын өв, урлаг, уран бүтээл, урлал, музейн үйл ажиллагааг хөгжүүлэхээр ZANABAZAR ART FESTIVAL дүрслэх урлагийн цахим хуудсыг ажиллуулан 100 гаруй пост мэдээллийг нийтэлж, 15000 гаруй хүнд хүргэсэн. ZANABAZAR ART FESTIVAL-2022 урлагийн эвент арга хэмжээний хүрээнд Хурд хамтлагтай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, наадмын сүлд Алтан Соёмбо дууг бүтээлгэн аймагт хүлээлгэн өгөх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулж, 500 гаруй иргэд олон нийт хамрагдсан. ZANABAZAR ART FESTIVAL-2022 урлагийн наадмыг бүтээлч үйлдвэрлэл болгон хөгжүүлэх төсөл бичиж, Соёлын яаманд хүргүүлсэн. Мөн тус наадмын шилдэг 6 уран бүтээлийн үзэсгэлэн гаргах ажлыг “Үндэсний Урлагийн Их наадам”-ын урлагийн тоглолттой хамтран зохион байгуулж, 1000 гаруй хүнд хүргэж сурталчилсан байна. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
4	Музей үзэл баримтлал боловсруулан батлуулах	60,5 сая төгрөг	Музейн үзэл баримтлал боловсруулсан эсэх	2021	-	Музейн үзэл баримтлал боловсруулсан байна.	Шинээр баригдаж байгаа аймгийн Музейн үзүүлэг дэглэлтийн үзэл баримтлалыг боловсруулах ажлын хэсэгт 8 эрдэмтэн судлаач нарыг оролцуулан ажиллаж байна. Арвайхээр, Хархорин сумдад ажиллаж музейн үзэл баримтлалын анхны концепцийг гаргасан. Энэ хүрээнд музейн үйлчилгээний талаарх болон, Өвөрхангайн эрхэмлэх үнэт зүйлийг тодруулах санал асуулгыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 1932 иргэдийг хамруулж, иргэдийн саналыг тусган ажиллаж байна. Мөн ажлын хэсэг Өмнөговь аймгийн Музей, Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн “Уурхайчин”, Улаанбаатар хотын Чингис хааны музейн үзүүлэг дэглэлттэй танилцаж туршлага судалсан. Музейн үзүүлэг дэглэлтийн үзэл баримтлалыг боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
5	Хөгжим бүжгийн коллежийн хүний нөөц, хамрах тойрог хэрэгцээний судалгаа хийнэ.	-	Хөгжим бүжгийн коллежийг байгуулах хэрэгцээний судалгаа	2021	-	Хүний нөөц, хамрах тойрог хэрэгцээний судалгаа хийгдсэн	Хөгжим бүжгийн коллеж байгуулах ажлын хүрээнд Монгол улсын Консерватортой хамтран судалгааны чиглэлээр хамтран ажиллаж байна. Хөгжим бүжгийн коллежийн сургуулийн хэрэгцээ, хамрах тойргийн талаарх хэлэлцүүлгийг аймгийн Хөгжимт драмын театрын уран бүтээлчид болон Соёл, урлагийн их сургуулийн Соёлын сургуулийн захирал доктор (Ph.D) Ш.Эрдэнэцэцэг нартай зохион

			хийгдсэн эсэх			байна	байгууллаа. Мөн Хөгжим бүжгийн коллежийг байгуулахтай холбоотойгоор “Орон нутгийн соёл, урлагийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” сэдвийн хүрээнд бүсийн хэлэлцүүлгийг Архангай, Баянхонгор, Булган, Дундговь, Говь-Алтай аймгуудыг хамруулан зохион байгуулж, судалгааны ажлыг эхлүүлээд байна. <b>Хэрэгжилт-70хувь</b>
6	Зарим сумдын номын сангуудыг LIBU-IV программаар хангах	6,0 сая төгрөг	LIBU-IV програмаар хангагдсан номын сангийн тоо	2021	1	18	Сумдын номын сангууд LIBU-IV программаар 100 хувь хангагдаж, тус программыг ажиллуулах үзүүлэлт сайтай 18 компьютерыг улсын төсвийн 41,1 сая төгрөгөөр шинэчлэв. Үүнээс 7 сумын номын сан LIBU-IV программын лицензийг сунган ажиллуулж, бусад сумд программд номоо цахим хэлбэрт оруулж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
7	Аймгийн Хөгжимт драмын театрын уран бүтээлчдийн хувцас шинэчлэл хийх	65,0 сая төгрөг	Уран бүтээлчдийн хувцас хийгдсэн эсэх	2021	-	Уран бүтээлчийн хувцас шинэчлэгдсэн байна.	Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлчдийн хувцас шинэчлэлийг орон нутгийн төсвийн 33,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж, Хөгжимт драмын театрын уран бүтээлчдийн болон язгуур урлагийн “Хөх домог”, “Гоцлол дуучид”-ын тоглолтын нийт 45 иж бүрэн хувцас шинэчлэгдсэн байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
8	“Өвөрхангай соёлын өдөр” арга хэмжээг 3 суманд зохион байгуулах	5,0 сая төгрөг	Зохион байгуулсан сумдын тоо	2021	3	3	“Өвөрхангай соёлын өдөр” арга хэмжээг Соёл, урлагийн газар, аймгийн Хөгжимт драмын театр, Музей, Номын сан, Зөв цаг бүжгийн клубтэй хамтран Төгрөг, Баянгол, Сант зэрэг сумдад зохион байгуулж, соёлын үйлчилгээг 1000 гаруй иргэдэд хүргэсэн. Энэ хүрээнд Монгол улсын баатар Л.Аюушийн 100 жилийн ойг тохиолдуулан түүний талаарх түүхэн хичээлийг Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зааж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилсан. Мөн үндэсний бичиг үсгийн үзэсгэлэн, шинэ номын арга хэмжээ, урлагийн тоглолт, хүүхдийн жүжиг зэргийг тус тус хүргэн иргэд, олон нийтэд соёлын боловсролыг түгээсэн. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>ЭРҮҮЛ МЭНД</b>							
<b>Зорилт 1.2. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.</b>							
9	Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийг төв болгон өргөтгөх ажлыг эхлүүлнэ.	48,0 сая төгрөг	Бүтэц, орон тоог нэмэгдүүлэх	2021	8	12	“Эрүүл мэндийн газрын дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоох тухай” аймгийн Засаг даргын 2022 оны А/181 дүгээр захирамжаар Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн орон тоог 2-оор нэмэгдүүлж, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 7, мэдээллийн ажилтан 1(нийт 10) хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулахад тулгамдаж буй байрын асуудлыг, цаашид хэрхэн шийдвэрлэх талаарх саналыг аймгийн Засаг даргын 2022 оны 1/490 дүгээр албан бичгээр Эрүүл мэндийн яаманд

							хүргүүлсэн.
							<b>Хэрэгжилт-70 хувь</b>
10	Хавдрын 7 төрөл, даралт ихсэлт, чихрийн шижингийн эрт илрүүлгийн үзлэгт зорилтот насны хүмүүсийг хамруулж, эмчилгээ, хяналтыг зохион байгуулна.	70,0 сая төгрөг	Эрт илрүүлэгийн хамрагдалтын хувь	2021	42	50	<p>Эрүүл мэндийн яамны дэмжлэгтэйгээр аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хархорин сумын Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийг дэмжих төвийг ашиглалтад оруулснаар эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, хорт хавдрыг эрт үед нь оношлох, илрүүлэх үзлэгийг цогцоор үзүүлэх боломж бүрдсэн.</p> <p>Дээрх төвүүд болон хувийн хэвшлийн Чинмэнд, Ачтан-Ирээдүй, Ариун-санаа эмнэлгүүдэд эрт илрүүлгийн үзлэгт нийт 13973 иргэнийг хамруулаад байна. Шинээр 164 хавдрын тохиолдол бүртгэгдсэнээс 95 хүн буюу 56,5 хувь нь 3 болон 4 дүгээр үе буюу хөнгөвчлөх тусламж үйлчилгээ шаардлагатай хожуу үедээ оношлогдож байна.</p> <p>Одоогоор хавдрын хяналтад нийт 975 хүн байгаагаас хөнгөвчлөх тасагт 131 хүнийг хэвтүүлэн эмчилж тусламж үйлчилгээг хүргэсэн. Хавдрын өвчлөлд элэг, улаан хоолой, ходоодны хавдар өндөр байна. Хөхний хавдар илрүүлэх үзлэгт 27672 иргэн хамрагдахаас 10869 буюу 39.3 хувь, умайн хүзүүний хавдар илрүүлэх үзлэгт зорилтот насны 6502 эмэгтэй, хамрагдахаас 3471 буюу 53,4 хувь нь хамрагдаж 10 тохиолдлыг дээд шатлалд, 40 тохиолдлыг эмчилгээ, хяналтад авсан.</p> <p>Хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд зохион байгуулж, 9326 хүүхэд хамрагдсанаас 0-5 насны 2086, 6-17 насны 7240 хүүхэд байна.</p> <p>Насанд хүрэгчдийн үзлэгийг Арвайхээр суманд Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон хувийн хэвшлийн 3 эмнэлэг, Хархорин сумын Нэгдсэн эмнэлэгт хийж, 18-30 насны 2436, 31-45 насны 891, 46-60 насны 867, 61-ээс дээш насны 453 иргэн хамрагдаад байна. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн 51,6 хувь нь эмэгтэй, 48,4 хувь нь эрэгтэй байна.</p> <p>Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 50745 иргэн хамрагдахаас 17634 буюу 34,8 хувь хамрагдаж шинээр артерийн гипертензи оношлогдсон 126 иргэнийг эмчилгээ хяналтад авсан.</p> <p>Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 29080 иргэн хамрагдахаас 16206 буюу 55,7 хувь нь хамрагдаж, шинээр чихрийн шижин 18 батлагдан, эмчилгээ хяналтад аваад байна.</p> <p>Эрт илрүүлгийн үзлэгээр 31-с дээш насны иргэдийн ходоод, улаан хоолойн сөөргөө, ходоодны үрэвслийн тохиолдол элбэг оношлогдож байна.</p> <p>Хүн амыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах ажлыг эрчимжүүлэх хүрээнд 10 сумын эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн Ариунсанаа, Ачтан-Ирээдүй, Чинмэнд эмнэлгүүдэд дэмжлэгт хяналт хийж, зөвлөмжийг хүргүүлсэн. Орон нутгийн онцлогт</p>

							тохируулан 12 төрлийн зурагт хуудас, 2 төрлийн уриалга бүхий видео бичлэг, 5 удаагийн телевизийн нэвтрүүлэг, 113 төрлийн мэдээлэл бүхий зурагт хуудас, видео бичлэгийг цахим хуудсаар танилцуулж, давхардсан тоогоор 352978 удаагийн хандалт авсан байна. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
11	Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх "Гэр бүлийн эрүүл мэнд" цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	50,0 сая төгрөг	Эрүүл мэндийг дэмжигч гэр бүлийн эзлэх хувь	2021	20	30	Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгтэй хамтран "Миний гэр бүл миний аз жаргал" сэдэвт ток шоу, "Гэр бүлийн үнэ цэнэ өнөөгийн байдал" сэдэвт илтгэлийн уралдаануудыг зохион байгуулахад хамтран ажилласан. Эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн, үе тэнгийн сургагч, бүлгүүдийг сургаж, чадавхжуулах, идэвхжүүлэх замаар эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэх, айл өрх, албан байгууллагуудад эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэхээр 2 сум, 5 байгууллага, 239 айл өрх, 7500 гаруй иргэнийг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган, үе тэнгийн сургагч багшаар 80 сурагчийг бэлтгэлээ. Хөдөлгөөн эрүүл мэнд аяны хүрээнд идэвхэжсэн 231 өрх гэр бүлээрээ дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, зөв зохистой хооллох, үлгэр дуурайлал сайн туршлагуудыг түгээж байна. Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр олон нийтийн цахим сүлжээнд эрэгтэйчүүд, гэр бүлийн гишүүн бүрийг эерэг эрүүл зан үйл хандлагад уриалсан 27 төрлийн постер, 12 төрлийн шторк, мэдээлэл, зөвлөгөөг байршуулснаар 80000 гаруй иргэн хандаж, мэдээлэл авсан байна. Эрүүл мэндийг дэмжигч өрхүүдийн тодорхойлолт, тайланг авах ажлыг эхлээд байна. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
12	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд эрэгтэйчүүдийн кабинетыг цогцоор нь байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.	18,0 сая төгрөг	Эрэгтэйчүүдийн кабинетаар үйлчлүүлсэн эрэгтэйчүүдийн тоо	2021	-	1000	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 449 дүгээр тушаалаар "Эрэгтэйчүүдийн кабинетын үйл ажиллагааны үлгэрчилсэн загвар, журам, тусламж үйлчилгээний багц, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног, төхөөрөмж, багаж, хэрэгслийн жагсаалт" батлагдаж, мэргэшсэн эмч нараар хангагдсанаар Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд тусламж үйлчилгээг цогцоор нь үзүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. "Эрчүүдийн эрүүл мэнд" төслийг боловсруулж, багцад заасан тусламж үйлчилгээг бүрэн үзүүлэхэд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, кабинетын тохижилт, эмч, сувилагчийн ажиллах орчныг бий болгоход шаардагдах эд, зүйлсийн жагсаалт, тооцоо судалгааг гарган, аймаг, орон нутгийн удирдлага болон олон улсын байгууллагад хүргүүлэхээр бэлтгэсэн. Энэ онд эрэгтэйчүүдийн эмчийн (андрологи, урологи) үзлэгт 2764 иргэн хамрагдаж, тусламж үйлчилгээ авсан байна. Эрэгтэйчүүдийн өвчлөлд түрүү булчирхайн томрол, чулуужилт, төмсөг дайврын эмгэг зонхилж байна.

							Хэрэгжилт-70 хувь
<b>Зорилт 1.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлнэ.</b>							
13	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд харвалт шигдээсийн нэгж байгуулна. (ангиография)	1,8 тэрбум төгрөг	Нэгж байгуулсан эсэх	2021	-	Харвалт шигдээсний нэгж байгуулсан байна.	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд улсын төсвийн 1,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ангиографийн аппаратыг суурилуулан, 1 эмч нарийн мэргэжлийн сургалтад хамрагдаж байна.
<b>Хэрэгжилт-90 хувь</b>							
14	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн мэдрэл, дотор, мэс заслын тасгийн дотор их засвар хийнэ.	-	Их засварын тоо	2021	-	3	Улсын төсвийн 80,0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сэтгэц наркологиын тасгийн засварыг хийж үйлчлүүлэгчдэд ая тухтай орчин бүрдүүллээ. Мэдрэл, дотор, мэс заслын тасгийн дотор их засварын ажил эх үүсвэр шийдвэрлэгдээгүйн улмаас хийгдээгүй.
<b>Хэрэгжилт-50 хувь</b>							
<b>Зорилт 1.4. Цахим эрүүл мэнд, эрт илрүүлэг эргэн дуудах тогтолцоог бүрдүүлж, яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг хөгжүүлнэ.</b>							
15	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сургалтын өрөөг цахим болон танхимын сургалт явуулах зориулалт бүхий техник хэрэгслээр тохижуулна.	20,0 сая төгрөг	Техник хэрэгслийн хангалтын хувь	2021	50	90	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн сургалтын өрөөг 10,0 сая төгрөгийн өртөг бүхий техник хэрэгслээр тохижуулсан. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Сувилахуйн гардан үйлдлийн өрөөг байгууллагын дотоод нөөцөөр, Эрүүл мэндийн газрын гардан үйлдлийн өрөөг Энэрэл сургуулийн дэмжлэгээр нийт 10,0 гаруй сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр тохижуулснаар эмч мэргэжилтнүүд дадлага сургалт хийх орчин бүрдсэн. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Хүүхдийн эмнэлгийн 3 давхарт 150 хүний багтаамжтай сургалтын өрөө гарган тохижуулах төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн (3.1.6.улсын болон орон нутгийн төсөв;) хүрээнд хэрэгжүүлэх боломжгүй болоод байна.
<b>Хэрэгжилт-90 хувь</b>							
16	Хавдрын эрт илрүүлгийн цахим цаг товлох, эргэн дуудах тогтолцоог нэвтрүүлнэ.	-	Цахим програм нэвтрүүлсэн эсэх	2021	-	Цахим програм нэвтрүүлсэн байна.	Хавдрын эрт илрүүлгийн цахим цаг товлох болон цуцлах үйлчилгээг E-mongolia-гаас авах боломжийг бүрдүүлсэн. Мөн иргэдэд хүртээмжтэй байдлыг харгалзан 7032-3212 утсаар цаг захиалах үйлчилгээг нэвтрүүлсэн. Хавдрын эргэн дуудах тогтолцоонд скрининг, канеринг программыг нэвтрүүлэн ашиглаж байна. Энэ онд Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн цаг товлох үйлчилгээг өргөжүүлж 1664 иргэн E-mongolia, 70323212 утсаар 52300 иргэн, цахимын шууд үйлчилгээгээр 46200 иргэн үйлчлүүлсэн байна. Мөн коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын гэрчилгээг цахимаар авах боломжтой болсон.
<b>Хэрэгжилт-100 хувь</b>							
<b>Зорилт 1.5. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бүрдүүлж, мэргэшүүлэн, чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.</b>							
17	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн үр дүнг	50,0 сая төгрөг	Их эмч сувилагчийн харьцааг	2021	1:1:3	1:1:4	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 55 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, сургалт, хөгжил, нийгмийн баталгааг дэмжих” хөтөлбөрийг

	тооцох, цаашдын 2022-2032 оны дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулна.		нэмэгдүүлэх				батлуулан 2019-2022 онд хэрэгжүүлсэн. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын зөвлөлийн хурлаар хөтөлбөрийн үр дүнг 94,0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн. (Их эмч сувилагчийн харьцаа 1:1.4 хүрсэн.) Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 10,000 хүн амд ноогдох их эмч 2,4 хувиар сувилагч 7,3 хувиар, эмч сувилагчийн харьцаа 1:1,4 болж өссөн. Нарийн мэргэшил эзэмшсэн их эмчийн хангалт 16,2 хувиар өссөн үзүүлэлтээр улсад тэргүүлж байна. Цаашид хүний нөөцийн тогтвортой байдал, нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүднээс 2022-2025 онд хэрэгжүүлэх "Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 13/03 дугаар тогтоолоор батлуулсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>Зорилт 1.6. Зарим төрөлжсөн төвүүд болон сумдын Эрүүл мэндийн төвүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.</b>							
18	Хархорин сумын 100 ортой нэгдсэн эмнэлэг барилга, Төгрөг, Сант, Гучин-Ус сумдад 15 ортой Эрүүл мэндийн төв, Бат-өлзий суманд 15 ортой эмнэлгийн барилга, Хайрхандулаан сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	17,8 тэрбум төгрөг	Барилгын ажлын явцын хувь	2021	0	100	Улсын төсвийн 11,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хархорин суманд 100 ортой эмнэлгийн барилга, гүйцэтгэл 30 хувьтай, улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Төгрөг сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, гүйцэтгэл 30 хувьтай, улсын төсвийн 1,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сант сумын Эрүүл мэндийн төвийн барилга, гүйцэтгэл 40 хувьтай тус тус баригдаж байна. Сант сумын эмчийн байрыг халаалтад холбох бэлтгэл ажил хийгдсэн. Улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Гучин-Ус сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажил гэрээ байгуулагдсан. Улсын төсвийн 1,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хайрхандулаан, Бат-Өлзий сумдын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл энэ онд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
19	Аймгийн Эрүүл мэндийн газрын гадна фасадны засвар, Баян-Өндөр, Хужирт сумдын Эрүүл мэндийн төвүүдийг засварлана.	-	Барилгын ажлын гүйцэтгэлээр	2021	0	100	Эрүүл мэндийн газрын гадна фасадны засвар, Хужирт сумын Эрүүл мэндийн төвийн хуучин барилгын их засвар тус тус хийгдсэн. Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2023 онд шинээр барихаар төлөвлөсөн. Хужирт сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажил 30 хувьтай явагдаж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
20	Хужирт, Тарагт сумдын эмчийн байрыг засварлана.	-	Барилгын ажлын гүйцэтгэлээр	2021	0	100	Тарагт сумын Эрүүл мэндийн төвийн эмчийн байрыг засварлаж, ашиглалтад хүлээн авсан. Хужирт сумын Эрүүл мэндийн төвийн эмчийн байранд засвар хийхгүйгээр суманд баригдаж байгаа төрийн албан хаагчдын орон сууцанд байрлуулахаар төлөвлөөд байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>

21	Өлзийт, Есөнзүйл сумдын мооргийн барилга, Хархорин сумын өрхийн эмнэлгийн хуучин байрыг тус тус засварлана.	-	Барилгын ажлын гүйцэтгэлээр	2021	0	100	Өлзийт сумын мооргийг 1,5 сая төгрөгөөр засварлаж, Есөнзүйл сумын Эрүүл мэндийн төвийн мооргийн барилгыг шинээр барихаар гэрээ байгуулж, ажил эхэлсэн. Хархорин сумын өрхийн эмнэлгийн барилгыг буулгаж 100 ортой нэгдсэн эмнэлгийн барилгыг шинээр барьж эхлээд байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
22	Бүрд, Өлзийт, Тарагт, Сант, Уянга, Бат-Өлзий, Хархорин сумдын Эрүүл мэндийн төвийг түргэн тусламжийн автомашинаар хангана.	-	Түргэн тусламжийн машины хангалтын хувь	2021	65	75	Эрүүл мэндийн яамны түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлд Уянга сумын Эрүүл мэндийн төв хамрагдаж шинэ автомашинтай болсон. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Өндөр, Бат-Өлзий, Богд, Бүрд, Өлзийт, Сант, Тарагт, Хархорин, Есөнзүйл, Гучин-Ус сумдын Эрүүл мэндийн төвд эмнэлгийн автомашин хүлээлгэн өгч түргэн тусламжийн машины хангалт 90,0 хувьд хүрсэн. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
23	Баянтээг багийн Эрүүл мэндийн төвийг уламжлалтын эмчилгээ, үйлчилгээтэй болгоно.	-	Уламжлалтын эмчилгээ, үйлчилгээ авсан хүний тоо	2021	-	150	Баянтээг багийн Эрүүл мэндийн төв уламжлалт, нөхөн сэргээх тусламж үйлчилгээг өргөжүүлж, цахилгаан массаж, шарлага, бумба, парафин лаа, төөнүүр зэрэг эмчилгээнүүдийг 204 хүнд үзүүлсэн байна. Цаашид зориулалтын өрөө, тасалгааны хүрэлцээг нэмэгдүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх шаардлагатай байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
24	Зоонозын өвчин судлалын төвийн барилгыг ашиглалтад оруулна.	1,8 тэрбум төгрөг	Барилга угсралтын ажлын явцын хувь	2021	20	100	Зоонозын өвчин судлалын төвийн шинэ барилгыг 1,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр ажил эхэлж, одоогийн байдлаар 90 хувийн гүйцэтгэлтэй, 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
25	Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт орчин үеийн нян судлалын лаборатори байгуулна.	-	Нян судлалын лаборатори байгуулсан эсэх	2021	-	Нян судлалын лаборатори байгуулагдсан байна.	Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 130,0 сая төгрөгийн хөрөнгөөр бактериологийн лабораторийн тоног төхөөрөмжөөр хангагдаж нян судлалын лабораторитой болсон. Ажиллах эмч, мэргэжилтэнг холбогдох сургалтад хамруулж чадавхжуулсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>

#### БИЕИЙН ТАМИР

#### Зорилт 1.7. Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх (эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах) нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох

26	Иргэдийн дунд “Миний нутаг сайхан” спортын наадмыг зохион байгуулна.	24,1 сая төгрөг	Иргэдийн дунд наадмыг зохион байгуулсан эсэх	2021	-	Иргэдийн дунд наадмыг зохион байгуулсан байна.	Монголын бүх ард түмний спортын 15 дугаар наадмын шигшээ тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулах тив, дэлхийн тэмцээн наадамд өрсөлдөх тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэхээр спортын 8 төрлөөр зохион байгуулж, 624 тамирчдыг хамруулсан. Анхан шатны тэмцээнээс шалгарсан 145 тамирчин шигшээ тэмцээнд спортын 18 төрлөөр оролцож алт 5, мөнгө 2, хүрэл 6, мөн багийн төрөлд 1 алт (шатар), 1 хүрэл (Байт харваа) нийт 15 медаль хүртсэн
----	--	-----------------	--	------	---	--	--



							амжилтаар 21 аймгаас 7 дугаар байранд шалгарсан. Монголын Үндэсний спортын 7 дугаар наадмын анхан шатны тэмцээнийг спортын 8 төрлөөр зохион байгуулж, 19 сумын 305 тамирчид оролцож, шалгарсан 84 тамирчид шигшээ тэмцээнд спортын 13 төрлөөр оролцож, 4 алтан медаль хүртэж багийн дүнгээр II байрт шалгарсан. Миний нутаг сайхан” иргэдийн спортын наадмыг 2 үе шаттайгаар 10 дугаар сарын 20-ноос 11 дүгээр сарын 12-нд зохион байгуулахаар спортын төрөл тус бүрийн заавартай нэгдсэн удирдамж батлагдсан. Удирдамжийн дагуу спортын наадмын анхан шатыг 15 сум зохион байгуулж 2908 хүн хамруулсан, анхан шатны тэмцээнээс шалгарсан баг тамирчдын шигшээ тэмцээнийг софт волейбол, ширээний теннис, шатар, сагсан бөмбөг 3x3, үндэсний бөх, волейбол, олс таталт, хийн дасгал гэсэн 8 төрлөөр зохион байгуулж, 18 сумын 590 иргэн хамрагдлаа. Биеийн тамир, спортын газраас 24,1 сая төгрөг зарцуулсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
27	Иргэдэд зориулсан биеийн тамирын гадна талбай, алхалтын зам барьж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ээлтэй орчин бүрдүүлнэ.	50,0 сая төгрөг	Иргэдэд зориулсан ээлтэй орчны тоо	2021	1	3	Тарагт суманд ерөнхий боловсролын сургуулийн гадна талбай болон айл өрхүүд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хүрээнд хашаандаа турник, сагсан бөмбөгийн шийд, савлуур, гимнастикийн хана, Өлзийт суманд 3x3 сагсан бөмбөгийн талбай, Хужирт суманд орон нутгийн хөгжлийн сангийн 10,0 сая төгрөгийн хөрөнгөөр 21x10 хэмжээтэй сагсан бөмбөгийн талбай шинээр байгуулагдаж, хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлсэн. Нарийнтээл суманд улсын төсвийн 500,0 сая төгрөгийн хөрөнгөөр волейбол, сагсан бөмбөг, хөлбөмбөгийн гадна талбайн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>Зорилт 1.8. Спортын сургалт дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан тамирчдын залгамж халааг бэлтгэх, өсвөрийн шигшээ багийн зохион байгуулалтыг сайжруулж тамирчдын амжилтыг бүс, улс, олон улс, тив дэлхийн хэмжээнд хүргэх</b>							
28	Өсвөрийн шигшээ багийг жүдо бөх, чөлөөт бөх, шатар, таеквондо, хүндийн өргөлт, хөнгөн атлетик, цана, волейбол, сагсан бөмбөг, теннисний спортын төрлүүдээр байгуулна.	63,6 сая төгрөг	Шигшээ багийн тоо	2021	3	1	Хүүхэд, залуучуудын авьяас чадварыг нээн хөгжүүлж, мэргэжлийн спортыг сурталчлан дэмжих, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлэх зорилгоор залуучууд, өсвөрийн тамирчдыг бэлтгэж 2021 онд өсвөр үеийн үндэсний бөх, чөлөөт бөх, жүдо бөх, пауэрлифтингийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 28 тамирчин оролцож 11 медаль хүртсэн. Энэ онд 24 удаагийн тэмцээнд нийт 114 тамирчин оролцож 21 алт, 51 мөнгө, 73 хүрэл нийт 145 медаль хүртсэн байна. Тус тэмцээн уралдаанд оролцсон баг тамирчид, дасгалжуулагч нарт нийт 27,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Волейболын насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг Арвайхээр суманд зохион байгуулж, тэмцээнд 30 багийн 308 тамирчин оролцсон. Хайрхандулаан суманд Монгол Улсын

							хөдөлмөрийн баатар, гавьяат дасгалжуулагч Ч.Насантогтохын санаачилгаар самбо, жүдо бөхийн дасгалжуулагчийн орон тооны асуудлыг шийдэж, шаардлагатай хэрэглэл материалаар хангаад байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
29	Үндэсний болон багийн спортын олон улсын жишигт нийцсэн зуны спортын цэнгэлдэх хүрээлэн, талбай байгуулах ажлыг эхлүүлнэ.	599,0 сая төгрөг	Талбайн тоо	2021	-	1	Арвайхээр сумын наадмын талбайг орон нутгийн хөгжлийн сангийн 500,0 сая төгрөгийн хөрөнгөөр засварлан, орон нутгийн 50,0 сая төгрөгөөр үндэсний сурын талбайг шинэчлэн барьж ашиглалтад оруулсан. Нарийнтээл суманд орон нутгийн хөгжлийн сангийн 59,0 сая төгрөгийн хөрөнгөөр наадмын талбай байгуулсан байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
30	Гавьяат тамирчдын нэрэмжит тэмцээнийг зохион байгуулна.	20,0 сая	Тэмцээний тоо	2021	-	2	Улсын цолтой харваачдад хүндэтгэл үзүүлэх, Монгол улсын Дархан мэргэн Л.Бадарчийн нэрэмжит шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 50 багийн 400 харваач оролцож, цэц мэргэнээ сорьж, уралдаанд оролцсон баг тамирчдад 6,2 сая төгрөг, Шатрын спортын Их мастер Г.Мөнхгалын нэрэмжит "Өвөрхангай-2022" тэмцээнд шатрын 12 клубийн 300 тамирчин оролцож, тэмцээн зохион байгуулахад 19,0 сая төгрөгийг тус тус зарцуулсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
31	Биеийн тамир, спортын ордны дотор засвар хийнэ.	-	Засвар хийгдсэн эсэх	2021	-	Засвар хийгдсэн байна.	Биеийн тамир, спортын ордны дотор засварыг хийх хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй байгаа тул хэрэгжээгүй. Байгууллагын хөрөнгөөр спортын ордны дээврийг 2,5 сая төгрөгөөр сэргээн будаж засварласан. <b>Хэрэгжилт-30 хувь</b>

**БОЛОВСРОЛ**

**Зорилт 1.9. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

32	Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд 320 хүүхдийн хичээлийн байрын өргөтгөл, Хужирт суманд 320 хүүхдийн хүчин чадалтай спорт заал бүхий сургуулийн барилгыг шинээр барьж эхлүүлнэ.	14,8 тэрбум төгрөг	Баригдаж эхэлсэн барилгын тоо, гүйцэтгэлийн хувиар	2021	3	2 барилгыг 50 хувь	Улсын төсвийн 6,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр суманд 320 хүүхдийн хүчин чадалтай ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэл 45 хувь, улсын төсвийн 7,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хужирт сумын 320 хүүхдийн хүчин чадалтай урлаг заал, спорт заал бүхий сургуулийн барилгын ажил 40 хувийн гүйцэтгэлтэй тус тус явагдаж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
33	Арвайхээр суманд 150 хүүхдийн цэцэрлэг, тус сумын 11 дүгээр тусгай цэцэрлэгт шинэ барилгын	3,2 тэрбум төгрөг	Баригдаж эхэлсэн барилгын тоо, гүйцэтгэлийн	2021	0	5 барилгыг 50-10 хувь	Арвайхээр суманд улсын төсвийн 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлж, гүйцэтгэл 30 хувь, улсын төсвийн 391.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянгол сумын 50 ортой хүүхдийн

	ажлыг эхлүүлэх, Баянгол, Хайрхандулаан, Хархорин сумдад 50 ортой урлаг заал бүхий цэцэрлэгийн барилгын өргөтгөл барина.		хувиар				цэцэрлэгийн барилгын гүйцэтгэл 70 хувь, улсын төсвийн 393,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хархорин сумын 50 ортой хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл, гүйцэтгэл 90 хувь, улсын төсвийн 249,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хужирт суманд урлаг заал бүхий 50 ортой хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл, барилгын гүйцэтгэл 75, улсын төсвийн 400,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хайрхандулаан суманд 50 ортой хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл, гүйцэтгэл 50 хувьтай тус тус явагдаж байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
34	Арвайхээр сумын ерөнхий боловсролын Тэмүүлэл-Эрдэм, Хархорин сумын ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулиудад спорт заал, Уянга сумын 1 дүгээр сургуульд урлаг заал, номын сан бүхий өргөтгөлийн барилгыг барьж эхлүүлнэ.	5,6 тэрбум төгрөг	Урлаг болон спорт заалны барилгын тоо, гүйцэтгэлийн хувиар	2021	Спорт заал 3, Урлаг заал 1	спорт заал 3, урлаг заал 1	Улсын төсвийн 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр сумын ерөнхий боловсролын Тэмүүлэл-Эрдэм сургуулийн спорт заалны барилга, гүйцэтгэл 50 хувь, улсын төсвийн 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хархорин сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн спорт заал гүйцэтгэл 35 хувь, 2 дугаар сургуулийн спорт заал гүйцэтгэл 30 хувь, улсын төсвийн 2,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Уянга сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн урлаг заал, номын сан бүхий өргөтгөл, гүйцэтгэл 15 хувьтай явагдаж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
35	Нарийнтээл сумын ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын талбайн шинэчлэл, засвар хийх.	500,0 сая төгрөг	барилгын ажлын гүйцэтгэлийн хувиар	2021	0	100 хувь	Улсын төсвийн 500,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Нарийнтээл сумын ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын гаднах талбайн шинэчлэлийн ажлын гүйцэтгэл 70 хувьтай явагдаж байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
36	Зарим сумдын сургууль, цэцэрлэгт мах, ногооны зориулалтын хөргүүр бүхий агуулах, зоорь барина.	-	мах, ногооны зориулалтын хөргүүр бүхий агуулах, зоорьтой болсон байгууллагын тоогоор	2021	4	3	Хархорин сумын 2 дугаар сургуульд Тайваны гэр бүл хөгжлийн сангаас хэрэгжүүлж буй "Эрүүл хүнс-Эрүүл ирээдүй" төслийн хүрээнд 22,0 сая төгрөгийн санхүүжилтээр хүлэмж, хүнсний агуулах, Сант сумын ерөнхий боловсролын сургууль орон нутгийн 12,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хүнсний агуулахын зоорь, Арвайхээр сумын 1 дүгээр сургуульд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хүнсний агуулах барьж тус тус ашиглалтад бүрэн оруулсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
37	Бат-Өлзий сумын 440, Уянга сумын Жаргалант багийн 120, Өлзийт сумын 240, Хархорин сумын 2 дугаар сургуулийн дотуур байр, Арвайхээр сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн номын	8,6 тэрбум төгрөг	Барилга угсралтын гүйцэтгэлийн хувиар	2021	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 15 хувь	100 хувь	Улсын төсвийн 4,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Бат-Өлзий сумын 440 хүүхдийн сургуулийн барилга гүйцэтгэл 70 хувьтай, улсын төсвийн 1,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хархорин сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 100 ортой хүүхдийн дотуур байрын барилга, гүйцэтгэл 50 хувьтай, улсын төсвийн 1,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн урлаг заал, номын сан бүхий өргөтгөлийн барилга гүйцэтгэл 85 хувьтай, улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өлзийт сумын ерөнхий боловсролын

	сан, урлаг заалны өргөтгөл, Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгуудыг дуусгаж, ашиглалтад оруулна.						240 хүүхдийн бага сургуулийн барилга ашиглалтад орж, улсын төсвийн 997,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Уянга сумын Жаргалант багийн 120 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэл 20 хувьтай, улсын төсвийн 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэл 35 хувьтай тус тус явагдаж байна. <b>Хэрэгжилт-100хувь</b>
38	Баян-Өндөр, Нарийнтээл, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан Бүрд сумдын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг дотуур байрын ариун цэврийн байгууламжуудыг ашиглалтад оруулна.	-	Ашиглалтад орсон ариун цэврийн байгууламжийн тоогоор	2021	2	5	Эрдэнэт ТӨҮГ-ын 100.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа бага оврын ариун цэврийн цэвэршүүлэх байгууламжийн төсөл Баян-Өндөр, Есөнзүйл, Бүрд, Нарийнтээл, Хужирт сумдын ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн 5 байр, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 6 байр, 7 дотуур байранд хэрэгжиж барилгын ажил 30-95 хувьтай байна. Дээрх төслийн хүрээнд Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Сант, Төгрөг, Баянтээг, Уянга, Бат-Өлзий, Баруунбаян-Улаан, Өлзийт сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байранд шинээр ариун цэврийн байгууламжийг байгуулах төслийн саналыг барилга хөгжлийн төв Боловсрол, шинжлэх ухааны яаманд тус тус хүргүүлэн шийдвэрлэх шатандаа байна. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
<b>Зорилт 1.10. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын сургалтын болон үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор дараах барилгуудад их засвар хийнэ.</b>							
39	Арвайхээр сумын 1, Хужирт сумын сургуулийн сантехникийн засвар, Зүүнбаян-Улаан сумын цэцэрлэгийн дээвэр, Уянга сумын 1, Хархорин сумын 2, Төгрөг, сумдын ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрын их засварыг хийнэ. Хужирт, Баруунбаян-Улаан, Нарийнтээл сумын Баянтээг, Хайрхандулаан зэрэг сумдын ерөнхий боловсролын сургуулиудын гал тогоог засварлана.	-	Их засварын гүйцэтгэл, гал тогооны тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн хувиар	2021	20	6 сургуулийн барилгад их засвар хийгдэж, 5 сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлсэн байна.	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар боловсролын салбарын их засварт нийт 350,0 сая төгрөг зарцуулагдаж, Баян-Өндөр, Гучин-Ус, Уянга, Зүүнбаян-Улаан, Төгрөг сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрын дээврийн их засвар, Бат-Өлзий сумын ерөнхий боловсролын сургуулийн спорт заал, Есөнзүйл сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын их засварууд хийгдсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн 6,0 сая төгрөгийн хөрөнгөөр Нарийнтээл сумын ерөнхий боловсролын сургууль, 15,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баруунбаян-Улаан сумын ерөнхий боловсролын сургуулиудын гал тогоог засварлаж, Хужирт сумын ерөнхий боловсролын сургуулийн гал тогоог 250,0 сая төгрөгөөр, Баянтээг багийн сургуулийн гал тогоог 42,8 сая төгрөгөөр засварлахаар ажлын зураг төсвийг боловсруулаад байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
40	Бат-Өлзий, Уянга, Баруунбаян-Улаан,	-	Ариун цэврийн	2021	5/100 хувь	7 /100 хувь	Бат-Өлзий, Уянга, Баруунбаян-Улаан, Төгрөг, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Сант, Баянтээг, Өлзийт сумдын сургууль, цэцэрлэг, дотуур

	Тарагт, Төгрөг, Гучин-Ус сумдын сургууль, цэцэрлэгийг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгоно.		байгууламжтай болсон байгууллагын тоо, Ажлын гүйцэтгэлийн хувиар				байранд шинээр ариун цэврийн байгууламж байгуулах төслийн саналыг Барилга хөгжлийн төв, Боловсрол, шинжлэх ухааны яаманд тус тус хүргүүлснээр 3 дугаар ээлжинд дээрх сумдаас 7 сумын сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж баригдахаар техник эдийн засгийн судалгаа хийгдэж байна. <b>Хэрэгжилт -0</b>
41	Есөнзүйл сумын хичээлийн байрын дотор засвар, Хархорин сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрын дээвэр, Арвайхээр сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны душийг засварлана.	-	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2021	3	3	Улс, орон нутгийн төсвийн 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Есөнзүйл сумын ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрын дотор засвар, Хархорин сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрын дээврийг тус тус засварласан. Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрын душийг засварлуулахаар 2023 оны хөрөнгө оруулалтад санал хүргүүлээд байна. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
42	Сургууль, цэцэрлэгийн материаллаг болон нийгэм сэтгэл зүйн орчны эрсдэлийн үнэлгээг улирал бүр хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулна.	-	Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан байгууллагын эзлэх хувиар	2021	50 хувь	80 хувь	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлыг хүрээний агентлаг Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газрууд хамтран "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчны болон нийгэм сэтгэл зүйн орчны эрсдэлийг бууруулах сарын аян"-ыг зохион байгуулж, сургууль, цэцэрлэг бүр орчны болон сэтгэл зүйн 3-аас доошгүй эрсдэлийг илрүүлж, хариу арга хэмжээ авч ажилласан. Боловсролын байгууллагууд улирал тутам дотоод хяналт шалгалтыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, тайланг Мэргэжлийн хяналтын газарт тухай бүр хүргүүлж, зөрчлийг бууруулахад хамтран ажиллаж байна. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Сэтгэц наркологийн тасаг, Боловсрол, шинжлэх ухааны газар хамтран "Хүүхдийн ертөнцийг ойлгоё" аяныг зохион байгуулж, аймгийн 32 ерөнхий боловсролын сургуулиас 30 ерөнхий боловсролын сургуулийн эмч, нийгмийн ажилтан, багшийн төлөөлөл нийт 90 гаруй хүнийг судалгааны арга зүйд сургаж, Зүүнбаян-Улаан, Уянга, Хужирт сумдад ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчдийг ажиллуулж, цахимаар болон утсаар зөвлөгөө өгөх зэргээр боловсролын салбарын эрсдэлийн түвшин бууруулах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
<b>Зорилт 1.11. Боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.</b>							
43	Баруунбаян-Улаан, Баянгол, Баян-Өндөр, Өлзийт, Уянга сумын Жаргалант багийн сургууль "Физик", Гучин-Ус, Есөнзүйл, Уянга	134,0 сая төгрөг	Кабинетийн тоног төхөөрөмжтэй болсон сургуулийн тоогоор	2021	10	15	Улсын төсвийн нийт 176,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумдын ерөнхий боловсролын 15 сургуульд хими, физик, технологи, англи хэлний кабинетийг тоног төхөөрөмжөөр хангаж, сурагчид зориулалтын хэрэглэгдэхүүн, ширээ, сандал ашиглан хичээл, сургалтын үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдээд байна.

	сумын Жаргалант багийн сургууль, Хайрхандулаан, Хархорин сумын Номын хүрдэн сургуулиуд “Хими”-ийн, Бат-Өлзий сумын ерөнхий боловсролын сургууль технологийн кабинет, Есөнзүйл сумын Ерөнхий боловсролын сургуулийг англи хэлний кабинетын тоног төхөөрөмжөөр хангана.						<b>Хэрэгжилт-100 хувь</b>
44	Төгрөг, Баруунбаян-Улаан, Хархорин сумын 1, Арвайхээр сумын 1, Уянга сумын Жаргалант багийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, Арвайхээр 4 дүгээр сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжөөр хангана.	66,0 сая төгрөг	Гал тогооны тоног төхөөрөмжөөр хангагдсан сургуулийн тоогоор	2021	20	5 сургууль, 1 дотуур байрыг гал тогооны тоног төхөөрөмжөөр хангана.	Улсын төсвийн 64,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын 5 сургууль, 1 дотуур байрын гал тогоонд тоног төхөөрөмж нийлүүлснээр ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын 95 хувь нь гал тогооны тоног төхөөрөмжтэй болоод байна. Ингэснээр сургуулийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хүчин чадал сайжирч, дотуур байрын сурагчдын болон бага ангийн сурагчдын үдийн хоолны чанар хүртээмж нэмэгдэх, тогооч, туслах ажилтнуудын ажлын ачаалал багасах нөхцөл бүрдэж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
45	Богд, Хайрхандулаан, Есөнзүйл, Хужирт, Өлзийт, Баруунбаян-Улаан, Баянгол, Бүрд сумдын, Хархорин сумын 1 дүгээр сургууль, Номын хүрдэн сургууль, Арвайхээр сумын 1 дүгээр сургуулиудын дотуур байруудын хяналтын камерын тоог нэмэгдүүлэх, сайжруулж, шинэчилнэ.	50,0 сая төгрөг	Хяналтын камераар хангагдсан байгууллагын тоогоор	2021	20	11	Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Хужирт сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, Өлзийт, Баруунбаян-Улаан, Есөнзүйл сумдын сургууль, дотуур байруудын хяналтын камерыг улсын төсвийн 8,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинэчилснээр боловсролын салбарын камержуулалт бүрэн хийгдсэн. Камерын шинэчлэл засварыг тасралтгүй хийхэд анхаарч Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2021 оны А/31 дүгээр тушаалаар батлагдсан “Боловсролын байгууллагуудын камер ашиглалтын журам”-ыг боловсруулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Камерын хяналтыг тогтмол хийснээр сургууль, цэцэрлэг, дотуур байрын орчинд хүүхэд аливаа эрсдэлд өртөх, ямар нэгэн зөрчил дутагдлыг илрүүлэх, хариу арга хэмжээ авч, урьдчилан сэргийлэх нөхцөл боломж бүрдсэн. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
46	Японы хүүхдийг ивээх сангийн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь	50,0 сая төгрөг	Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн	2021	70-90	100	Японы хүүхдийг ивээх сангийн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн зорилтот 8 сургуулийн хэмжээнд бичил төсөл шалгаруулах уралдааныг 2 үе

	хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөл, “Монгол улсад хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах” 2 дугаар шатны төслүүдийг хэрэгжүүлнэ.		хувиар				шаттай зохион байгуулж, нийт 17 төсөл шалгаран 47,6 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна. ESEL буюу өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар энтрепренершип боловсрол олгох сургалтын хөтөлбөрт нийт 857 хүүхэд хамрагдаж байна. “Монгол улсад хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах” төслийн 2 дугаар шат хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дунд ангид шилжин суралцахад дэмжлэг үзүүлэх, багш нарыг арга зүйн дэмжлэгээр хангах, эцэг эхийн ойлголт хандлага, орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, Уянга сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль дээр тус тус хэрэгжиж байна. Төслийн хүрээнд давхардсан тоогоор 6666 багш, ажилтан, эцэг эхийг сургалтад хамруулж, Арвайхээр сумын 2 дугаар сургуульд төслийн 7,2 сая төгрөгийн санхүүжилтээр Хүүхэд хөгжлийн танхим байгуулагдлаа. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
47	Сургууль, цэцэрлэгүүдэд туслах аж ахуй, хүлэмжийн аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлж, зарим сургуульд хоол үйлдвэрлэлийн технологич, хоол зүйчийг орон тоогоор ажиллуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	-	Хүлэмжтэй болсон байгууллага, хоол зүйчийн тоогоор	2021	3/2	3 хоол зүйчтэй болсон байна.	Арвайхээр сумын 5 дугаар сургууль, Хархорин сумын 2 дугаар сургууль, Төгрөг сумын ерөнхий боловсролын сургууль, Арвайхээр сумын 3 дугаар цэцэрлэгт тус тус “Өрхийн тариалалт бизнес хөгжил” ТББ-ын “Эрүүл хүнс эрүүл ирээдүй” төслийн санхүүжилтээр хүлэмж баригдаж, өргөст хэмх, улаан лооль, сургуулийн талбайд төмс, байцай, шар манжин, улаан манжин, лууван, бөөрөнхий сонгино, урт сонгино зэрэг хүнсний ногоо тариалан, ургацыг бүрэн хураан авч сургуулийн үдийн хоол, цэцэрлэгийн хүүхдийн хоолонд нийлүүлж байна. Арвайхээр сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль Зүүнбаян-Улаан сумын нутагт багш ажилчдынхаа хэрэгцээнд зориулж төмс хүнсний ногоо, Хайрхандулаан сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид орон нутагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн хүлэмжид өргөст хэмх, шийгуа, улаан лооль, чинжүү, гүзээлзгэнэ тариалж, хураан авсан байна. Арвайхээр сумын 5 дугаар сургууль орон тооны хоол зүйчийг ажиллуулж байгаа бөгөөд Хархорин сумын 2 дугаар сургууль, Мэргэд сургуулиуд хоол зүйчийг хөрвүүлэн бэлтгэж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>Зорилт 1.12. Боловсролын үйлчилгээг чанартай зохион байгуулж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.</b>							
48	Багш, удирдах ажилтны ажлын арга барил, үйл ажиллагааны үр дүн, ур чадварын түвшин тогтоох, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор багш, удирдах	-	Үнэлгээний түвшингээр урамшуулал авах багшийн эзлэх хувиар	2021	0	40-өөс дээш хувь нь урамшуулал авсан байна.	Боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас "Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, урамшуулах олгох аргачлал"-ыг баталсны дагуу Боловсролын үнэлгээний төвтэй хамтран 31 сургуулийн 1247 багшийн сургалт үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээг суралцагчийн сурах үйл ажиллагааны үр дүнгийн ахиц, суралцагчийн хөгжил хамгаалал төлөвшил, багшийн мэргэжлийн хөгжил, сургууль

	ажилтныг аттестатчилах ажлыг үе шаттай зохион байгуулна.						ба олон нийтийн үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэр гэсэн 4 багц 13 шалгуур үзүүлэлтээр үнэлэв. Үнэлгээний дүнгээр 1 дүгээр түвшинд 37 багш буюу 2,97 хувь, 2 дугаар түвшинд 121 багш буюу 9,7 хувь, 3 дугаар түвшинд 138 багш буюу 11,07 хувь, 4 дүгээр түвшинд 205 багш буюу 16,44 хувь, 4-5 дугаар түвшинд 746 багш буюу 59,82 хувьтай тус тус үнэлэгдэж, 501 багшид буюу 40,18 хувьд багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан үр дүнгийн 10-25 хувийн урамшуулал 419698,2 сая төгрөг олгоод байна. Үнэлгээгээр 4 болон 5 дугаар түвшинд үнэлэгдсэн багш нарыг чадавхжуулах, дараагийн үнэлгээг ахиулахад нь дэмжлэг үзүүлэхээр Боловсролын ерөнхий газраас Модул сургалтын хөтөлбөр боловсруулагдан гарсан бөгөөд тус хөтөлбөрийн заавал болон сонгох агуулгаас сонгон судалж, мэргэжил арга зүйн чадамжаа нэмэгдүүлэх боломжтой болоод байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
49	Хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах санаачилгыг дэмжин ажиллана.	-	Хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байдлаар	2021	0	Хувийн хэвшлийн цэцэрлэгүүдэд үйл ажиллагааны дэмжлэг үзүүлсэн байна.	Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн 4 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, нийт 165 хүүхэд хамрагдаж байна. Тус цэцэрлэгүүдийн багш удирдах ажилтнуудыг орон нутгаас зохион байгуулж буй аливаа сургалт, зөвлөгөөн, уралдаан тэмцээнд хамруулж, арга зүй, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох чиглэлээр дэмжин ажиллаж байна. Одоогоор нэмж хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг байгуулах санал хүсэлт иргэдээс ирээгүй байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
50	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдол нөхөх арилгах цогц төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн ахицаар	2021	-	Танхимын болон танхимын бус сургалтыг тасралтгүй зохион байгуулсан байна. Сурагчдыг сургуулиас хөндийрэх, сургууль завсардалтгүй тэгш хамруулан сургана	Энэ оны хичээлийн жилд цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургууль, цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж, Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/292, А/525 дугаар тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар (ковид-19)-ын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ыг хэрэгжүүлж, 31 сургууль, 44 цэцэрлэг шинэ хичээлийн жилийг бүрэн эхлүүлсэн. Ковидын үеийн хичээл сургалтын хоцрогдлыг үнэлэхээр 2021 оны 4 дүгээр улиралд улсын хэмжээнд оношлох үнэлгээ, 2022 оны 1 дүгээр улиралд сургуульд суурилсан өөрийн үнэлгээг хийж, сурагчдын гүйцэтгэл улсын хэмжээгээр 41, аймгийн сурагчдын гүйцэтгэл 49 хувьтай үнэлэгдэж, сургууль бүр хоцрогдлыг нөхөх, арилгах, ахиц амжилтыг тооцох, сурагчдыг бие дааж сурах арга барил эзэмшүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна. Сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх арилгах цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж буй сайн туршлага солилцох, багш нарын заах арга, ур чадварыг нэмэгдүүлэх, харилцан суралцахаар 6 бүсийн хэмжээнд



							“Сайн туршлага үйл ажиллагаа”-ны зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалт зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 600 гаруй багш хамрагдсан байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
51	Боловсролын чанарын шинэчлэл төслийн сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шатыг хэрэгжүүлнэ.	162,5 сая төгрөг	Төслийн хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнгээр	2021	20 сургууль	23 сургууль	Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шатанд нийт 23 төслийн санал дэмжигдэж, хэрэгжилт 92,6 хувьтай байна. Төслийн хүрээнд Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Монгол Улсын Боловсролын Их сургууль, “Суралцахуйн баясгалан” төвтэй хамтран бага боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, багшийн хөгжлийг дэмжих, мэдээллийн технологийг ашиглан сурлагын хоцрогдлыг бууруулах, интерактив хэрэглэгдэхүүн бэлтгэх, цахим хичээл бэлтгэх зэрэг сургалтыг зохион байгуулж, бага боловсролын 34 сургалтын менежер, 428 багш 100 хувь хамрагдсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
52	Анги нийтийн аймгийн олимпиадыг зохион байгуулна.	4,0 сая төгрөг	Олимпиад зохион байгуулсан эсэх	2021	-	Анги нийтийн олимпиадыг зохион байгуулсан байна.	Монгол хэл, математик, түүх нийгмийн ухаан, гадаад хэл 4 судлагдахуунаар 2 үе шаттай анги нийтийн олимпиадыг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулиуд 100 хувь хамрагдсан байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>Зорилт 1.13. Сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос бичигтэн, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлнэ.</b>							
53	Монгол бичигт суралцах бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлж, хос бичигтэн аяны 2 дугаар шатыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	-	үндэсний бичгийн сургалтад хамрагдсан төрийн байгууллага, албан хаагчийн тоогоор	2021	41/1386	60/1500	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агетлаг Боловсрол, шинжлэх ухааны газар, Соёл урлагийн газар, Хэлний бодлогын салбар зөвлөл, аймгийн төв номын сантай хамтран “Хичээнгүй бичигтэн”, “Хурдан зөв уншигч”, “Алдаагүй зөв бичигтэн”, “Цахим монгол бичиг”, “Уран бичвэр”-ийн уралдааныг зохион байгуулж, 18 сумаас шалгарсан 90 гаруй сурагч, насанд хүрэгчид оролцсон. Мөн Хэлний бодлогын салбар зөвлөлөөс 2021 онд монгол бичгийн орчин бүрдүүлж, монгол бичиг сургах сургалтыг зохион байгуулж, манлайлсан аймгийн тэргүүний салбар зөвлөл, байгууллага, төрийн албан хаагч, багш нарыг шалгаруулж, батламж, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. “Үндэсний бичиг-Өв соёл” аяныг зохион байгуулж, төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулж, 62 байгууллагын 1528 албан хаагч хамрагдсан байна. Мөн Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Архивын ерөнхий газар, аймгийн Архивын тасагтай хамтран сумдын Засаг даргын Тамгын газар, албан байгууллагуудын Архив, бичиг хэргийн 170 гаруй ажилтанд монгол бичгээр хэвлэмэл хуудас дээр хэрхэн бичиж, хэвлэх сургалтыг зохион байгууллаа. <b>Хэрэгжилт-100 хувь</b>

54	Аймаг байгуулагдсан өдрийг угтан ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Миний Өвөрхангай” сарын аяныг зохион байгуулна.	5,0 сая төгрөг	Аян зохион байгуулагдсан эсэх, хамрагдсан сургуулийн тоо	2021	31	31	<p>Хүүхэд, багачуудыг төрөлх аймаг, сум орон нутгийнхаа түүх, соёл, өв уламжлал, бахархалт хүмүүсийн түүхэн замнал, байгалийн болон соёлын дурсгалт газруудыг судлан мэдүүлж, нутаг усаа хайрлан хамгаалах, уламжлалт ёс заншлаа хүндлэн дээдэлдэг иргэн болгон төлөвшүүлэхээр 1 дүгээр сарын 18-наас 2 дугаар сарын 18-ны өдрүүдэд “Миний Өвөрхангай” сарын аяныг зохион байгуулж, 1000 гаруй багш, сурагч идэвхтэй оролцож, шинэ бүтээлийн уралдаанд 100 гаруй бүтээл, үйл ажиллагаа, хэрэглэгдэхүүний уралдаанд 400 гаруй бүтээлээр оролцсоныг /<a href="http://uv.edu.mn">http://uv.edu.mn</a> сайтад “Өвөрхангайн магтаалыг хэн сайн дуулах вэ?” уралдааны бүтээлүүдийн хамтаар “Миний Өвөрхангай” цэс үүсгэн байршуулж, олон нийтийн хүртээл болгоод байна.</p> <p>Аймаг байгуулагдсан өдрийг тохиолдуулан аймгийн Засаг дарга тусгай хөтөлбөрийн дагуу, ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан 866 багш нэгдсэн төлөвлөгөөт хөтөлбөрөөр хичээл зааж бүх сурагч хамрагдлаа. Тухайлбал 1 дүгээр анги “Өвөрхангайн магтаал”, 3 дугаар анги “Авзага хайрхан уулын домог”, 12 дугаар анги “Өвөрхангай аймгийн соёлын өв” гэх мэтээр анги бүрт өөр өөр сэдвүүдийг нэгдсэн хөтөлбөрийн дагуу заасан.</p> <p><b>Хэрэгжилт-100 хувь</b></p>
55	Хүүхдийн зуны амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэх, тэднийг хөдөлмөрт сургах, хамтарч ажиллах чадвар эзэмшүүлэх зорилгоор “Хөдөлмөр зуслан” төслийг үргэлжлүүлнэ.	-	хөдөлмөр зуслан ажиллуулсан сургуулийн тоогоор	2021	3	5-аас дээш сургуульд Хөдөлмөр зуслан ажиллуулсан байна.	<p>Боловсрол, шинжлэх ухааны газраас Хөдөлмөр зуслан хүүхэд хөгжүүлэх хөтөлбөрийн удирдамжийг батлан хүргүүлсэн ба хөтөлбөрийг богино болон урт хугацааны зуслан, экскурс хичээл хэлбэрээр малчин, тариаланч, хот айл, бүлэг, нөхөрлөлийг түшиглэн сум, сургуулийн хэмжээнд анги хамт олон, баг, сонирхлын бүлгээр зохион байгуулах, Хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн агуулга, үйл ажиллагаа, сурагчдын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртэй холбож, хамтран хэрэгжүүлэх чиглэлийг хүргүүлснээр Уянга сумын ерөнхий боловсролын 1, 2 дугаар, Богд сумын 1 дүгээр сургууль хөдөлмөр зусланг ажиллуулж, нийт 150 хүүхэд хамрагдан, зуны амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлж, хөдөлмөрт сурган, хамтарч ажиллах чадвар эзэмшүүлсэн байна.</p> <p><b>Хэрэгжилт-70 хувь</b></p>
56	Олон улсын “XREADING” цахим номын сан турших хөтөлбөрийг хэрэгжүүлж, унших үйлээр дамжуулан багш, сурагчдын англи хэлний хэрэглээг нэмэгдүүлж, англи хэлний сургалтын чанарт	7,2 сая төгрөг (сурагч тус бүрт 30 хувийн төлбөрийн	Хамрагдсан сургууль, багш, сурагчдын тоогоор	2021	15/15/184	16/35/400	<p>Лингорс компанитай хамтран “XREADING “Англи хэлний цахим номын сангийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр”-т нийцүүлсэн хөтөлбөрийн туршилтад 16 сургуулийн 35 багш, давхардсан тоогоор 428 сурагч амжилттай хамрагдаж англи хэлний мэдлэг, унших чадвараа сайжруулсан.</p> <p>Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд зарлагдсан 2 удаагийн улсын уралдаанд манай аймгийн 4 багш, 12 сурагч үндэсний шилдгээр шалгарсан байна.</p>

	ахиц гаргана.	дэмжлэг үзүүлнэ)					<b>Хэрэгжилт-100 хувь</b>
57	Хүүхдийн хүмүүжил, төлөвшилд эцэг эх, дотуур байрын багшийн оролцоо, арга зүйг нэмэгдүүлэх, хүүхдийн цахим хэрэглээг гэр бүл, дотуур байрын орчинд хязгаарлах, номоор дамжуулж хүмүүжүүлэх чиглэлээр “Аав, ээжтэйгээ уншигч”, “Бүтээлч уншигч” соёл, нөлөөллийн аян зохион байгуулна.	3,0 сая төгрөг	Сургуулийн номын сангийн уншигчийн эзлэх хувиар	2021	20	33,5	<p>Хүүхэд багачуудыг номоор дамжуулж хүмүүжүүлэх чиглэлээр “Аав, ээжтэйгээ уншигч”, “Бүтээлч уншигч” сэдэвт соёл, нөлөөллийн аян зохион байгуулж тус аянд 31 сургуулийн нийт 500 гаруй эцэг эх, 3200 гаруй сурагч хамрагджээ. Аяны үр дүнд номын сангийн уншигчдын тоо 13,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Арвайхээр, Хужирт, Хархорин сумдад өсвөр үе, хүүхэд залуучуудыг хөгжүүлэх, амьдрах ухааны боловсрол олгох зорилго бүхий “Амьдрах ухааны танхим”-ыг тохижуулж, бүх ерөнхий боловсролын нийгмийн ажилтан тухайн сургуулийн удирдлагуудад Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбооноос “Арт терапи”-ийн талаар ойлголт өгч, амьдрах ухааны 12 модуль сургалт зохион байгуулсан.</p> <p>Дотуур байранд болон сургуулийн орчинд сурагчдыг чөлөөт цагаараа ном унших, уншсан номынхоо утга агуулгаар хэлэлцүүлэг өрнүүлэх, ном солилцоо арга хэмжээ, номын булан байгуулах, сумынхаа номын сантай хамтарсан зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан номтой нөхөрлүүлэхэд анхаарч бүтээлч ажлуудыг санаачлан хэрэгжүүлсэн. Тухайлбал Бат-Өлзий сумын ерөнхий боловсролын сургуулийн багш нар “Номтой нөхөрлөө” цогц арга хэмжээг төлөвлөн 3 жилийн хугацаанд хэрэгжүүлж, тус арга хэмжээний үр дүнг судалгааны бүтээл болгон боловсруулж, улмаар 2022 оны эрдэм шинжилгээний бүтээлийн улсын уралдаанд оролцож дэд байр эзэлсэн амжилтыг үзүүллээ. Мөн Арвайхээрийн 1, 4, Мэргэд, Тэмүүлэл-Эрдэм, Хархорин, Уянга, Хайрхандулаан, Баян-Өндөр, Жаргалант, Сант зэрэг сумдын сургуулиуд сургууль, дотуур байрын орчинд ном унших орчин нөхцөлийг шинээр бүрдүүлж өгсөн байна.</p> <p><b>Хэрэгжилт-90 хувь</b></p>
58	“Хүүхэд бүрийг оролцуулъя” зорилтот аяныг өрнүүлж ерөнхий боловсролын сургууль дээрх Хүүхдийн өөрөө удирдах байгууллага, клубын үйл ажиллагааг дэмжих, өсвөрийн сургагч багш нарыг бэлтгэх, тэднээр дамжуулан үе тэнгийнхэнд нь нөлөөлөх	5,0 сая төгрөг	ХӨУБ-ийн чиглэл, бэлтгэгдсэн сурагч багшийн тоогоор	2021	2/290	5/1000	<p>“Хүүхэд бүрийг оролцуулъя аян”-ны аймгийн нэгдсэн төлөвлөгөөг нийт сургуулиудад хүргүүлж, сургууль дээрх Хүүхдийн өөрөө удирдах байгууллага, клубыг идэвхжүүлэн холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллав.</p> <p>Монголын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран Охидын зөвлөлийн 135 гишүүдийг, Цагдаагийн газартай хамтран “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн 84 хүүхдийг чадавхжуулж, үе тэнгийн сургагч багшаар бэлтгээд байна.</p> <p>Лидер сурагч академи, Залуусын элч төрийн бус байгууллагатай хамтран "Оюуны давлагаа-VI" уран илтгэлийн аймгийн аварга шалгаруулах, туршлага солилцох тэмцээнийг зохион байгуулж, ерөнхий боловсролын 12 сургууль, Политехник коллежийн 52 сурагч</p>

	ажлыг хэрэгжүүлж, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлнэ.						оролцсон. Дэлхийн хүүхдийн номын өдрийг тохиолдуулан Соёл, урлагийн газар, Төв номын сантай хамтран сургуулийн номын сан, "Номын клуб"-ын үйл ажиллагааг сурталчлах, номыг бүтээлчээр унших, тэмдэглэл хөтлөх сургалтад ерөнхий боловсролын 6 сургуулийн 74 сурагч, Дэлхийн хүмүүнлэгийн өдрийг тохиолдуулан аймгийн Улаанзагалмайн хорооноос зохион байгуулсан сургалт, өдөрлөгт "Өсвөрийн улаан загалмайчид", "Тусч клуб"-ын 120 гаруй сурагчид оролцож, анхны тусламж үзүүлэх сургалтад, Эрүүл мэндийн газар, Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн Өвөрхангай аймаг дахь салбартай хамтран нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр "Өсвөр үеийн үе тэнгийн сурагч" бэлтгэх сургалтад "Өсвөрийн эмч" бүлгэмийн 89 сурагч, Онцгой байдлын газар, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран "Өсвөрийн аврагч" аймгийн аварга шалгаруулах тэмцээн, чадавхжуулах сургалтад 450 орчим сурагчийг тус тус хамруулснаар нийт хүүхдийн өөрөө удирдах байгууллагын 7 чиглэлийн сургалтад 1004 сурагч хамрагдаж, сурагч багшаар бэлтгэгдсэн байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
59	Монгол орны нэн ховор амьтдыг бага насны хүүхдүүдэд танин мэдүүлэх, хайрлан хамгаалах үзэл төлөвшүүлэх чиглэлээр "Мазаалай баавгай" төсөлтэй хамтран ажиллана.	15,0 сая төгрөг	Хөрөнгө оруулалтын дүн, нэн ховор амьтдын талаар мэдээлэл авсан хүүхдийн тоогоор	2021	-	12000 хүүхэд	Орон нутгийн төсвийн 15,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Оюунлаг шүрт ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, Монгол орны нэн ховор амьтдыг бага насны хүүхдүүдэд танин мэдүүлэх, хайрлан хамгаалах үзэл төлөвшүүлэх агуулгыг багтаасан 5 төрлийн 12000 ширхэг зурагт ном, буддаг номыг хэвлүүлж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад сурч буй бүх хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн нийт хүүхдүүдэд олгож, тус номоор анги удирдсан багш нар хүүхдүүдэд сургалт зохион байгуулснаар Монгол орны нэн ховор амьтдыг хайрлан хамгаалах мэдлэгтэй болсон байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>Зорилт 1.14. Нээлттэй боловсролын тогтолцоог бий болгон цахим болон зайн сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэн, бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг цахим хэрэглээнд бүрэн шилжүүлж, бүх насны суралцагч, иргэдэд зориулсан цахим сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулан түгээнэ.</b>							
60	Нээлттэй, зайны болон онлайн сургалтын нөөцийн сан бүрдүүлж, сургалтын үйл ажиллагаанд ашиглах чиглэлээр сургуулийн удирдлага, багш нарыг чадавхжуулах	-	Сургалт зохион байгуулсан эсэх, хамрагдсан багшийн тоо	2021	1	30 хүртэл багш, удирдах ажилтныг хамруулсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны яамны Мэдээллийн технологийн газартай хамтран Шинэ зуун бүсийн сургуулийн багш, сургалтын менежерүүдэд "Ээлжит хичээлийн цахим контент боловсруулах арга зүй" сургалтыг танхимаар 29 сургуулийн 8 судлагдахууны 79 багшийг хамруулан зохион байгуулж, цахим контент боловсруулах арга зүйд суралцаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлээд байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
61	"Боловсролын удирдлага, мэдээллийн	-	Багшийн цахим журнал	2021	3 сургууль	20 сургууль	Энэ оны хичээлийн жилд Боловсролын мэдээллийн системийн "Багшийн цахим журнал"-ыг аймгийн ерөнхий боловсролын 32

	систем"-ийн мэдээллийг бодлого төлөвлөлтөд үр дүнтэй ашиглах, "Багшийн цахим журнал" хөтөлж хэвших		хөтөлж хэвшүүлсэн сургуулийн тоогоор				сургуулиас 31 нь хөтөлж, хэвшүүлээд байна. Тарагт сумын Туяа багийн ерөнхий боловсролын сургууль тог цахилгаан байхгүйн улмаас багшийн хэвлэмэл журнал хөтөлж байна.
<b>Хэрэгжилт-100 хувь</b>							
<b>Зорилт 1.15. Багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг олгох, тэдний нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд анхаарч ажиллана.</b>							
62	Багш нарын арга зүйн хөгжлийг дэмжих тэргүүн туршлага, ур чадварыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Багш, сурагч солилцоо"-ны арга хэмжээг хэрэгжүүлнэ.	3,0 сая төгрөг	үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгээр	2021	-	31 сургууль	Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн журамд заасан багш бүр 1-3 "Мэргэжлийн хөгжлийн бүлэг"-т заавал хамрагдаж, мэргэжил дээшлүүлэх ажилд оролцон, мэргэжил дээшлүүлэх оноогоо тогтмол цуглуулж, "Багшийн хөгжлийн зардал"-аас санхүүжих шинэ зарчмыг хэрэгжүүлж байна. Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн технологийн багш нар болон нисэх загвар сонирхон хичээллэдэг сурагчдын харилцан туршлага солилцох, бие биеэсээ суралцах, хамтран ажиллах сургалт, дадлагыг Баянхонгор аймагт зохион байгууллаа. Ерөнхий боловсролын 6 бүсийн сургуулиудын багш нарын арга туршлагыг харилцан солилцох хамтын үйл ажиллагааг бэхжүүлэхээр "Багш солилцоо" арга хэмжээг удирдамжийн хүрээнд үе шаттай зохион байгуулснаар 12 багш хамрагдаад байна.
<b>Хэрэгжилт-70 хувь</b>							
63	Арвайхээр, Хархорин, Бат-Өлзий, Уянга, Хужирт сумдын сургуулиудад сэтгэл зүйчийн орон тоог шийдвэрлэн, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	-	орон тооны сэтгэл зүйчтэй болсон сургуулийн тоогоор	2021	2	4	Арвайхээр сумын ерөнхий боловсролын 5 болон 1, Тэмүүлэл-Эрдэм, Хархорин сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулиуд дээр тус тус шинээр сэтгэл зүйчийг томилон ажиллуулснаар аймгийн хэмжээнд 6 сургуульд сэтгэл зүйч ажиллаж байна. Сэтгэл зүйч нарыг багш сурагчид, эцэг, эхчүүдтэй хэрхэн хамтарч ажиллах талаар болон тэдэнд сэтгэл зүйн зөвлөгөө авахын ач холбогдол, үр нөлөөллийг сурталчлан таниулах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч, сургалтад хамруулж, мөн сэтгэл зүйч нарын туршлага солилцох уулзалтыг сар бүр зохион байгуулж байна. Ингэснээр сэтгэл зүйчээс зөвлөгөө авах сурагч, эцэг, эх, асран хамгаалагч, багш ажилчдын тоо нэмэгдсэн үр дүн гарч байна.
<b>Хэрэгжилт-100 хувь</b>							
64	Хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, тэдэнтэй ажиллах арга зүйн зөвлөгөө, аргачлал" бүхий хүүхэд, эцэг эх, анги удирдсан багш, асран хамгаалагчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулан	15,0 сая төгрөг	Гарын авалга боловсруулсан эсэх	2021	0	1	Монгол улсын Зөвлөх зэрэгтэй 12 багшийн арга зүй туршлага, анги удирдах сайн туршлагын эмхэтгэлийг цахим хэлбэрээр боловсруулж, багш нарт хүргээд байна. Мөн тус гарын авлагын хүрээнд анги удирдсан багш нарын 3 бүлэг үүсгэн цахим ментор сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн 32 ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан 90 багш хамрагдлаа.
<b>Хэрэгжилт-50 хувь</b>							

	батлуулж хэрэгжүүлнэ.						
65	“Багш айлчлал” аргачлалыг батлуулж, хүүхдийн хөгжил хамгаалалд салбар дундын уялдаа холбоог сайжруулах.	3,8 сая	Аргачлал батлагдан хэрэгжүүлсэн эсэх	2021	-	“Багш айлчлал” аргачлалыг боловсруулан баталж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	“Багш айлчлал” аргачлалыг боловсруулах явцад Арвайхээр сумын ерөнхий боловсролын сургуулиудын бага, дунд, ахлах ангийн 24 багш, 11 сумын сургуулийн нийгмийн ажилтнуудаас санал авах фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулав. “Багш айлчлал” аргачлалыг баталж, аргачлалын апп-ыг хөгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 3,8 сая төгрөг зарцуулж, анги удирдсан багш нар хэрэгжүүлж эхлээд байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
66	Ерөнхий боловсролын сургуулийн 6,7 настай хүүхдийг дотуур байрын орчинд амьдрах, хичээлийн хоцрогдол арилгах, төлөвшүүлэх чиглэлээр ахмад багш нарын нөөцийг дайчлан хөгжүүлэх загвар гарган, зарим сумдад хэрэгжүүлнэ.	-	Ахмад багшийн тоогоор	2021	0	5	Аймгийн хэмжээнд сургуулийн дотуур байранд нийт 6 настай 52, 7 настай 87 сурагч амьдарч байна. Баруунбаян-Улаан, Хайрхандулаан, Бүрд, Уянга, Тарагт сумдын сургуульд өндөр насны тэтгэвэрт гарсан 6 ахмад багшийг ажиллуулж, 6-7 настай хүүхдийн сургуулийн дотуур байрын орчинд эрүүл аюулгүй амьдрах, унших бичих, өөрийгөө илэрхийлэх, чадварыг сайжруулах, математик, монгол хэлний хичээлийн хоцрогдлыг багасгах, өөртөө үйлчлэх энгийн дадал хэвшил, бусадтай хамтрах, бусдыг хүндлэх зэрэг харилцааны эерэг хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр дотуур байрын багш нартай хамтран ажилласнаар 6-7 настай сурагчид дотуур байрын орчинд дасах, сурлагын хоцрогдолд орохгүй байхад дэмжлэг болж байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
67	Драм урлагаар дамжуулан хүүхдийн танин мэдэхүйн, сэтгэн бодох чадвар, хүмүүнлэг ёсны ойлголтыг бий болгох зорилгоор Хөхөлдэй хүүгийн театрыг Арвайхээр сумын Ерөнхий боловсролын сургууль түшиглэн байгуулна.	-	Театр байгуулагдсан эсэх	2021	-	Хөхөлдэй хүүхдийн театр байгуулагдан, сурагчид хамрагдаж эхэлсэн байна.	Арвайхээр сумын ерөнхий боловсролын 4, 5 дугаар сургуулиудад түшиглэн "Хөхөлдэй хүүгийн театр"-ыг байгуулах ажлыг эхлүүлж, 4 дүгээр сургуульд "Алиа Тогмид" жүжгийн эхний үзэгдлийг 5 дугаар сургуульд "Болдоггүй бор өвгөн" жүжгийн 2 үзэгдлийг тавиад байна. Жүжигт нийт 90 гаруй сурагч сонгогдон, оролцон тоглохоор бэлтгэж, жүжгийг контент хэлбэрээр нийтэд хүргэхээр хичээллэж байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
68	Багш нарын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх харилцан туршлага солилцох, багшийн ажлын үнэлэмжийг дээшлүүлэх зорилгоор “Чадварлаг багш” арга хэмжээ, “Бүсийн төвийн журам”-ын хэрэгжилтийг	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгээр	2021	-	Бүсчилсэн сургалт, зөвлөгөөнүүдийг зохион байгуулсан байна.	Говь-Эрдэнэ бүсийн Төгрөг, Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Богд сумын багш нарын туршлага солилцох уулзалт Богд суманд зохион байгуулагдаж, нийт 134 багш оролцлоо. Тус арга хэмжээгээр 3 цагийн үзүүлэх хичээлийн хэлэлцүүлэг хийж, “Багшийн ёс зүй, харилцаа хандлага” сэдвээр лекц уншиж, Төгрөг сумын сургууль багш нарын “ЭЕШ-д бэлтгэх арга зүй”, Гучин-Ус сумын сургууль багш нарын “Сурлагын хоцрогдол нөхөх, арилгах үйл ажиллагааны туршлага”, Баруунбаян-Улаан сумын сургууль багш нарын “Хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур, даалгавар боловсруулах арга зүй”, Богд сумын

	ханган ажиллана.						<p>сургууль багш нарын “Ээлжит хичээлийн цахим контент боловсруулах зөвлөмж” туршлагаадаа түгээн дэлгэрүүлж, харилцан туршлага солилцон хамтран ажиллалаа.</p> <p>Хан хөгшин бүсийн Уянга, Хайрхандулаан, Тарагт, Нарийнтээл сум, Жаргалант багийн сургуулийн захирал, сургалтын менежер нийгмийн ажилтан, эмч, дотуур байрын багш, нягтлан бодогч, ёс зүйн зөвлөлийн гишүүн зэрэг 48 хүний бүрэлдэхүүнтэй бүсийн зөвлөгөөн зохион байгуулж, ёс зүйн сургалт, “Хөдөлмөр зуслангаар дамжуулан сурагчдыг хөгжүүлэх боломж”, “Хүүхэд хөгжүүлэх цахим тоглоомыг сургуулийн вэб сайтаар хөгжүүлэх боломж” зэрэг сайн туршлагаа танилцуулж, “Судалгаанд тулгуурлан үйл ажиллагаа зохион байгуулах нь” “Дунд, ахлах ангийн сурагчидтай фокус ярилцлага хийх арга зүй” сэдвээр хэлэлцүүлэг хийх зэрэг бүсчилсэн арга хэмжээг зохион байгуулсан болно.</p> <p>Мөн Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан "Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил-Зөвлөх багшийн манлайлал" сургалт зөвлөгөөнд 14 зөвлөх багш оролцож, "Итгэлцлийн санамж бичиг" байгуулан багшид мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, тэргүүн туршлагаа түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна.</p> <p><b>Хэрэгжилт-100 хувь</b></p>
69	Багш нарын англи хэлний онол, яриа, бичгийн чадварыг сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	-	Ахисан түвшний сургалтанд хамрагдсан англи хэлний багшийн тоогоор	2021	45	60	<p>Англи хэлний багш нарын заах арга зүй, ярих чадвар, дүрмийн мэдлэгийг сайжруулахаар Глобал Удирдагч их сургуультай хамтран 5 ээлжийн 14 хоногийн сургалтыг Улаанбаатар хотод танхимаар зохион байгуулж, 35 багш, “Энх тайвны Корпус”-тай хамтран 3 өдрийн “IELTS Writing, reading, listening, speaking and listening” агуулгын хүрээнд чадваржуулах сургалтад 33 багш, Монголын англи хэлний багш нарын холбоо, Их Британы консулаас хамтарсан төсөлд 4 багш оролцож, 2 сарын хугацаанд "Ярианы анги"-д, IELTS сургагч багшийн мэргэжлийн чадавхыг сайжруулах 2 сарын сургалтад 9 багшийг чадавхжуулан, нийт 79 англи хэлний багш мэргэжил дээшлүүлээд байна.</p> <p><b>Хэрэгжилт-100 хувь</b></p>
70	Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын дотоод хяналтын нэгжийн гишүүдийг чадавхжуулах, хяналт шалгалтын үр дүнгээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлд	-	Сургалтад хамрагдсан дотоод хяналтын гишүүдийн тоогоор	2021	45	90	<p>Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын дотоод хяналтын нэгжийн гишүүдийг чадавхжуулах, хяналт шалгалтын үр дүнгээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулах сургалтыг зохион байгуулж, салбарын 76 байгууллагын 120 гишүүн хамрагдсан байна.</p> <p>Сургалтын үр дүнд дотоод хяналтын ажлыг төлөвлөх, хяналт шалгалтыг зохион байгуулах, үнэлж дүгнэх, зөрчлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах зэргээр мэдлэг ойлголтоо нэмэгдүүлж харилцан туршлага солилцлоо.</p>

							Хэрэгжилт-100 хувь
71	мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана						<p>Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2022 оныг “Боловсролын салбарын ёс зүйн жил” болгон зарласантай холбогдуулан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, коллежийн багш, удирдах ажилтнуудад мэдээлэл өгч, зорилтот жилийн нээлтийг хийлээ.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны газраас зорилтот жилийн хүрээнд хийх ажлын ерөнхий төлөвлөгөөг гарган хүргүүлснээр боловсролын байгууллагууд төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа зохион байгуулж байна.</p> <p>Энэ оны хичээлийн жилийн багш нарын бага хуралд багшийн ёс зүй, боловсролын салбарт хандаж буй ёс зүйн холбогдолтой өргөдөл гомдлын тайлан мэдээлэл, цаашид анхаарах асуудлаар багш, удирдах ажилтнуудад мэдээлэл өгч, Боловсрол шинжлэх ухааны яам, Төрийн албаны зөвлөлөөс хамтран боловсролын байгууллагын ёс зүйн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж танхимаар 65, онлайнаар 32 сургууль, 48 цэцэрлэгийн ёс зүйн зөвлөлийн гишүүд оролцлоо.</p> <p>Мөн “Ёс зүйгээрээ үлгэрлэе” аяныг бүх шатны боловсролын байгууллагуудын дунд зохион байгуулж, сайн туршлага, үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлж, ажиллав.</p> <p>Тус аяны хүрээнд боловсролын байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрэм журам, холбогдох эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, аливаа ёс зүйн алдаа дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр “Алдаанаасаа суралцъя” кейст тулгуурласан хэлэлцүүлэг, багш, удирдах болон бусад ажилчдын ажлын нэг өдрийн ачааллыг иргэд, эцэг, эхчүүдэд сурталчлан таниулах видео контент, подкаст, ёс зүй, харилцаа хандлагыг нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөөнүүдийг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, бүх албан хаагчдыг хамрууллаа.</p> <p>Боловсролын байгууллагын албан хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол санал 2021 онд нийт 23 байсан бол 2022 оны байдлаар 12 болж буурсан үзүүлэлттэй байна.</p> <p><b>Хэрэгжилт-90 хувь</b></p>
<b>ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ</b>							
<b>Зорилт 1.16. Гэр бүлд ээлтэй хөгжил, хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх замаар гэр бүлийн хөгжлийг дэмжих, тогтвортой, чадавхжсан гэр бүлийг төлөвшүүлнэ.</b>							
72	Есөнзүйл суманд хүүхдийн хөдөлмөр зусланг байгуулах ажлыг эхлүүлнэ.	Орон нутгийн төсөв	Зуслан байгуулах	2021	-	Зуслан гийн ажлыг эхлүүлсэн байна.	<p>Есөнзүйл суманд хүүхдийн хөдөлмөр зуслан байгуулах төсөв шийдвэрлэгдээгүйн улмаас ажил эхлээгүй тул хэрэгжилт тооцох боломжгүй.</p> <p><b>Хэрэгжилт-0</b></p>



73	Хүүхдийн нөхцөл байдлын суурь судалгааг хийнэ.	-	Суурь судалгаа	2021	Гэр бүлийн хүчирхийл лээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр батлагдсан.	Гэр бүлийн хүчирхийл лийн нөхцөл байдлын талаарх суурь судалгаатай болсон байна.	<p>Үндэсний Статистикийн хорооны 2015 оны Хүүхэд хамгааллын 129 үзүүлэлт тооцох аргачлалын дагуу аймгийн Цагдаагийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар зэрэг нийгмийн 7 салбар, сумдын Нийгмийн бодлогын мэргэжилтнүүд, багийн нийгмийн ажилтнаар дамжуулан анхан шатны нэгжээс статистик тоон судалгааг нэгтгэн, мэдээллийн санг өргөжүүлж, “Статистик-2022” эмхэтгэлийг 80 ширхэгийг хэвлэн сум, багийн холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлж, мэдээллээр хангасан.</p> <p>Аймгийн баяр наадмаар хурдан морь унаж уралдсан 1460 уралдаанч хүүхдийн мэдээллийг эрсдэлийн программд бүртгэн, мориноос унаж, бэртсэн 54 тохиолдолд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж, бэртэл, гэмтэлтэй хүүхдийг дахин хурдан морь унуулахгүй байхад хяналт тавин ажиллалаа. Цахим бүртгэлийг нэвтрүүлснээр уралдаанч хүүхэд хэдэн жил морь унаж байгаа, оролцсон уралдаан, уяачийн мэдээлэл, гаргасан амжилт, учирсан эрсдэл, сургуульд хамрагдалт, үзүүлсэн үйлчилгээ зэрэг мэдээллийг хянах нөхцөл боломж бүрдсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд хорихоос суллагдсан 33, архины хамааралтай 334 иргэнийг судалгаанд хамруулж, судалгааны сан бүрдүүлээд байна. Судалгаанд хамрагдсан иргэдээс архины хамааралтай 220 гэр бүлийг сонгон нөхцөл байдлын үнэлгээ хийж, 15 гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, 22 гэр бүлийг гэр бүлийн боловсрол олгох “Гэр бүлийн харилцаа”, “Гэр бүлийн эрүүл мэнд” сэдэвт сургалтад хамрууллаа.</p> <p>Цагдаагийн хэсгийн байцаагчид бүртгэлтэй, хүчирхийлэлтэй гэр бүлд амьдарч байгаа, гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй, хүүхдийн тусламжийн 108 утсанд дуудлага, мэдээлэл бүртгэгдэж байсан болон “Багш айлчлал” аргачлалаар өндөр эрсдэлтэй гарсан хүүхдүүдийн анхан шатны судалгааг авч, мэдээллийг сум, багийн хамтарсан багийн хурлаар хэлэлцүүлж, 665 хүүхдийг хүүхдийн эрсдэлийн даатгалд даатгуулаад байна. Ингэснээр хурдан морь унаач хүүхдүүд болон бусад хүүхдэд аливаа эрсдэлийн тохиолдол үүсэхэд хариу үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг болж байна.</p> <p><b>Хэрэгжилт-90 хувь</b></p>
74	Залуучуудын хөгжлийн төв байгуулж, стандартын дагуу тохижуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.	10.0 сая	Залуучуудын хөгжлийн төв	2021	Залуучуудын хөгжлийн төвийн танхимын асуудал шийдэгдсэн.	Залуучуудын хөгжлийн жишиг төвтэй болсон байна.	<p>Залуучуудын хөгжлийн төвийг орон нутгийн төсвийн 10.0 сая төгрөгийн санхүүжилтээр тохижуулан үйл ажиллагаа тогтмолжин, залуучуудад амьдрах ухааны боловсрол олгох, санхүүгийн боловсрол эзэмшүүлэх, гэр бүлийн боловсрол олгох 18 удаагийн танхим болон цахим сургалтыг зохион байгуулж, 3360 өсвөр үе, залуучуудыг хамрууллаа.</p> <p>Эрдэм шинжилгээний бага хурал, иргэний андгай өргөх ёслол, Охидоо хайрлая, Супер анги шалгаруулах уралдаан, Бид эх оронч залуу зэрэг</p>

						<p>13 удаагийн нөлөөллийн үйл ажиллагаанд 7145 залуучууд хамрагдсан байна.</p> <p>Тус төв нь өсвөр үе, залуучууд руу чиглэсэн залуучуудын оролцоог идэвхжүүлсэн сайн дурын клуб, зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулж, гарааны бизнес эрхлэх залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, start-up хөтөлбөрт холбон зуучлах, мэдээллээр хангах, сэтгэл зүй, хууль эрх зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд холбон зуучлах, чөлөөт ярилцлага зохион байгуулах зэрэг үндсэн 7 төрлийн үйлчилгээг үзүүлж, нийт залуучуудын 29,5 хувийг хамруулаад байна.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт-100 хувь</b></p>
75	“Хүүхэд хамгаалал”-ын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, тэднийг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.		Чадавхжуулах сургалтын тоо	2021	Чадавхжуулах сургалт 2	<p>Хамтарсан багийн үйл ажиллагаа сайжирсан байна.</p> <p>Нийгмийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, нийгмийн ажилтнуудын судалгаа, бүртгэл, мэдээллийг цахимжуулах “Нийгмийн ажил үйлчилгээний нэгдсэн сан” мэдээллийн цахим системийг үндэсний хэмжээнд нэвтрүүлж байгаатай холбогдуулан системийн ашиглалт, хэрэглээний талаарх 3 удаагийн сургалтад хамтарсан багийн 53 төлөөлөл хамрагдаж, өдөр тутмын үйл ажиллагаандаа таблет ашиглан, зорилтот бүлгийн 723 иргэний мэдээлэл, зөвлөгөө өгсөн 30 тэмдэглэл, 34 кейс бүртгэгдэж, программын бүртгэл, ашиглалт сайжирч байна.</p> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас таблет болон тусгай утасны дугаар бүхий сим карт, хурууны хээ уншигч зэрэг 49,1 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.</p> <p>Сум, багийн хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, зөвлөн туслах, хүүхэд хамгааллыг сайжруулахаар хүүхдийн эрхийн үндэсний сургагч багштай хамтран бүх сумдад хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн зөвлөгөөн зохион байгуулж, 2118 төрийн албан хаагч, 2124 эцэг эх хамрагдлаа. Мөн хамтарсан багийн гишүүдэд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд багийн гишүүний хуулиар хүлээх ажил үүрэг, багийн жишиг төлөвлөгөө, тайлангийн загвар хүргүүлж, арга зүйн дэмжлэг тогтмол үзүүлж, эргэх холбоотой ажиллаж байна.</p> <p>Хамтарсан багийн үйл ажиллагааг арга зүйгээр дэмжих, эрчимжүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагын ажлын хэсэг жил бүр сумдад ажиллаж, зөвлөн туслахаас гадна хүүхэд хамгааллын зурдал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс хамтарсан баг бүрд 1,8 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн, үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Энэ хүрээнд аймгийн хэмжээнд 36 хамтарсан баг 204 өрхийн 562 хүүхдэд кейс нээн ажиллаж байгаа ба кейс шийдвэрлэлт 62 хувьтай байна.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт-90 хувь</b></p>

76	Хүүхэд залуучууд, гэр бүлийн ёс зүй, хүмүүжил төлөвшилд нөлөөлөхүйц видео контент хийж, архивын сан үүсгэнэ.		Видео контентийн тоо	2021	1	Видео контент хийж архивын сантай болсон байна.	Олон улсын Гэр бүлийн өдрийг угтан 3 үеийн гэр бүлийн төлөөллийг оролцуулсан “Миний гэр бүл миний аз жаргал” телевизийн уулзалт, ярилцлага зохион байгуулж, 63 хүн оролцож, орон нутгийн телевиз болон цахим хэлбэрээр нийтэд түгээлээ. Гэр бүлийн үнэ цэнэ, хайр, хүндлэл, аз жаргалыг илэрхийлсэн 4 төрлийн постер, шторк бэлтгэж, цахим орчноор дамжуулан 7 мянган хүнд хүргэж, гэр бүлийн боловсрол олгох 8 модуль хичээлийн видеог түгээж, 12 мянган хандалт авсан байна. Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдрөөр “Хүүхэддээ бахархан дуурайх аав, ээж нь байя” уриалга гаргаж, “Хүүхдийг зодож шийтгэснээс үүсэх сэтгэл зүйн гэмтэл” сэдвээр сэтгэл зүйч орон нутгийн телевизэд ярилцлага өгч, эцэг, эхчүүд, хүүхэдтэй ажилладаг албан хаагчдад мэдээлэл хүргэлээ. Хүүхдүүдийн зуны амралтын хугацаанд хүүхэд хамгааллын чиглэлээр 5 постер, 1 видео, 6 удаагийн мэдээлэл бэлтгэн байгууллагын цахим хуудаст байршуулж, 10 мянган хандалт авсан байна. Хүүхдийг ахуйн осол гэмтэл, гол, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах мэдээллүүдийг гудамж, нийтийн талбайн сурталчилгааны самбарт байршуулж, иргэдэд мэдээлэл түгээлээ. Орон нутгийн телевизтэй хамтран хүүхэд, өсвөр үеийнхнийг мал маллах монгол ухаан, малчин залуу, гэр бүлийн амьдрал ахуйтай танилцуулахаар “Илгээлтийн эзэд” цахим контент, аав хүний үүрэг, хариуцлага, оролцоог нэмэгдүүлж, гэр бүлийн харилцаа хандлагад сайнаар нөлөөлөх “Халамжтай аав” телевизийн нэвтрүүлгийг бэлтгэж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар цахим хуудаст байршуулсныг 8.8 мянган хүн үзэж, хандалт авсан байна. Энэ хугацаанд 12 контентоор архивын сан үүсгэж хадгалаад байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
77	Хүүхдийн ордны дугуйлангийн төрлийг нэмэгдүүлж, дугуйлангийн багш нарыг орон тоогоор ажиллуулна.		Дугуйлангийн тоо, багшийн орон тоо	2021	11	Дугуйлангийн тоо нэмэгдсэн байна.	Хүүхдийн ордны дэргэд монгол бичиг, шатар, соробан сампин, найрал дуу, их хуур, төгөлдөр хуур, ятга, ёочин, үкүлэлэ, бүжиг, зураг зэрэг 15 дугуйланд давхардсан тоогоор 7100 хүүхэд хамрагдаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүүхдийн тоо 26 хувиар өсч, дугуйлангийн нэр төрөл 4-өөр нэмэгдсэн байна. Уран зургийн “Этюд” дугуйланд зорилтот бүлгийн, 32 хүүхдийг хамруулж, хөгжлийн үйлчилгээ үзүүлж байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
<b>Зорилт 1.17. Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тасралтгүй хөгжүүлэх тэдний эрэлт хэрэгцээнд суурилсан, хөгжил оролцоог хангасан салбар дундын зохицуулалт хийж, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлнэ.</b>							
78	Ахмад настны аж байдлын судалгааг хийж, судалгаанд үндэслэн шаардлагатай цогц арга	Улсын төсөв 2,2 тэрбум	Ахмад настанд нийгмийн халамжийн	2021	Аймгийн хэмжээнд нийт 11,000 ахмад	Судалгаанд хамрагдсан ганц бие болон эрсдэлт	Аймгийн хэмжээнд нийт 12677 ахмад настан байгаа бөгөөд үүнээс 9651 харьяалалгүй, 21 хувь буюу 2703 ахмад хөдөлмөр эрхэлж байна. Үүнээс төрийн байгууллагад 70, төрийн бус байгууллагад 136, үйлдвэрлэл үйлчилгээний салбарт 316, газар тариалангийн салбарт

	хэмжээ авч хэрэгжүүлнэ.	(халамжийн сан)	үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх		настан байна.	нөхцөлд амьдардаг ахмадуудын 10 хувьд хүрч үйлчилсэн байна.	182, мал аж ахуйн салбарт 1999 ахмад хөдөлмөр эрхэлж байна. Аймгийн ахмадын хорооноос гаргасан судалгаагаар 308 харж хандах хүнгүй ахмад настан байгаа бөгөөд эдгээр ахмадад чиглэсэн арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж байна. Нийт нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламж, ахмад настанд үзүүлэх хүндэтгэл, насны хишигт давхардсан тоогоор 20 мянга гаруй ахмад настанг хамруулж, 4,8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төсөвлөсөн. Үүнээс нийгмийн халамжийн тэтгэвэрт 143 ахмад настан 347,5 сая, асаргааны тэтгэмжид 1560 ахмад настанд 273,2 сая, нэг удаагийн тусламж, хөнгөлөлтөд 2480 ахмад настанд 424,0 сая, алдар цолтой ахмад настны хөнгөлөлт, тусламжид 9 ахмад настан хамрагдаж 2,4 сая төгрөгийг тус тус олгосон. Мөн насны хишигт 5776 ахмад хамрагдаж, 969,0 сая, харьяалалгүй ахмад настны хөнгөлөлт тусламжид 9497 ахмад хамрагдаж, 95,0 сая төгрөгийг улсын төсвөөс тус тус зарцуулсан. Ахмад настанд нийгмийн халамжийн үйлчилгээг цогцоор үзүүлж, амьдралын чанарыг сайжруулахаар олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд амьдрах ухааны сургалт, өдрийн болон сэргээн засах үйлчилгээ, бүлийн төсөлд нийт 440 ахмад настныг хамруулж, орон нутгийн төсвөөс 32,6 сая төгрөг зарцуулсан.
							<b>Хэрэгжилт-100 хувь</b>
79	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд суурилсан сэтгэлзүйн болон сэргээн засах сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулж, хөгжих, оролцох боломжийг сайжруулах багц арга хэмжээг авч хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн зураг төсөв хийлгэнэ.	Орон нутгийн төсөв 82,0 сая	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх	2021	Төрийн болон үйлчилгээний 12 барилга байгууламжид үнэлгээ хийсэн.	Төрийн байгууллагуудад хүртээмжтэй орчин бүрдүүлсэн байна.  Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн зураг төсөв хийгдсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл 6 зорилтын хүрээнд 21 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан брайл үсгийн сургалт, дохионы хэлний сургалтыг зохион байгуулж, нийт 25 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 120 орчим төрийн албан хаагчдыг хамруулаад байна. Хүртээмжтэй орчин бүрдүүлэх зөвлөн туслах чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн 32 байгууллагад зөвлөмж хүргүүлээд байна. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн үзлэгийн ор, тэргэнцэр, тэргэнцэртэй хүний жин зэрэг багц тоног төхөөрөмжийг байршуулан, 50 гаруй хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг үзлэгт хамруулаад байна. Арвайхээр сумын 4 байршлын 14 цэгт явган хүний гарцад харааны бэрхшээлтэй хүнд зориулсан дуут дохио суурилуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тэдэнд сэтгэл зүйн болон сэргээн засах сургалт, арга хэмжээг зохион байгуулахаар 35,7 сая төгрөг төсөвлөж, амьдрах ухааны сургалтад 25, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 15, өдрийн болон сэргээн засах үйлчилгээнд 28, бүлийн төсөлд 15, нийт 83 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулж, орон нутгийн төсвөөс 9,3 сая төгрөг зарцуулсан.

							Хэрэгжилт-90 хувь
ШИНЖЛЭХ УХААН							
Зорилт 1.18 Орон нутгийн онцлогт тулгуурлан их, дээд сургуулийг шинээр байгуулна.							
80	Төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, их дээд сургууль, судалгааны институттэй хамтарсан судалгааны шинжилгээ, инновацын төв байгуулах ажлыг үе шаттай эхлүүлж, ажил олгогч, мэргэжлийн холбоод, эрдэмтэн багш, судлаачдын түншлэлийг бэхжүүлнэ.	15,0 сая төгрөг	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	2021	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Монгол Улсын Засгийн газраас их дээд сургуулийг орон нутагт шилжүүлэх “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх бодлогын хүрээнд аймаг орон нутгийн нөөц боломжид тулгуурлан их дээд сургууль байгуулах тухай саналыг хүргүүлээд байна. Аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/297 дугаар захирамжаар Шинжлэх ухаан технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулав. Боловсрол, шинжлэх ухааны яам, Шинжлэх ухаан технологийн сан, “Startup” хөтөлбөрөөс хамтран нийслэлд болон орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд иргэд, олон нийтийн оролцоог хангах, тэдгээрийн санал, санаачилгыг дэмжих, урамшуулах “Mon-X Инновацын хөтөлбөр”-ийг зарлаж, “Асуудал тодорхойлох уулзалт” “Сонирхогчдын уулзалт”-ыг онлайнаар зохион байгуулсан бөгөөд уулзалтад аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Статистикийн хэлтэс, Худалдаа аж үйлдвэрийн танхимын төлөөлөл, бусад албаны хүмүүс оролцож, аймаг орон нутагт тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлов. Үүнд агаарын бохирдол, малчдын бэлчээрийн асуудал, ядуурал, ажилгүйдэл, ажлын байр, гэх мэт асуудлуудыг онцоллоо.
Зорилт 1.19. Техник, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын үйл ажиллагааг тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлогод нийцүүлэн хөгжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан төгсөгчдийг ажлын байраар хангана.							
81	Техник, мэргэжлийн боловсрол сургалтын үйл ажиллагаанд цахим сургалтын орчин бүрдүүлж, үнэлгээ, бүртгэл мэдээллийн системийг хөгжүүлнэ.	-	Үнэлгээ, бүртгэл мэдээллийн системийг хөгжүүлсэн эсэх	2021		Платформын хөгжүүлэлтийг сайжруулна.	Өвөрхангай аймаг дахь Политехникийн коллеж нь цахим сургалтын платформыг дотоод сүлжээндээ ашиглахаар хөгжүүлэн, нийт 70 багшийн 34 мэргэжлийн, 124 бүлэг, 1000 гаруй цахим хичээлийн нэгдсэн санг үүсгэв. Эдгээр цахим хичээлийг хичээл нэг бүрээр DVD дискэд хуулж багш, суралцагчид ашиглаж болох нөхцөл боломжоор хангав. Техник, мэргэжлийн боловсролын суралцагч, төгсөгчдийн мэдээллийг mergejl.mn системд бүрэн оруулж цахимжууллаа.
82	Техник, мэргэжлийн боловсролын байгууллага, багш нарын ур чадвар сургалтын чанарыг дээшлүүлж, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлд	-	Төгсөгчдийн ажил эрхлэлтийн эзлэх хувиар	2021	45,6	56,5	Өнгөрсөн оны 2,5 жилтэй өвлийн төгсөлтийн 197, техникийн боловсрол олгох 1,5 жилтэй 27 төгсөгчийн мэдээллийг маягтын дагуу гарган, 3 сарын дараах хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгааг гаргав. Өвлийн төгсөлтийн 224 төгсөгчийн 120 суралцагч буюу 53.5 хувь нь ажлын байраар хангагдаад байна. Ажил хайгч төгсөгчдийн мэдээллийг “Идэвхтэй ажил хайгч”-ийн санд бүртгүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, төгсөгчидтэй эргэх холбоотой ажиллаж

	эрэлттэй мэргэжилтэнг бэлтгэн, төгсөгчдийг ажлын байранд зуучилна.						байгаа бөгөөд “Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн төгсөгчид” пэйж хуудсыг тогтмол ажиллуулан, гишүүдийн тоог нэмэгдүүлж, төгсөгчдөд ажлын байрны захиалга болон бусад мэдээллийг хүргэн ажиллав. Тус пэйж хуудаст 566 төгсөгч нэгдсэн бөгөөд цахим хуудсаар дамжуулан 40 удаагийн ажлын байрны зарыг түгээж ажилласан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ</b>							
<b>Зорилт 1.20. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангаж, халамжаас хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулж, нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.</b>							
83	Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	1,5 тэрбум төгрөг	шинээр бий болсон ажлын байрны тоо	2021	1102 ажлын байр (хүлээгдэж буй гүйцэтгэл 1500 ажлын байр)	2000 иргэн ажлын байраар хангагдсан байна. (ажлын байрны дэмжлэгт хамрагдсан иргэдийн 50 хүртэлх хувь нь эмэгтэйчүүд байна)	Орон нутагт хэрэгжүүлж буй томоохон бүтээн байгуулалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрийн үр дүнд 1140 ажлын байр бий болсон байна. Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн төсөл хөтөлбөр арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал “Хөгжлийн шийдэл” төрийн бус байгууллагатай хамтран “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгийн хүрээнд 70 эмэгтэйд үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний онцлогт нийцүүлж, бизнесээ өргөжүүлэхэд чиглэсэн аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж, сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдээс 37 эмэгтэйн төслийг сонгон шалгаруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 185,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож тогтвортой ажлын байраар хангасан. Азийн сангийн “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд 31 удаагийн уулзалт, арга хэмжээг зохион байгуулж, 439 эмэгтэйг хамруулж, 25 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйд 35,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлээд байна. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн аж ахуй эрхлэлтийн сургалтад 27 эмэгтэй, 50 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 11 эмэгтэй тус тус хамрагдаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 58,0 сая төгрөг зарцуулсан. 25 ба түүнээс дээш ажиллагсадтай 101 аж ахуйн нэгж байгууллагад 209 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах ёстойгоос 161 иргэн ажиллаж байна. “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгт 21 эмэгтэйг хамруулж 74,0 сая, “Старт ап” арга хэмжээний сургалтад 14 эмэгтэйг хамруулж, 4,4 сая төгрөгийг тус тус хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан. Нийтийг хамарсан ажилд 334 иргэн, мод тарих арга хэмжээнд 500 иргэн тус тус хамрагдсан. Дээрх 2 арга хэмжээнд хамрагдсан иргэдийн 377 нь буюу 90,9 хувь нь эмэгтэйчүүд байна. Хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний үр дүнд 34 байнгын, 377 түр ажлын байр шинээр бий

							болсон дүнтэй байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
84	Хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн зөвлөгөө мэдээллийн үйлчилгээг цогцоор нь хүргэж, мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулж ажилд зуучилна.	Улсын төсөв 12,7 сая төгрөг	сургалтад хамрагдсан иргэдийн тоо	2021	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд 568 иргэн хамрагдсан	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд 2000 иргэн хамруулна.	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 2000 иргэн хамрагдсанаас 600 нь ганцаарчилсан зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээнд, 1400 нь бүлгийн сургалтад хамрагдсан байна. “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалтад 258 иргэнийг, тогооч, оёдолчны мэргэжил олгох сургалтад 100 иргэнийг тус тус хамруулж, сургалтад хамрагдсан иргэдийн 26 нь байнгын, 103 нь түр ажлын байртай болж, 3 иргэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт хамрагдсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
85	Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн бүртгэл, мэдээлэлд тулгуурлан төсөл, хөтөлбөрийг оновчтой хуваарилан зохион байгуулна.	-	хэрэгжүүлсэн арга хэмжээ	2021	Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгч иргэдийн судалгааг 18 сумаар гаргасан.	Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүд, зорилтот өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулна.	Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн түүвэр судалгааг 37 салбараар ангилан шинэчилж гаргасан бөгөөд 1471 албан бус хөдөлмөр эрхлэгч ажиллаж байна. Эдгээрийн 357 буюу 24,2 хувь нь газар тариалан эрхлэгчид, 425 буюу 28,9 хувь нь хоол үйлдвэрлэгчид, нарийн боов үйлдвэрлэл, 191 буюу 13 хувь нь оёдолчид, 119 буюу 8 хувь нь дугуй засварын үйлчилгээ эрхлэгчид, 88 буюу 6 хувь нь үсчин, авто угаалга, 108 буюу 7,3 хувь нь модон эдлэлийн үйлдвэрлэл эрхлэгчид тус тус байна. Дээрх судалгаанд үндэслэн 2022 оны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөр, санхүүгийн дэмжлэгийг дараах салбаруудад чиглэн олгосон. Үүнд газар тариалан 28, хоол үйлдвэрлэл 23, оёдол 32, дугуй засвар 8, үсчин 6, мод, модон эдлэл 9, төмөр эдлэл 5, саван үйлдвэрлэл 2, бариа засал 3, жааз үйлдвэрлэл, сургалт үйлчилгээ 1, бусад 5, нийт 122 иргэнд санхүүгийн дэмжлэг олгосон. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
<b>Зорилт 1.21. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төр, хувийн хэвшлийн байгууллагууд ажилтан, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлнэ</b>							
86	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг сурталчилж, сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулсан байна.	2,0 сая төгрөг	зохион байгуулсан сургалтын тоо	2021	-	100-аас доошгүй байгууллага д сургалт зохион байгуулсан байна.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг сурталчлах ажлын хүрээнд 11 удаагийн сургалтыг зохион байгуулж, 95 аж ахуйн нэгж байгууллагын 153 ажилтан, албан хаагчдад хүрч ажиллан, зөвлөгөө мэдээлэл өгсөн. Мөн 133 иргэнд хуулийн шинэчлэлийн талаар мэдээлэл зөвлөгөө өгч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчилсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
87	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, үзлэг шалгалт, зөвлөн туслах, сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.	3,0 сая төгрөг ХЭДС ОН 4,3 сая	зохион байгуулсан үзлэг шалгалтын тоо  сургалтын тоо	2021	28 байгууллага д үзлэг, шалгалт хийсэн.  12 удаагийн сургалт	35 байгууллага д үзлэг шалгалт хийсэн байна.  15 удаагийн	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах чиглэлээр 15 удаагийн сургалтыг зохион байгуулж, 124 аж ахуйн нэгж байгууллагын 479 ажилтан албан хаагчид зөвлөгөө мэдээлэл өгсөн. Мөн энэ чиглэлээр 148 иргэнийг сургалтад хамруулж, зөвлөгөө мэдээллээр хангасан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөөс иргэдийн оролцоотой нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь аюул эрсдэлийг илрүүлж, арилгах зорилготой, иргэд мэдээлэл оруулахад хялбар

					зохион байгуулсан.	сургалт зохион байгуулсан байна.	шийдэл бүхий “Эрсдэлээс сэргийлье” гар утасны аппликэйшн бий болгож, үйлчилгээг нэвтрүүлж эхлээд байна. Цаашид аппликэйшнийг 19 сумын хэмжээнд ашиглах журмыг боловсруулж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх үзлэг шалгалтыг 3 удаа зохион байгуулж, 78 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Дээрх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 1,9 сая төгрөгийг зарцуулсан. Эндээ хөгжил ТББ-аас Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал 8 цагийн сургалтыг танхим болон цахимаар хослуулан зохион байгуулж, 34 байгууллага аж ахуйн нэгжийн 276 ажилтан албан хаагчид, цахимаар 16 сумдын 89 ажилтан албан хаагчид тус тус хамрагдсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>Зорилт 1.22. Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон, зорилтот өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж, хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.</b>							
88	Халамжаас хөдөлмөрт шилжүүлэх бодлогын хүрээнд “Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн тоог бууруулна.	890,1 сая төгрөг (10 сарын гүйцэтгэлээр)  ОУТ хөтөлбөр 55,0 сая	хөтөлбөрт хамрагдсан өрхийн тоо  хэрэгжүүлсэн арга хэмжээ	2021	Үйлчилгээнд 2653 өрх хамрагдаж байсан	Үйлчилгээнд хамрагддаг өрхийн тоог 10 хүртэлх хувиар бууруулах	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг өрх, иргэдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16 хувиар буурсан бөгөөд 899 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж, 778 өрхийн үйлчилгээнд хамрагдах эрхийг түдгэлзүүлсэн. Дээрх үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхөөс 63 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 47 иргэнийг түр ажлын байраар хангаж байна. “Нэг өрх нэг ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд Австралийн Засгийн газрын 2022-2023 оны санхүүгийн жилд “Бичил төсөл”-ийн хөтөлбөрт “Тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” төслийг боловсруулан, 55,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан. Уг төслийн хүрээнд 500 өрхөөс 390 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж, өрхийн хөгжлийн дэвтрийг боловсруулан, хэвлүүлж, өрхийн хөгжлийн өсөлтийг үнэлэх ажлыг хийж эхлээд байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
89	Нийгмийн халамжийн арга хэмжээг нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттайгаар зохион байгуулах, цахимжуулах, цахим үйлчилгээг иргэдэд сурталчлан таниулах	-	цахимжуулсан үйлчилгээний тоо	2021	16 төрлийн үйлчилгээ цахимжсан	9 төрлийн үйлчилгээ шинээр цахимжина	Нийгмийн халамжийн нэгдсэн систем www.ehalamj.mn цахим программаас нийт 66 төрлийн үйлчилгээг иргэд цахим хэлбэрээр авч байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 91,7 хувиар нэмэгдэж, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжид давхардсан тоогоор 42365 иргэн, хүүхдийн мөнгөн тэтгэмжид 42400 хүүхэд хамрагдсан. Төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй хүргэх нээлттэй хаалганы өдөрлөг, уулзалт, хэлэлцүүлэг арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 3000 гаруй иргэнд нийгмийн халамжийн цахим үйлчилгээний талаар мэдээлэл, зөвлөгөө өгсөн. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
90	Нийгмийн халамжийн бодлогын шинэчлэлийн	-	-	2021	Шинэчлэн тогтоох ажил	Амьжиргааны түвшинг	Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны аргачлалыг улсын хэмжээнд Хэнтий, Булган, Орхон, Дундговь, Улаанбаатар хотын



	хүрээнд зорилтот өрхийн амьжиргааны түвшинг шинэчлэн тогтоох ажлыг үе шаттай эхлүүлнэ.				туршилтын шатанд хэрэгжсэн	шинэчлэн тогтоох ажлыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна	төвийн 6 дүүрэг туршилтаар хэрэгжүүлж эхлээд байна. Аймгийн хэмжээнд Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдах хүсэлт гаргасан нийт 27 өрхийг судалгаанд хамруулж, түүнээс 15 өрхийг шинээр хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамруулсан. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
<b>Зорилт 1.23. Нийгмийн даатгалын мэдээллийг бүрэн цахимжуулан, иргэд даатгуулагчдад үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдыг нийгмийн даатгалд хамруулж, тэдний нийгмийн баталгааг хангана.</b>							
91	Нийгмийн даатгалын цахим мэдээллийн сан бүрдүүлэн, архивын цахим лавлагааны үйлчилгээг жигдрүүлж, иргэд, даатгуулагчдад шуурхай үйлчилгээ үзүүлнэ.	-	үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	2021	1995-2005 оны НД-ын шимтгэл төлөлтийн тайланг цахим оруулж, 2006 оноос хойш тайлан лавлагаа QR кодоор баталгаажиж бүрэн цахимжсан. Үйлчилгээ авагчдын 30 хувь цахимаар авсан.	Архивын цахим үйлчилгээг жигдрүүлж нийт үйлчлүүлэгчдийн 40 хувьд цахимаар үйлчилгээг үзүүлсэн байна.	Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод шаардлагатай архивын лавлагаа олгох ажлыг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх "Цахим архивын лавлагаа" программ хангамжийг салбарын хэмжээнд нэвтрүүлж, лавлагаа тодорхойлолтыг цахимаар олгож эхний 10 сарын байдлаар 820 лавлагаа олгоод байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолтыг "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт" программыг ашиглаж дахин давтагдашгүй тоон өгөгдөл бүхий QR кодтой гаргаж, тэтгэвэр, тэтгэмж олгоход ашиглаж байгаа бөгөөд нийт 281 иргэнд хэвлэн үйлчилсэн. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
92	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг биелүүлж, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	-	нийгмийн даатгалын хамрагдалтын хувь	2021	Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 28,7 тэрбум төгрөгөөр 100 хувь биелнэ. Нийт малчдын НД-ын хамрагдалт 26% байна.	2022 оны батлагдсан төсвийн хуваарийн дагуу төлөвлөгөөг биелүүлэх, малчдын хамрагдалтыг 27,5 хувьд хүргэх	Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах, ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх үүднээс нийт 34 үйлчилгээнээс 19 үйлчилгээ бүрэн цахимжсан. Дээрх цахим үйлчилгээг 250 гаруй удаагийн сургалт, 19 сумдад явуулын үйлчилгээ, нээлттэй хаалганы өдөрлөг, цахим орчинд зохион байгуулж, давхардсан тоогоор 45959 иргэн даатгуулагчид хамрагдсан. Ажил олгогчийн шимтгэлийн тайлан болон сайн дурын даатгалын гэрээ, эрүүл мэндийн даатгалын хураамжийн орлого, архивын лавлагаа, мэдээлэл тодорхойлолтыг даатгуулагчид зориулсан вэб программ, "Нийгмийн даатгал" аппликейшн, төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia)-ээс цахимаар авах боломж бүрдсэн. Нийгмийн даатгалын сангийн орлого 28,6 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 30,9 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлогын төвлөрүүлж, сангийн орлогын төлөвлөгөө 100,0-108,0 хувиар биелэгдэх төлөвлөгөөтэй байна. Аймгийн хэмжээнд нийгмийн даатгалын сайн дурын даатгалд нийт 8324 даатгуулагч хамрагдсанаас хувиараа хөдөлмөр эрхлэгч 1210, малчин 1075

							хамрагдсан нь нийт даатгуулагчийн 28 хувийг эзэлж байна. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх хууль болон хүүхдийн тоогоор нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэмэгдүүлэх, 0-3 насны хүүхдээ асрах хугацаанд сайн дурын даатгалд 50 хувиар хамруулах, нэг сая хүртэлх төгрөгийн цалинтай даатгуулагчид 50 хувийн шимтгэлийн буцаан олголтыг олгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.						
							<b>Хэрэгжилт-100 хувь</b>						
93	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын хурлын үйл ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмжөөр хангаж, хурлыг цахимаар зохион байгуулж, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр сургалт, арга хэмжээ зохион байгуулна.	-	зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтээр	2021	Нийт 3 удаагийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулсан.	Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр сургалт зөвлөгөөн зохион байгуулж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулна.	Мэргэжлийн чиглэлээр хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд эрүүл мэндийн үзүүлэлттэй харьцуулсан судалгаа хийж, хөдөлмөрийн чадвар алдалтаар тэргүүлж байгаа осол гэмтлийн шалтгаант нүдний болон мэдрэлийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн чадвар алдсан үеийн асаргаа сувилгаа, нөхөн сэргээх тусламж үйлчилгээг хэрхэн үзүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх талаарх сургалтыг сум өрхийн эмч нарт “ZOOM” болон танхимаар тогтмол зохион байгуулж байна. Тухайлбал хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх “Даатгуулагч та гэмтлийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдахаас урьдчилан сэргийлж чадна”, “Нүдний эрүүл мэндээ хэрхэн хамгаалах вэ” сэдэвт видео бичлэг бэлтгэн цахим орчинд байршуулснаар нийт 1450 иргэн мэдээлэл авсан. Сум өрхийн эрүүл мэндийн төвийн сэргээн засах тусламж үйлчилгээнд 1881, орон нутгийн рашаан сувилалд 115 хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдсан. Хөдөлмөрийн чадвар алдалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,9 хувиар буурсан байна.						
							<b>Хэрэгжилт-100 хувь</b>						
94	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг сурталчлах, эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	2021	2	2	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөгийг 3 удаа зохион байгуулж зах худалдааны төвөөр сурталчилгаа хийж 1350 иргэнд мэдээлэл түгээж, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвтэй хамтран 128 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд хуулийн сурталчилгаа хийж иргэдийн гар утсанд edaatgal аппликейшин суулгаж, заавар зөвлөгөө өгсөн. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн эмнэлгүүдэд 300 ширхэг сурталчилгааны материал хүргэн иргэдэд мэдээлэл өгсөн. Edaatgal аппликейшины сурталчилгааны самбарыг байгууллагын үүдэнд байршуулсан. Энэ онд орлогын төлөвлөгөө 975,6 сая төгрөг бүрдүүлэхээс 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар орлогын төлөвлөгөөний биелэлт 784,9 сая төгрөг байна.						
							<b>Хэрэгжилт-100 хувь</b>						
							<table border="1"> <tr> <td>төрөл</td> <td>Хүний тоо</td> <td>Дүн /мянган.төг/</td> </tr> <tr> <td>ААН, ХХЭ</td> <td>616</td> <td>49,329.6</td> </tr> </table>	төрөл	Хүний тоо	Дүн /мянган.төг/	ААН, ХХЭ	616	49,329.6
төрөл	Хүний тоо	Дүн /мянган.төг/											
ААН, ХХЭ	616	49,329.6											

							МСҮТ суралцагч	718	41,515.7
							малчин	5429	379,283.1
							Хөдөлмөр эрхлээгүй иргэн	5739	314,861.6
							<b>Дүн</b>	<b>12502</b>	<b>784,990.2</b>
<b>Бүлгийн дүн 89,8 хувь</b>									
<b>ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ</b>									
<b>Зорилго: Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, олон тулгуурт эдийн засаг бүхий өрсөлдөх чадвартай аймаг болно.</b>									
<b>САНХҮҮ, ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТ</b>									
<b>Зорилт 2.1. Төсвийн төлөвлөлт, хариуцлагыг сайжруулж, цахим системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана.</b>									
95	Төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавьж, хариуцлага тооцон ажиллана.	-	Шилэн дансанд мэдээлэл байршуулсан хувиар	2021	90,0	Хуулийн хэрэгжилт 100 хувь	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаардаг төсвийн байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд 2022 онд 3 удаа хяналт шалгалтыг хийсэн. Энэ оны 3 дугаар улирлын байдлаар төсвийн 192 байгууллага нийт 21428 мэдээлэл байршуулахаас 19964 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж, 1396 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 68 мэдээллийг байршуулаагүй, улирлын тайлан мэдээг 89 байгууллага хугацаандаа илгээж, 8 байгууллага илгээгээгүй, хуулийн хугацаанд мэдээ байршуулалт 93,2 хувь, мэдээ илгээлт 91,8 хувьтай байна. Шилэн дансны үйл ажиллагаанд 2022 онд хийгдсэн хяналт шалгалтаар эхний хагас жилийн мэдээлэл байршуулаагүй болон илгээгээгүй байгууллагуудад албан шаардлага хүргүүлснээс биелэлт 94,2 хувьтай байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>		
96	Төрийн сангийн үйл ажиллагааны портал цахим шилжилтийн хүрээнд эрхийн бүртгэлийн сан систем нэвтрүүлэх ажлын баазыг бүрдүүлж, цалингийн нэгдсэн системээс цалингийн гүйлгээг цахимжуулах.	-	Хамрагдсан байгууллагын тоогоор	2021	-	193	Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр цалингаа олгодог 195 төсөвт байгууллага эрхийн бүртгэлийн сан системээр цалингаа 100 хувь цахимаар баталгаажуулж хэвшсэн байна. Мөн 10 дугаар сарын 13-наас эхлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйлгээг эрхийн бүртгэлийн сан системийн тусламжтайгаар цахимаар амжилттай баталгаажуулж эхэлсэн. Портал системийн хөгжүүлэлт үе шаттай хийгдэж байна. Аймаг, сумын төрийн сангийн мэргэжилтэн болон төсөвт байгууллагын дарга, нягтлан бодогч нарт портал системийн эрх олгож цалингаас бусад гүйлгээг цахимаар баталгаажуулах бэлтгэл ажил хийгдэж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>		
<b>Зорилт 2.2. Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, татварын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэнэ.</b>									
97	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд, салбар компаниудыг	-	Төсвийн орлого нэмэгдсэн байна.	2021	17,3 тэрбум	18,0 тэрбум	Энэ онд 123 хуулийн этгээд шинээр бүртгүүлснээр аймгийн хэмжээнд бүртгэлтэй 1731 ХХК, 554 салбар хоршоо, нөхөрлөл, 215 төсөвт байгууллага, 363 төрийн бус байгууллага, 71058 иргэн нийт 73921 татвар төлөгчийн бааз суурьтайгаар төсвийн орлогыг нэмэгдүүлэн		

	орон нутгийн татварын албанд бүртгэлтэй болгон, татварын баазыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.						ажилласан. Аймагт шинээр үйл ажиллагаа явуулж байгаа Миний дэлгүүр, PC mall, “Жи Эс Би” капитал салбаруудыг шинээр татвар төлөгчийн бүртгэлд бүртгэж 4,2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Хархорин, Бат-Өлзий, Богд, Нарийнтээл, Төгрөг, Есөнзүйл сумдад НӨАТ-ын хуулийн хэрэгжилтийг шалгаж ажлын зураг авалт хийн, ААНОАТ, ХХОАТ, НӨАТ, АТБӨЯХАТ 151 татвар төлөгчийн 12,5 сая төгрөгийн татвар ногдуулж төсөвт төвлөрүүлсэн. Барилга угсралт, засварын ажил хийж буй 13 аж ахуйн нэгж болон Уянга сумын Өлт, Бөөрөлжүүтийн аманд бичил уурхай ажиллуулж байгаа 11 иргэн, аж ахуйн нэгжийн ажлын байран дээр ажлын зураг авалт хийж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ус ашигласны төлбөр, ААНОАТ, ХХОАТ-т нийт 95,9 сая төгрөгийн татварыг төвлөрүүлж төсвийн орлогыг нэмэгдүүлсэн. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
98	Иргэдэд татварын шинэчлэлийн талаар сургалт сурталчилгаа явуулна.	-	Сургалт сурталчилгаа явуулсан байна.	2021	-	Малчдын малын хөлийн татварын төлөлт 70 хувиас дээш төлөлттэй, иргэдийн НӨАТ-ын ойлголт нэмэгдэж зөрчил багассан байна.	Татвар төлөгчдөд татварын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, татварын өрийг хугацаандаа төлж, тайлангаа ирүүлэх талаар татвар төлөгчдийг 3 сегментээр ангилан танхимын 58 удаагийн сургалтад 3963, цахимаар 18 удаагийн сургалтад 2865 буюу нийт 76 удаагийн сургалтад 6828 татвар төлөгчийг хамруулсан. НӨАТ-ын хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор томоохон зах худалдааны төвүүдийн бизнес эрхлэгчдийн ажлын байран дээр 3 удаа LIVE-г баримт хэрхэн авах баталгаажуулах тухай мэдээллийг өгч 10 худалдааны төвд баримт олгох QR код нааж зөвлөгөөг өгсөн. “Өвөрхангай Татварын хэлтэс фэйсбүүк” хуудсаар татварын хуулийг сурталчилсан 635 мэдээллийг байршуулсан. Татвар төлөгчдөд зөвлөгөө өгөх тусгай дугаар 1800-1288 болон байгууллагын лавлах утсаар 8570, биечлэн угтах үйлчилгээгээр 10015 бүгд 18585 татвар төлөгчдөд зөвлөгөө өгсөн байна. Мөн 2021 оноос эхлэн шинээр хэрэгжиж буй малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дагуу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр малыг төрөл бүрээр татварын хэмжээг тогтоон мөрдүүлж, 2021 онд 1,3 тэрбум төгрөг, 2022 онд 1,7 тэрбум төгрөг төлөвлөснөөс 3 дугаар улирлын байдлаар 25,2 хувийн биелэлттэй байна. Иргэд, олон нийтэд мөрдөгдөж буй татварын багц хуулиудын сургалт, мэдээллийг цаг тухай бүрд үе шаттайгаар цахим болон танхим хосолсон боломжит бүхий л нөхцөлөөр сурталчлан таниулж байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
<b>Зорилт 2.3. Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, цахим санхүүгийн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлнэ.</b>							
99	Иргэдэд хөрөнгийн зах зээл, үнэт цаасны арилжаанд оролцох	2,0 сая төгрөг	Сургалтад хамрагдсан хүний тоогоор	2021	Сургалтад хамрагдсан хүний тоо	Сургалтад шинээр 1150 хүн	Хөрөнгийн зах зээл, үнэт цаасны зах зээлийн арилжаанд оролцогчдыг нэмэгдүүлэх, Хаан, Төрийн банкнууд хувьцааныхаа тодорхой хувийг олон нийтэд арилжаалахтай холбоотой нэгдсэн цогц мэдээллийг

	чадавхыг нэмэгдүүлэх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.				1123 хүн	хамрагдаж, арилжаанд оролцсон хүний тоо 50 хүнээр өснө	хүргэх зорилгоор “НОГООН СУМ” аяныг Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Санхүүгийн зохицуулах хороо, МҮОНРТ-тэй хамтран зохион байгуулсан. Уг аяны хүрээнд Үнэт цаасны компаниуд нийт 56 иргэнд хувьцааны данс шинээр нээсэн. Дээрх арга хэмжээнд нийт 600 гаруй иргэд оролцож сургалтад хамрагдсан. Мөн “Амьдралын санхүү-Санхүүгээ сайжруулах нь” сургалт өдөрлөг мөн үнэт цаасны арилжааны тухай сургалтыг Гүүдсек ҮЦК-тай хамтран иргэд албан байгууллагад зохион байгуулж сургалт, өдөрлөгт 1400 орчим хүн хамрагдсан. Нийт үнэт цаасны данс эзэмшигчийн тоо 80,1 мянгад хүрч өмнөх оноос 7,4 мянган иргэнээр нэмэгдсэн. Гүүдсек ҮЦК-ны Өвөрхангай аймаг дахь салбараар дамжуулан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд 462 иргэн оролцож 188,3 сая төгрөгийн үнэт цаас худалдан авсан байна. Мөн хоёрдогч зах зээлээс 43 удаагийн арилжаагаар 2,9 сая төгрөгийн үнэт цаас худалдан авсан болно. Үнэт цаасны арилжаанд оролцогч болон сонирхогчдын тоо өмнөх оноос эрс өсөж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
100	Иргэдийн санхүүгийн суурь боловсролыг нэмэгдүүлэх, сургалт “Хуримтлалтай иргэн” аяныг хэрэгжүүлнэ.	1,5 сая төгрөг	Хуримтлалтай иргэдийн тоогоор	2021	Хуримтлалтай иргэдийн тоо 1000	Хуримтлалтай иргэд 15 хувиар өссөн байна.	Аймгийн Засаг даргын Тамгын газраас Монгол банктай хамтран зохион байгуулсан нийт 28 удаагийн 12 төрлийн өрхийн санхүүг нэмэгдүүлэх, хадгаламж, хуримтлал бий болгох сургалт, сурталчилгаа, төрөл бүрийн уралдаан тэмцээн, теле нэвтрүүлэг, нээлттэй хаалганы өдөрлөг, цахим болон танхимын сургалт, сурталчилгаа зэрэг арга хэмжээ зохион байгуулж 100 гаруй байгууллага, 2,6 мянган иргэн хамрагдсан нь өмнөх оноос 2,2 дахин өссөн. Нийт 81,9 мянган иргэн 169,1 тэрбум төгрөгийн хадгаламж эзэмшиж байна. Иргэд хувьцаа, үнэт цаас худалдан авах хэлбэрээр хуримтлал бий болгох аргыг илүү сонгох хандлагатай болсон байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
101	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд цэнхэр ягаан тасалбараар хувьцаа худалдан авсан иргэдийн хувьцааны ногдол ашгийг олгуулах, иргэдийг мэдээллээр хангана.	-	Мэдээллээр хангагдсан иргэдийн тоогоор	2021	-	Иргэдийг мэдээллээр хангасан байна.	Ногоон сум аяны хүрээнд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийнхөн орон нутагт ажиллаж цэнхэр ягаан тасалбараар хувьцаа худалдан авсан иргэдийн хувьцааны ногдол ашгийг шалган газар дээр нь лавлагаа гаргаж өгсөн. Нийт 400 гаруй иргэний регистрийн дугаараар шүүлт хийн, 250 харилцагчийн дансны дэлгэрэнгүй хуулга хэвлэн, дэлгэрэнгүй мэдээлэл, зөвлөгөө өгөн ажилласан. Хувьцааны дансаа шалгуулсан болон дансны хуулга хэвлүүлсэн харилцагчдын 80 гаруй хувь нь үнэт цаас, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан ба эдгээр иргэдэд мэдээлэл өгч ажилласан байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>Зорилт 2.4. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоот компани, аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулж, хариуцлагын тогтолцоог бий болгон аймгийн эдийн засагт оруулах үр өгөөжийг нэмэгдүүлэн орон нутгийн өмчийн менежментийг сайжруулна.</b>							
102	Орон нутгийн болон орон	-	Компанийн	2021	20 гишүүн	34 гишүүн	Орон нутгийн өмчит байгууллагуудад мөрдөгдөх, “Орон нутгийн өмчид

	нутгийн өмчийн оролцоотой компани, аж ахуйн нэгжүүдэд холбоотой журмуудыг шинэчлэн батлуулж, төлөөлөн удирдах зөвлөл, удирдах зөвлөл, удирдлагын багийг компаний засаглалын сургалтад хамруулж чадавхжуулах замаар компаний засаглалын менежментийг сайжруулна.		засаглалын сургалтад хамруулсан тоогоор				эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, шинэчилсэн үнэлгээ тогтоох журам”, “Төлөөлөл хэрэгжүүлэх журам”, “Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн. “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль шинэчлэгдэн батлагдах, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль” шинээр батлагдахаар хэлэлцэгдэж байгаатай холбогдуулан дээрх журмууд, орон нутгийн өмчит компаниуд, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын дүрмийг шинэчлэх ажлыг хойшлуулаад байна. Баянтээг түлш ОНӨХХК, Өв агро гурил тэжээлийн үйлдвэр ОНӨХХК-иудын дүрмийг хууль болон Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс гаргасан компанийн дүрмийн үлгэрчилсэн загварын дагуу боловсруулан, төлөөлөн удирдах зөвлөлийг хуулийн дагуу томилж батлуулсан. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
103	Орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын, санхүүгийн тайлангийн шинжилгээ, үйл ажиллагааны хяналт үнэлгээг бүх компаниудад хийж, ашигт ажиллагааг нэмэгдүүлж, ногдол ашгийн төлөвлөгөө баталж хэрэгжилтийг хангуулан, хариуцлага тооцох ажлыг хэрэгжүүлнэ.	10,2 сая төгрөг	Ногдол ашиг олгосон эсэх	2021	1 компани 25,3 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилах аар зарласан	1-2 компани, 30,0 сая төгрөг	Баянтээг ХК 2020 онд 1,7 тэрбум, 2021 онд 1,6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Төлөөлөн удирдах зөвлөлөөс тухайн жилүүдэд 25,3 сая төгрөгийн ногдол ашиг олгох төлөвлөгөө баталж, 2021 онд 25,3 сая төгрөгийн ногдол ашгийг олгосон ба 2022 онд дахин 25,3 сая төгрөгийн ногдол ашиг олгохоор зарласан байна. Засаг даргын зөвлөлийн хурлаар 7 компанийн үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлж, хөрөнгө оруулалтын өгөөж, төлбөрийн чадварын, үйл ажиллагааны, өрийн, ашигт ажиллагааны, бүтээмжийн зэрэг 6 багц шинжилгээг хийгээд байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
104	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 278 дугаар тогтоолын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулна.	20,0 сая төгрөг	Өмчийн улсын үзлэг, тооллогыг зохион байгуулсан байна.	2021	2016 оны суурь түвшин	100 хувь хамруулна.	Засгийн газрын 2020 оны Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай 9 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн өмчит 83 сан, 191 байгууллагын эд хөрөнгийг улсын үзлэг тооллогт хамруулан хөрөнгийн бүртгэл, хадгалалт хамгаалтад хяналт тавьж ажилласан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
105	Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл,	-	Цахимжуулалтын хувиар	2021	32,6 хувь	100 хувь цахимжуулна	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” 271 дүгээр тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой

	үнэлгээ, тайлан, орон нутгийн өмчийг данснаас хасах үйл ажиллагааг ил тод нээлттэй болгон, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.						хөрөнгөнд нэг байгууллагын хүсэлтийн дагуу 9 нэр төрлийн 42,4 сая төгрөгийн балансын үнэ бүхий үлдэгдэл өртөггүй хөрөнгийг 41,9 сая төгрөгөөр дахин үнэлж бүртгэлд тусгасан. Хөрөнгийн дуудлага худалдааг 1 удаа зохион байгуулж, 13 тээврийн хэрэгслийг худалдан борлуулж 74,9 сая төгрөг, хоёрдогч түүхий эдээр худалдсан хөрөнгөөс 1,9 сая төгрөг, шүүхийн шийдвэрээр улсын орлого болгосон 9,9 сая төгрөг, түрээсийн орлогоос 48,0 мянган төгрөг нийт 86,7 сая төгрөгийг аймгийн төсвийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд төвлөрүүлээд байна. Мөн 2021 оны “Өмч эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэх ажлыг зохион байгуулж, 189 байгууллагын гэрээг газар дээр нь дүгнэн, “Өмч эзэмшүүлэх гэрээ”-г шинэчлэн байгуулж, гарсан алдаа зөрчил, ололт амжилтын талаар зөвлөмж, дүгнэлтийг хүргүүлэн ажилласан.
<b>Хэрэгжилт-100 хувь</b>							
<b>Зорилт 2.5. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч худалдан авалтыг дэмжиж, худалдан авах ажиллагаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан, цахим хэлбэрээр зохион байгуулна.</b>							
106	Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтад Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> –ийн шинэчлэлийг ашиглан тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг цахим системд бүртгэж хэвшинэ.	-	Цахимжуулалтын хувиар	2021	65 хувь	100 хувь цахимжуулна	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэлтэй 22 төсөвт байгууллага тендер шалгаруулалтыг зохион байгуулж байгаа бөгөөд 2022 онд тухайн төсөл арга хэмжээний босго үнээс хамааруулан 85 хувийг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Гэрээний удирдлагын системд гүйцэтгэгч, нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийн 93 гэрээг байршуулаад байна. Цаашид цахим системийг ашиглах төсөвт байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, гэрээний удирдлагын системд гүйцэтгэгч, нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийн гэрээ болон үр дүнг тогтмол нийтэлж хэвших, цахим системээр хэлэлцээр хийх талаар заавар, зөвлөмжийг өгч мэргэшил арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллаж байна.
107	Төрийн худалдан авалтын үйл ажиллагаанд дотоодын давуу эрхийн зөрүү тооцох замаар орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.	-	Дотоодын давуу эрхийн зөрүү тооцсон аж ахуйн нэгжийн тоогоор	2021	4 аж ахуйн нэгж	7 аж ахуйн нэгж	Орон нутгаас ажиллах хүч авахаар хүсэлтээ ирүүлсэн 12 аж ахуйн нэгжийн 14,8 тэрбум төгрөгийн гэрээний дүнг 10 хувиар бууруулж дотоодын давуу эрхийн зөрүү тооцсон. Үүний үр дүнд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй 189 иргэн ажлын байраар хангагдаж, дотоодын үйлдвэрээс бараа авах хүсэлтээ ирүүлсэн 11 аж ахуйн нэгжийн 633,0 сая төгрөгийн гэрээний дүнд давуу эрхийн зөрүү тооцон вакум цонх, элс хайрга, ажлын хувцас, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо, эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл, дусал, шингэн, витамин зэрэг 20 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрүүдээс худалдан авсан байна.
108	Худалдан авах ажиллагаанд оролцож	-	Сургалтад хамрагдсан	2021	160 хүн	170 хүн	Төрийн худалдан авах ажиллагааны газар, Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төвтэй хамтран худалдан авах

	байгаа албан хаагчид, хөндлөнгийн төлөөллүүдийг мэргэшүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулж, бүх шатны худалдан авах ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, хөндлөнгийн хяналтыг сайжруулна.		хүний тоогоор				ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ сертификат олгох сургалтыг танхимаар 3 удаа зохион байгуулж 257 хүн хамрагдсанаас 185 хүн тэнцсэн байна. Мөн үнэлгээний хороонд иргэний төлөөлөл, ТББ-ын төлөөллийг оруулж хэвшсэн ба жил бүр Дэлхийн банкнаас сонгон шалгаруулж томилсон үнэлгээчдийн баг Орон нутгийн хөгжлийн санд жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, хяналтыг хийдэг. Уг үнэлгээгээр улсын дундаж 67,7, аймгийн дундаж 81 хувьтай байгаа ба 90-ээс дээш хувьтай 2, 80-аас дээш хувьтай 10, 70-аас дээш хувьтай 4, 65-аас дээш хувьтай 3 сум байна.
<b>Хэрэгжилт-100 хувь</b>							
<b>УУЛ УУРХАЙ ХҮНД ҮЙЛДВЭР</b>							
<b>Зорилт 2.6. Орон нутгийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах уул уурхайн орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.</b>							
109	Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг өргөтгөж, өөрийн болон зэргэлдээх аймгуудын сайжруулсан шахмал түлшний хэрэгцээг хангаж, агаарын бохирдлыг бууруулна.	УТ-2,1 тэрбум төгрөг	Шахмал түлшний хэрэглээг нэмэгдүүлсэн тоо хэмжээ	2021	462 тонн шахмал түлш үйлдвэрлэж, Арвайхээр сумын 300-400 өрхийн түлшний хэрэглээнд нэвтрүүлсэн.	Үйлдвэрийн өргөтгөлийн ажил хийгдэж, 7500 тонн шахмал түлш үйлдвэрлэж Арвайхээр сумын 5000-6000 өрхийн түлшний хэрэглээг хангана.	Баянтээг түлш ОНӨХХК нь 2022 онд 380 тонн шахмал түлш үйлдвэрлэж Арвайхээр сумын Эмтийн 2 дугаар багийн гэр хорооллын 500 айл өрхүүдийг шахмал түлшээр ханган ажиллаж байна. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2,1 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлж, шахмал түлш нөөцлөх агуулахын барилга угсралт, ажлын гүйцэтгэл 70 хувь, үйлдвэрийн өргөтгөл, олон үйлдэлт зуух, хатаалтын төхөөрөмжийн угсралт, гүйцэтгэл 40 хувь, 1000 ширхэг мэдээлэл дамжуулах угаар мэдрэгч төхөөрөмж суурилуулах ажлууд тус тус хийгдэж гүйцэтгэлээр нь санхүүжилтийг олгогдоод байна.
<b>Хэрэгжилт-70 хувь</b>							
<b>ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ</b>							
<b>Зорилт 2.7. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлж, сүргийн зохистой бүтцийг хадгалах замаар түүхий эд бүтээгдэхүүний экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.</b>							
110	Уянга сумын Таац, Жаргалант, Шуранга, Ар цармын сарлаг үхрийн биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох судалгааны ажлыг эхлүүлнэ.	5,0 сая төгрөг	Судалгааны ажлын гүйцэтгэлээр	2021	Судалгааны арга зүйг боловсруулж, батлуулахаар бэлтгэл ажил хийгдсэн	Судалгааны арга зүйг батлуулж судалгааны ажил эхлүүлсэн байна.	Уянга сумын сарлаг үхрийн биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох судалгааны арга зүйг ХХААГ, МААЭШХ-тэй хамтран боловсруулж, 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн их эрдмийн зөвлөлийн хурлаар батлуулж, судалгааны ажлыг эхлүүлэхэд бэлэн болоод байна.
<b>Хэрэгжилт 100 хувь</b>							
111	Бог малын үржүүлэг, технологийн ажил	-	Хөнгөлөлттэй зээлийн	2021	Мал үржүүлэг,	Малын үржүүлэг,	Түсэг хайрхан мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж Гучин-Ус сумын Монголын хоолойн 500 тэмээнд орон нутгийн



	<p>үйлчилгээний нэгжийг чадваржуулах зорилгоор хөнгөлөлттэй зээлийн болон төсөл хөтөлбөрт хамруулан, мал аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийг сургалтад хамруулж, мэргэшүүлнэ.</p>		<p>болон төсөл хөтөлбөрт хамрагдсан аж ахуй нэгжийн тоо</p>		<p>технологийн ажил үйлчилгээний 6 нэгж үйл ажиллагаа явуулж байна.</p>	<p>технологийн ажил үйлчилгээний шинээр байгуулагдсан 2 аж ахуй нэгж, мал аж ахуйн салбарын 25 мэргэжилтэн г чадваржуулж, дэмжлэг үзүүлсэн байна.</p>	<p>хөгжлийн сангийн 5,0 сая төгрөгөөр мөн Цохын булуу мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж Нарийнтээл сумын Тээлийн улаан нутгийн шилмэл хэвшлийн 3000 ямаанд 2,0 сая төгрөгөөр хавар, намрын ангилалтыг холбогдох сумын Засаг даргатай гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн.</p> <p>Онцгой байдлын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумын Засаг даргын Тамгын газар, мал аж ахуйн ЭЗЭН төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран Зүүнбаян-Улаан, Баруунбаян-Улаан, Богд, Гучин-Ус сумдын зудын эрсдэлийн менежментийн чадавхыг үнэлэх, гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах талаар талбайн үзүүлэх сургуулилтад сум бүрээс 50 малчин, Мал үржлийн тасгийн мэргэжилтнүүдийг хамруулсан.</p> <p>Цахим хөдөө аж ахуй бодлогын хүрээнд сумдын Хөдөө аж ахуйн тасаг болон мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжийн мэргэжилтнүүдэд Мал аж ахуйн нэгдсэн систем, сүргийн эргэлтийн программ, мал ялган тэмдэглэх бүртгэх систем, удам зүйн үнэлгээний программын талаар танхимын 1, цахим 3 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласан.</p> <p>ӨМӨЗО-ны Хөдөө аж ахуйн их сургууль, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамтран зохион байгуулсан “Монголын тал нутгийн экологийн хамгаалалт ба менежментийн цахим” 21 хоногийн сургалтад Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэнг хамруулаад байна</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт-70 хувь</b></p>
112	<p>Эрчимжсэн аж ахуй эрхлэгч болон шинээр аж ахуй байгуулах иргэд, аж ахуйн нэгжийг сургалт, мэдээллээр хангах, Төв, Булган, Сэлэнгэ, Улаанбаатар хотын ойролцоох эрчимжсэн аж ахуйд туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулна.</p>	5,0 сая төгрөг	<p>Сургалт, туршлага судлуулах арга хэмжээний тоогоор</p>	2021	-	<p>Малын байр, арчилгаа, маллагаа, тэжээл бэлтгэх арга барилыг эрчимжсэн аж ахуй эрхэлдэг 20-с доошгүй малчдыг газар дээр нь үзэж танилцуулсан байна.</p>	<p>Малын удмын сангийн үндэсний төв болон Дархан, Төв аймгийн эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагаатай Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтнүүд, сумдын Засаг дарга нарыг танилцуулж, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, хөдөө аж ахуйн салбарт анхаарах асуудал болон хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцсон.</p> <p>Мөн 2022 оны 10 дугаар сард 13 сумын 18 малчныг Төв аймагт малын хүчит тэжээлийн 2 үйлдвэр, Улаанбаатар хотод мах боловсруулах үйлдвэрүүдтэй танилцуулж, туршлага судлуулсан.</p> <p>НҮБ-ын ХХААБ-аас “Ногоон өрсөлдөх чадвартай, экспортын баримжаатай хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийн бодлогын стратеги” төвийн бүсийн хэлэлцүүлгийг Дархан-Уул аймагт зохион байгуулж уг арга хэмжээний үеэр Арвайхээр суманд эрчимжсэн аж ахуй эрхэлдэг 10 иргэнийг Дархан-Уул аймгийн малын удмын сангийн үндэсний цогцолбор болон Төв аймагт үйл ажиллагаа явуулдаг үхэр, тахиа, гахай, галууны аж ахуйтай танилцуулан туршлага судлуулсан.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт-100 хувь</b></p>

113	Бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авна.	50,0 сая төгрөг	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоогоор	2021	70 мянган га-д бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцсэн, орон нутгийн төсвөөр 3 худаг шинээр гарсан. 200 га бэлчээрийг чөлөөлсөн.	Бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготной 5,0 мянган га-д тэмцэх ажлыг зохион байгуулж, инженерийн хийцтэй гүн өрмийн 10 доошгүй худаг шинээр гаргаж ажилласан байна.	Хархорин, Есөнзүйл, Өлзийт, Бүрд, Баян-Өндөр сумд Малын тоо толгойн албан татварын болон ОНХС-ийн 120,0 сая төгрөгийн хөрөнгөөр 24 тн бактержуулсан будаа худалдан авч бэлчээрийн нийт 48,8 га талбайд микробиологийн аргаар үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгуулж, техник үр дүн 80 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн. Аймгийн хэмжээнд улсын төсвийн 501,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй гүн өрмийн 20 худаг, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Сант суманд 3 худаг гаргаж бэлчээрийн усан хангамж 34,5 мянган га-аар нэмэгдээд байна.  <b>Хэрэгжилт-100 хувь</b>
114	Бат-Өлзий сумын сарлагийн үхэр сүргийг бруцеллөз өвчнөөр эрүүл тайван бүс болохыг баталгаажуулах хариу арга хэмжээний дараах хоёрдугаар шатны үзлэг, шинжилгээг хийнэ.	23,0 сая төгрөг	Хариу арга хэмжээ авагдсан эсэх	2021	7000 үхэр	Шинжилгээг эр өвчлөл илэрсэн 59 өрхийн нийт 10000 мянган мал (үхэр, хонь, ямаа)-г шинжилгээнд бүрэн хамруулсан байна.	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөлтэй хамтран Бат-Өлзий сумын сарлагийн сүргийг бруцеллөз өвчнөөр тайван байдлыг баталгаажуулах ажлыг 2021 онд эхлүүлсэн. Энэ онд үхэр сүргийг бруцеллөз өвчингүй эрүүл тайван байдлыг тогтоох ажлын хүрээнд хариу арга хэмжээний дараах хоёрдугаар шатны үзлэг, шинжилгээний ажлыг Бат-Өлзий суманд хийж, Хархорин суманд бруцеллөз өвчнөөр тайван байдлыг баталгаажуулах ажлыг эхлүүлээд байна. Тандалт шинжилгээнд Бат-Өлзий сумын 4 багийн 55 өрхийн 55 сүүний дээж, Хархорин сумын 8 багийн 870 өрхийн 686 сүүний дээж цуглуулж, сүүний цагирган урвалын шинжилгээг Мал эмнэлгийн явуулын лаборатори газар дээр нь хийсэн. Шинжилгээгээр Бат-Өлзий сум 1, Хархорин сумын 4 дээжид эерэг дүн үзүүлсэн. Сүүний шинжилгээгээр эерэг дүн үзүүлсэн 5 өрхийн 137 үхрээс цусны дээж авч, ийлдсийг ялган МЭЛ-д РБУ-н урвалаар шинжилгээ хийхэд 3 өрхийн 6 дээж эерэг дүн үзүүлсэн тул хариу арга хэмжээ авч байна. Бат-Өлзий, Хархорин суманд Малаас хүнд дамжин халдварладаг бруцеллөз өвчний болон хэрэгжүүлж буй төслийн танилцуулгаар нийт 10 удаагийн сургалтаар 925 малчдад сургалт хийж, 950 ширхэг гарын авлага материал тарааж мэдээ, мэдээлэл хүргэж ажилласан байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
115	Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг нэмэгдүүлж, тариаланчдыг бордоо,	-	Эргэлтийн талбайн нэмэгдсэн хэмжээ,	2021	2021 онд 15,8 мянган га талбайд тариалалт	Эргэлтийн талбайг 100 аас доошгүй га-р	Өв агро гурил тэжээлийн үйлдвэр ОНӨХХК-д 2022 онд улсын төсвийн 200,0 сая төгрөгийн хөрөнгөөр трактор, дагалдах хэрэгслийн дэмжлэг үзүүлсэн. Баруунбаян-Улаан, Төгрөг, Хархорин сумдад үр тарианы комбайн,

	техникийн дэмжлэгт, хүнсний ногооны тариалан эрхлэгчдийг үрийн дэмжлэгт тус тус хамруулна.		дэмжлэг үзүүлсэн аж ахуй нэгжийн тоогоор		хийсэн.	нэмэгдүүлж, 25-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг үр, бордооны дэмжлэгт, 2-с доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг техникийн дэмжлэгт хамруулсан байна.	төмс, хүнсний ногооны трактор, хаман боогч, ангилан хадагч зэрэг дагалдах хэрэгслүүдийг ОНХС-ийн 92,0 сая төгрөг, иргэн, аж ахуйн нэгжийн 1047,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус тус шийдвэрлэж, тариаланчдад техникийн дэмжлэг үзүүлсэн. Төгрөг сум ОНХС-ийн хөрөнгөөр Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 50 га болон 3 га, Хархорин сумын Баяншанх бүл 1 га талбай услах хүчин чадалтай дуслын усалгааны системийг тус тус хөнгөлөлттэй нөхцөлөөр авч ашиглаж байна. Хаврын тариалалтад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хөнгөлөлттэй үнээр олгосон 10 төрлийн 579кг үрийг 19 сумын 200 гаруй тариаланч иргэн, аж ахуйн нэгжид хуваарилж, орон нутгийн төсвөөс хөнгөлөлттэй үрийн үнийн зөрүү 2,4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн сонгино, саримсны тариалалтыг нэмэгдүүлэхэд орон нутгийн төсвийн 5,0 сая төгрөгийн дэмжлэгээр 130кг саримсны үр авч, 16 суманд нийт 200кг үр хуваарилан тариалалт хийлгэсэн. Энэ онд аймгийн хэмжээнд нийт 14738,7 га-д тариалалт хийсэн. Үүнээс улаан буудай 9160 га, бусад үр тариа 56,7 га, төмс 440 га, хүнсний ногоо 281 га, малын тэжээл 2697 га, тосны ургамал 2104 га-д тус тус тариалсан. Ургац хураалт одоогийн байдлаар үр тариа 2153 га талбайгаас 2173 тн (23,3%), улаан буудай 2150 га талбайгаас 2170 тн (23,6%), бусад үр тариа 3 га талбайгаас 3,0 тн (5,2%), төмс 274,1 га талбайгаас 2551,6 тн (62,2%), хүнсний ногоо 206,9 га талбайгаас 1847,0 тн (73,6%), жимс, жимсгэнэ 11,4 га талбайгаас 12,7 тн, малын тэжээл 1285 га талбайгаас 3043 тн, (47,6%), тосны ургамал 200 га талбайгаас 30,0 тн (9,5%) ургац тус тус хураан авч, аймгийн ургац хураалтын дүн 43,9 хувьтай байна.
116	Сумдад төмс хүнсний ногооны зоройг шинээр барих, сэргээн засварлах, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлнэ.	-	Шинээр баригдсан зоорь, хүлэмжийн аж ахуйн шинээр нэмэгдсэн тоогоор	2021	92 зоорь, 182 хүлэмж	2-оос доошгүй зоорь, 3-аас доошгүй хүлэмжийн аж ахуй шинээр нэмэгдсэн байна.	Орон нутгийн хөгжлийн сан болон "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслийн 50 хувийн хөрөнгө оруулалтаар Бат-Өлзий, Баян-Өндөр, Төгрөг, Нарийнтээл, Есөнзүйл сумдад 80,0 сая төгрөгийн санхүүжилтээр 50 тонны зоорь, Богд, Баруунбаян-Улаан сумдад 55,0 сая төгрөгийн санхүүжилтээр 30 тонны зоорь тус тус ашиглалтад орлоо. Тайваны хүүхдийг ивээх сангийн хөрөнгө оруулалтаар "Өрхийн тариалан бизнес хөгжил" төрийн бус байгууллага Тарагт, Уянга, Зүүнбаян-Улаан сумдад 50м <sup>2</sup> багтаамж бүхий нарлаг хүлэмж ашиглалтад оруулсан. Аймгийн хэмжээнд нийт 3307 тн багтаамж бүхий 105 төмс, хүнсний ногооны зоорь, 1140м <sup>2</sup> бүхий өвлийн 3 хүлэмж, 10866м <sup>2</sup> бүхий нийлэг хальсан 203 хүлэмж үйл ажиллагаа явуулж байна.

117	Арвайхээр сумын Дайрга, Хужиртын Цуврай, Тарагт сумын Хүрэмт, Өлзийт сумын Хүйс, Баруунбаян-Улаан сумын Дөхөм, Бүрд сумын Их боригтойн тариалангийн талбайн услалтын системийн засвар шинэчлэлийн зураг төсвийг хийлгэх ажлыг эхлүүлнэ.	Зураг төсөв 287,0 сая төгрөг	Услалтын системүүдийн зураг төсөв хийгдсэн эсэх	2021	Услалтын системүүдэд мэргэжлийн байгууллага ар үнэлгээ хийлгэж засвар шинэчлэлийн үнэлгээ хийлгэсэн.	Услалтын системүүдийн зураг төсөв хийлгэх	Услалтын системүүдийн ашиглалтыг сайжруулах, сэргээн засварлахаар Монгол-Ус" ТӨҮГ-тай хамтран Арвайхээр сумын Дайрга, Тарагт сумын Хүрэмт, Хужирт сумын Цуврай, Нарийнтээл сумын Арцын гол, Баруунбаян-Улаан сумын Дөхөм, Өлзийт сумын Хүйс, Бүрд сумын Боригдой, Гучин-Ус сумын Аргуйн голын услалтын системүүдийн нөхцөл байдлыг газар дээр нь үзэж, эвдрэл гэмтлийг тодорхойлон, тус газраас зураг төсөв хийхэд шаардагдах төсөв болон тэмдэглэлийг ирүүлсэн. Дээрх сумын Засаг дарга нарт төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны малын тоо толгойн албан татварын орлогоос хөрөнгийг шийдвэрлэх талаар албан бичгээр чиглэл өгсөн. <b>Хэрэгжилт-50 хувь</b>
118	Сум хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж, хугацаа хэтэрсэн зээлийн өрийг барагдуулах арга хэмжээ зохион байгуулна.	-	Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлийн буурсан хувиар	2021	1156 иргэн, аж ахуйн нэгж 5,1 тэрбум зээлийн үлдэгдэлтэй	Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 360 иргэн, аж ахуй нэгжийн 1,4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгааг 30 хувь бууруулна.	Улсын Их Хурлын 2021 оны 40 дүгээр тогтоолоор "Сум хөгжүүлэх сан"-г "Хоршоог хөгжүүлэх сан" болгон өөрчилсөн. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" А/243 дугаар тушаалаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих" журамд өөрчлөлт орсон. Дээрх шийдвэрүүдийн хүрээнд "Сум хөгжүүлэх сан"-ийн зээл олголтыг зогсоож, эргэн төлөлт, татан төвлөрүүлэлт, сангийн үлдэгдэлд хяналт үнэлгээ хийж, сумдын удирдлага холбогдох мэргэжилтнүүдийг арга зүйн заавар зөвлөгөөгөөр хангаж ажилласан. Мөн Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн программд холбогдон, хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлтэй иргэн, аж ахуйн нэгжүүдийн өрийг барагдуулах, ангилал солих чиглэлээр хамтран ажиллаж байна. Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны эхний 08 сарын байдлаар 1,1 тэрбум төгрөг болж (268,9) сая төгрөгөөр буюу 18 хувиар буурсан дүнтэй байна. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
119	Цахим хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бий болгох, загвар хоршоо байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	-	Загвар хоршоо байгуулагдсан эсэх	2021	Аймгийн хэмжээнд 112 хоршоо бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна.	1 загвар хоршоо байгуулагдсан байна.	Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн "Хоршооллын хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай" 81 дүгээр тогтоолын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны захирамжаар "Хоршооны хөгжлийг дэмжих жил"-ийн төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, биелэлт 90 хувьтай болоод байна. Хөдөө аж ахуйн бирж ХХК-тай хамтран аймгийн түүхий эдийн агуулах бүхий иргэн, аж ахуйн нэгжүүдэд итгэмжлэгдсэн агуулахын үйл ажиллагааг идэвхжүүлэх, сумдын агуулахад итгэмжлэл олгох, хоршоодыг биржийн байнгын бус гишүүнээр бүртгэх зэрэг сургалт, арга хэмжээг зохион байгуулсан. Үүний үр дүнд аймгийн хэмжээнд түүхий эдийн 17 агуулах байнгын бус гишүүнээр гэрээ хийж, Арвайхээр сумын Түмний буян далай, Бат-Өлзий сумын Малчдын хамтын хүч хоршоод биржийн арилжаанд оролцох эрх авсан. Монгол улсын Засгийн газраас зарласан "Хоршооны хөгжлийг дэмжих жил"-

							ийн хүрээнд Арвайхээр сумын Түмний буян далай, Бат-Өлзий сумын Малчдын хамтын хүч хоршоодыг загвар хоршоо болоход дэмжлэг үзүүлж, Хэнтий, Сүхбаатар аймгуудын загвар хоршоодын туршлагыг судлуулж, мэргэжил арга зүйгээр хангасан. Загвар хоршоогоор баталгаажуулах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу холбогдох байгууллагад уламжлаад байна. Мөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг орон нутагт бий болгоход хоршоодын оролцоог идэвхжүүлж, аймгийн хоршоологчид болон сумдын удирдлага, хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийг оролцуулан дээрх 2 хоршоод туршлага судлах үзүүлэх сургалтыг зохион байгуулсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
120	Сумдад малын гаралтай түүхий эдэд түшиглэсэн үйлдвэр, цех байгуулах, стандартын шаардлага хангасан мал нядалгааны цэг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.	-	Мал нядалгааны цэгт дэмжлэг үзүүлсэн байдлаар	2021	Стандартын шаардлага хангасан мал нядалгааны цэг-6	Малын гаралтай түүхий эдэд түшиглэсэн үйлдвэр, цех байгуулах, стандартын шаардлага хангасан мал нядалгааны цэг бий болгох санал санаачилга гаргасан иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлсэн байна.	Хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийн сургалт семинарыг 03 дугаар сарын 16-17-нд зохион байгуулж, малын гаралтай түүхий эдэд түшиглэсэн үйлдвэр, цех байгуулах, стандартын шаардлага хангасан мал нядалгааны цэг бий болгох санал санаачилга гаргасан иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх талаар арга зүйн зөвлөгөө хүргэсэн. Бат-өлзий суманд малын арьс шир боловсруулах, анхан шатны тордолт хийх бага оврын цех байгуулагдсан. Арвайхээр сумын "Түмний буян далай хоршоо" Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр мал нядалгааны цехээ өргөтгөх төсөл хүргүүлж, журмын дагуу 4 дэх шатны шалгуурыг ханган, аймгийн дэд хорооны хурлаар хэлэлцүүлэн Жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлээд байна. <b>Хэрэгжилт 30 хувь</b>
121	Арвайхээр сумын хүн амын хаврын улирлын махны хэрэгцээг хангах нөөц бүрдүүлнэ.	ОНТ 150,0 сая төгрөг	Улирлын нөөц бүрдүүлэх махны хэмжээ 20.0 тн- оос доошгүй байх	2021	Арвайхээр суманд 2021 оны хаврын улиралд 24,2 тн хонины махны нөөц бүрдүүлсэн	Зах зээлийн үнээс хямд үнээр иргэдэд нийлүүлсэн байна.	Төв суурин газрын хүн амын махны үнийг тогтворжуулах, махны нөөц буурах үед үүсэх үнийн зохиомол хөөргөдлөөс хамгаалах, улирлын нөөц бүрдүүлэхэд Арвайхээр суманд махны нөөц бэлтгэх тендер зарлан, 20,0 тн хонины мах нөөцлөн, нийлүүлсэн. Нөөцийн махыг Арвайхээр сумын баг тус бүрийн хүнсний дэлгүүрээр дамжуулан, зах зээлийн үнээс 3000-3500 төгрөгөөр хямд үнэтэйгээр иргэдэд нийлүүлсэн. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
122	Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл	19,0 сая төгрөг	Тоног төхөөрөмжөө	2021	МЭҮН 48	Сумдын Мал эмнэлгийн 19	Мал эмнэлгийн нэгдсэн системийг орон нутагтаа нэвтрүүлэн үйл ажиллагааг жигдрүүлж, Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн

	ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлгийн гэрчилгээг бичих, баталгаажуулах, хянахад шаардлагатай төхөөрөмжөөр сумдын тасгийн малын эмч, мэргэжилтнүүдийг хангана.		р хангагдсан эсэх		Мал эмнэлгийн газрын мал эмнэлгийн улсын байцаагч нарт -2	эмч, мэргэжилтнүүдийг плантаар хангасан байна	үйлчилгээний нэгжийн эмч нарт мэдээлэл оруулах, хянахад зайлшгүй шаардлагатай таблет төхөөрөмжөөр хангах ажлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлвэрийн яам, Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж, “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-өөс 48 аж ахуйн нэгжийг плантаар хангаад байна. Мөн Мал эмнэлгийн ерөнхий газраас аймгийн Мал эмнэлгийн улсын ахлах байцаагч, Нарийнтээл сум дахь Мал эмнэлгийн хорио цээр хяналтын цэгийн Мал эмнэлгийн улсын байцаагч нарт Мал эмнэлгийн нэгдсэн системд оруулсан мэдээллийг хянан шалгах таблет олгосноор Мал эмнэлгийн газрын байцаагч сумдын Мал эмнэлгийн гэрчилгээний бичилтэд шуурхай хяналт тавих, зөрчлийг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд мал эмнэлгийн мэдээллийн нэгдсэн системд гэрчилгээ бичих, урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын гүйцэтгэл бүртгэх, дуудлага, үзлэг хийсэн мэдээллээ бүртгэх нөхцөл боломжоор хангагдаад байна. Одоогийн байдлаар 48 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж Мал эмнэлгийн нэгдсэн системд 4924 удаа мал, малын гаралтай бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ бичиж, 8,3 сая (давхардсан тоогоор) малд үзлэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлж, 3376 дуудлагад үйлчилсэн бүртгэлтэй байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
--	---	--	-------------------	--	---	---	--

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА**

**Зорилт 2.8. Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөлтийн дагуу дэд бүтцийг хөгжүүлэх замаар орон нутагтаа тав тухтай ажиллах амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.**

123	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг тус тус боловсруулна.	750,0 сая төгрөг	Төлөвлөгөө боловсруулсан тоогоор	2021	Аймгийн ГЗБЕТ 2006-2020 онд хэрэгжиж дууссан. Хархорин, Тарагт, Төгрөг сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийгдсэн.	Нийт 16 төлөвлөгөө	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахаар орон нутгийн хөгжлийн сангийн 750,0 сая хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн. Энэ онд санхүүжихээр 150,0 сая төгрөг тусгагдсан, зөвлөх үйлчилгээний тендер зарлагдан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулаад байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
124	Бүрд, Есөнзүйл сумдын хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.	-	Төлөвлөгөө хийгдсэн эсэх		Ерөнхий төлөвлөгөөн ий хугацаа дууссан	Ерөнхий төлөвлөгөө хийгдсэн байна.	Хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр Бүрд сум орон нутгийн сангийн хөрөнгөд 35,0 сая төгрөг, Есөнзүйл сум орон нутгийн сангийн хөрөнгөд 45,0 сая төгрөгийг тусгаж, зөвлөх үйлчилгээний тендерийг тус бүр 2 удаа зарлахад гүйцэтгэгч оролцоогүй байна. <b>Хэрэгжилт-50 хувь</b>
125	Арвайхээр суманд	12,0	Ашиглалтад	2021		150 айлын	Энэ онд иргэн Ж.Самданжигмэдийн 20 айлын орон сууцны барилга,

	хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 150 айлын нийтийн орон сууцны барилгын ажлыг дуусгаж ашиглалтад оруулна.	тэрбум төгрөг	орсон орон сууцны тоогоор			нийтийн орон сууцны шинээр ашиглалтад орсон байна.	иргэн Г.Төмөрбаатарын 15 айлын орон сууцны барилга, Кинг тауны 34 айл, Амаржаргалын 15 айл, Хархорин сумын Орхон тауны 29 айл, Өв гурван Лут ХХК-ийн 16, 20 айлын орон сууцны барилгууд тус тус байнгын ашиглалтад орж, нийт 7 орон сууцны 146 айлын барилга байгууламж ашиглалтад ороод байна. <b>Хэрэгжилт -100 хувь</b>
126	Арвайхээр суманд нийтийн орон сууцны гадна талбайн ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай барьж байгуулна.	-	Гадна тохижилтын ажил хийгдсэн эсэх	2021	-	Гадна талбай, хүүхдийн тоглоомын талбай баригдаж, ногоон байгууламж нэмэгдсэн байна.	Нийт ашиглалтад орсон 7 орон сууцны гадна тохижилтын ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу автомашины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, явган зам, гэрэлтүүлгийн хамт хүлээн авч тухайн орон сууцад амьдарч байгаа айл өрхийн аятай, тухтай амьдаргах орчин нөхцөл бүрдсэн байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
127	Төрийн албан хаагчид, өндөр настан, бага, дунд орлоготой иргэдэд чиглэсэн түрээсийн орон сууцны зураг төсвийг хийлгэнэ.	-	Зураг төсөв хийгдсэн эсэх	2021	0	60 айл	Төрийн албан хаагчид, өндөр настан, бага, дунд орлоготой иргэдэд чиглэсэн 60 айлын түрээсийн орон сууцны зураг төсөл, томсгосон төсвөөр 5,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр Цесда ХХК-иас хүлээн авсан. <b>Хэрэгжилт-100</b>
128	Өндөр насжилттай буюу 2000 оноос өмнө ашиглалтад орсон олон нийтийн барилга байгууламжуудыг паспортжуулах ажлыг эхлүүлнэ.	-	Паспортжуулсан барилгын тоогоор	2021	4	5	Энэ онд Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулийн барилгуудыг паспортжуулж, дүгнэлт гаргуулахаар ШУТИС-ийн БАС-ийн оношилгоо, зураг төсөл, судалгааны Реконстракшн төвтэй гэрээ байгуулаад байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
129	Төгрөг суманд ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж шинээр барих зураг төслийг боловсруулна.	50,0 сая	Зураг төсөв боловсруулагдсан эсэх	2021	0	Зураг төсөв боловсруулагдсан байна.	Төгрөг сумын цэвэр усны байгууламж, шугам сүлжээний ажлын зураг төсвийг гүйцэтгүүлэн хүлээн авч, барилга угсралтын ажил эхэлсэн, гүйцэтгэл 50 хувьтай хийгдэж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
130	Бат-Өлзий, Хужирт Уянга суманд сумын төвийн шинэчлэл төслийг хэрэгжүүлэх зураг төсвийг гүйцэтгүүлж, ажлыг эхлүүлнэ.	-	Ажлын гүйцэтгэлээр	2021	0	Зураг төсөв боловсруулагдаж ажил эхэлсэн байна.	“Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төслийн хүрээнд Бат-Өлзий, Уянга сумдын төслийн гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулан, ажлаа эхлүүлсэн. Хужирт суманд хэрэгжиж буй төслийн ажлын гүйцэтгэл 95 хувьтай явагдаж байна. Дээрх ажлууд ирэх онд бүрэн ашиглалтад орно. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
131	“Нүхэн жорлон угаадасны нүх Техникийн	50,0 сая төгрөг	Шаардлагад нийцсэн	2021	330 ширхэг	380 ширхэг	Хувийн хөрөнгө оруулалтаар 3 айл Техникийн шаардлага MNS 5924: 2015 стандартын шаардлагад нийцсэн нүхэн жорлонг суурилуулсан.

	шаардлага MNS 5924:2015” стандартын шаардлагад нийцсэн нүхэн жорлонг суурилуулах ажиллагааг үргэлжлүүлнэ.		нүхэн жорлонгийн тоогоор				Мөн аялал жуулчлалын гол маршрут дагуу эко ариун цэврийн 17 суултуур бүхий зөөврийн эко ариун цэврийн 3 байгууламжийг суурилуулан ашиглалтад оруулаад байна. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
132	Хужирт, Нарийнтээл сумдын үерийн далан сувгийн зураг төсвийг хийлгэнэ.	-	Далан сувгийн зураг төсөв хийгдсэн эсэх	2021	0	Зураг төсөв хийгдсэн байна.	Хужирт сумын 11 км үерийн далан сувгийн ажлын зураг төслийг гүйцэтгүүлэхээр зургийн даалгаврыг батлаад байна. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
133	Байгууллага, аж ахуйн нэгжүүдийг дулааны тоолууржуулах ажлыг дулааны үнэ тарифтай уялдуулж хэрэгжүүлнэ.	-	Дулааны тоолуур суурилуулсан барилгын тоогоор	2021	6	120	Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдэд дулааны хэрэглээг хэмжүүрээр тооцох тарифын аргачлал, зөвлөмжийг хүргүүлэх ажлыг зохион байгуулсны дагуу Хархорин сумын “өгөлдөр суурь констракшн ХХК, Бат-Өлзий сумын Арвин бумба илч ХХК, Өлзийт, Гучин-Ус сумдад үйл ажиллагаа явуулж байгаа Илч кассандра ХХК, Нарийнтээл сумын Эх нутгийн буян ХХК, Хайрхандулаан сумын Мэйжикал даймонд ХХК-иуд дулааныг хэмжүүрээр тооцох тарифыг батлуулсан. Шинээр барих барилгуудын ажлын зургийн даалгаварт дулааны тоолуур тавихыг тусган хянан баталж байна. Энэ онд ашиглалтад орсон Богд сумын Эрүүл мэндийн төв, Өлзийт сумын 240 хүүхдийн сургуулийн барилгад дулааны тоолуур суурилуулаад байна. Аймгийн хэмжээнд одоогийн байдлаар нийт 10 байгууллагад дулааны тоолуур суурилуулсан байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>Зорилт 2.9. Эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой орон нутгийн дэд бүтцийг бий болгож, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.</b>							
134	A0301, A0302 улсын чанартай авто замын дагуух Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Тарагт, Хайрхандулаан сумдыг хатуу хучилттай авто замаар холбох, “Арвайхээр-Хужирт-Бат-Өлзий”, “Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан”, “Арвайхээр-Баянгол-Сайхан Овоо-Цогт овоо”, “Арвайхээр-Гурван тэс-Шивээхүрэн”, “Чойр-Мандалговь-Арвайхээр”,	51,6 тэрбум төгрөг	Ажлын гүйцэтгэлээр Зураг төсөв хийлгэсэн эсэх	2021		A0301 улсын чанартай авто замаас Есөнзүйл сумын төвийг холбох, Хужирт-Бат-Өлзий сумдыг холбох хатуу хучилттай	Хужирт-Бат-Өлзий сумдыг холбох хатуу хучилттай автозамын ажил эхэлж 10 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байна. A0301 улсын чанартай автозамаас Есөнзүйл сумын төвийг холбох ажлын зураг бүрэн хийгдэж Дэлхийн банкны төслөөр гүйцэтгүүлэхээр санал хүргүүлээд байна. “Чойр-Мандалговь-Арвайхээр” чиглэлийн хэвтээ тэнхлэгийн автозамын зураг төсвийг Эм Си Пи Си Жи Ар ХХК гүйцэтгэж Зам тээврийн хөгжлийн яаманд хүлээн авсан. <b>Хэрэгжилт-70 хувь</b>



	А0302 улсын чанартай авто замаас Баянтээг баг хүртэлх 22 километр авто замуудыг шинээр барих зураг төсвийг хийлгэж, барьж эхлүүлнэ.					авто замын ажлыг эхлүүлнэ. А0302 улсын чанартай авто замаас Баянтээг баг хүртэлх 22 километр авто замын зураг төсвийг хийлгэх	
135	Арвайхээр, Хархорин сумдын доторх авто замын өргөтгөл, шинэчлэл хийнэ.	1,5 тэрбум	Гүйцэтгэлийн хувиар	2021	-	Ажил эхэлсэн байна	Арвайхээр, Хархорин сумдад 1,15 км урттай хатуу хучилттай автозам, явган болон дугуйн зам, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн хамт ашиглалтад орсон. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
136	Хөдөөгийн багт болон зарим сумдын үүрэн холбооны сүлжээг өргөтгөн, Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсийн холбооны шугам сүлжээний худаг, сувагчлалын ажлыг хийнэ.	5,0 тэрбум төгрөг	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2021	-	3	Бат-Өлзий, Уянга, Хархорин, Богд, Хужирт, Зүүнбаян-Улаан, Гучин-Ус, Өлзийт сумдын 17 байршилд Юнител ХХК үүрэн холбооны сүлжээг өргөтгөсөн. Уянга, Баянгол, Өлзийт, Хужирт, Тарагт, Хархорин, Бүрд, Арвайхээр, Зүүнбаян-Улаан сумдын 10 байршилд Мобиком ХХК үүрэн холбооны сүлжээг өргөтгөсөн. Уянга сумын Жаргалант багийг шилэн кабельд холбох ажлыг Бүх нийтийн үүргийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэж, ашиглалтад оруулаад байна. Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсийн холбооны шугам сүлжээний худаг, сувагчлалын ажлын зураг хийгдсэн бөгөөд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд тусган цахимаар санал авч эрэмбэлүүлэхээр тусгасан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
137	Тарагт, Хайрхандулаан, Төгрөг сумдын цахилгаан дамжуулах шугамын өргөтгөл шинэчлэл хийнэ.	200,0 сая төгрөг	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2021	-	3	Тарагт, Хайрхандулаан, Төгрөг сумдад улсын төсвийн хөрөнгөөр 10/0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл хийгдэж, ашиглалтад оруулсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
138	Арвайхээр сумын гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний	1,5 тэрбум төгрөг	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2021	272	600	Арвайхээр сумын 10, 11 дүгээр багийн гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний холболтын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байна.

холболт хийнэ.							<b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>Бүлгийн дүн 90,68 хувь</b>							
<b>ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>							
<b>Зорилго: Нутгийн захиргааны байгууллагын бүх түвшинд засаглалын хариуцлага, шударга ёсыг мөрдүүлж, цахим технологид тулгуурласан, иргэдэд тэгш боломж олгодог, оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлнэ.</b>							
<b>ЁС ЗҮЙ, ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА</b>							
<b>Зорилт 3.1. Төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, давхардлыг арилгах, үйл ажиллагааны уялдааг хангах замаар үр ашигтай бүтэц бүхий мэргэшсэн чадварлаг, тогтвортой, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлнэ.</b>							
139	Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн шинжилгээ, хүний нөөцийн аудит хийж, давхардал, хийдлийг арилган, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоно.	-	Чиг үүргийн шинжилгээ хийсэн байгууллагын тоо	2021	-	Төрийн захиргааны 3-4 байгууллагад чиг үүргийн шинжилгээ, хүний нөөцийн аудит хийсэн байна.	Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдэд чиг үүргийн шинжилгээ хийж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/26 дугаар тушаалаар орон тооны дээд хязгаарыг 46 байхаар тогтоож, албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр хянуулан, батлуулаад байна. Мөн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Боловсрол, шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтэц, чиг үүрэгт шинжилгээ хийж, Боловсрол, шинжлэх ухааны газрыг 24, Эрүүл мэндийн газрыг 41, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албыг 14, Биеийн тамир, спортын газрыг 15 орон тоотой байхаар тус тус тогтоож, байгууллагын дүрмийг шинэчлэн баталсан. Бүтэц орон тоонд өөрчлөлт орсонтой холбоотой аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах чиглэлээр холбогдох журам, заавар, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч, Төрийн албаны зөвлөлөөр хянуулан батлах зөвшөөрөл авч, томилох эрх бүхий этгээдийн шийдвэрээр баталгаажууллаа.
<b>Хэрэгжилт-100 хувь</b>							
140	“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийг тогтвортой ажиллах баталгааг хангаж, чадахуйн зарчимд суурилж, төрийн албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ.	10,0 сая төгрөг	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц Хамрагдсан албан хаагчдын тоо	2021	-	Нийт төрийн албан хаагчдын 20-оос доошгүй хувь хамрагдсан байна.	Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/561 захирамжаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах” тухай аймгийн дэд хөтөлбөрийг баталж, төрийн албан хаагчийг сургах, хөгжүүлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, ажлын идэвх санаачилга, гүйцэтгэл үр дүн, сахилга, хариуцлага, ёс зүйг харгалзан үнэлж, дүгнэн тэднийг шагнаж урамшуулах, амьдралд нь бодитой дэмжлэг үзүүлж нийгмийн баталгааг хангах зорилтыг дэвшүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Тайлант онд Удирдлагын академийн эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц

						<p>сургалтад 8, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 6, шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад 7 төрийн албан хаагч хамрагдсан.</p> <p>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 цахим вэбинар сургалтад төрийн албан хаагчдыг 7 хоног бүр тогтмол хамруулж байгаа бөгөөд тайлант хугацааны байдлаар давхардсан тоогоор 2180 албан хаагч тус сургалтад хамрагдаад байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслөөс зохион байгуулсан “Нутгийн удирдлагын байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах” сургалтад нутгийн захиргааны байгууллагын удирдлага, мэргэжилтэн нийт 180 гаруй албан хаагчдыг хамрууллаа.</p> <p>Мөн аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагийн хүний нөөцийн мэргэжилтнүүдэд 14 хоног тутам уулзалт, сургалтыг зохион байгуулж, мэргэшил, арга зүйн зөвлөгөө мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын тусгай шалгалтад төрийн жинхэнэ албан тушаалд ажиллаж байгаа 4 албан хаагч, төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтад төрийн жинхэнэ албан тушаалд ажиллаж байгаа 11 албан хаагч тус тус тусгай шалгалт өгч тэнцэн чадахуйн зарчмын дагуу шатлан дэвшиж томилогдсон.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 44.1 дэх хэсэгт заасны дагуу албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангасан 15 төрийн жинхэнэ албан хаагчийг хууль, журмын хүрээнд шилжүүлэн ажиллуулж байна.</p> <p><b>Хэрэгжилт-100 хувь</b></p>	
141	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, цогц чадамж, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон дүгнэж, мэдээллийн санг бүрдүүлнэ.	-	Ёс зүйн зөрчлийн тоо Үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	2021	-	Ажлын гүйцэтгэл, үр дүн, ёс зүй, хариуцлагын үзүүлэлтээр үнэлсэн байна.	<p>Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 218 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг хагас болон бүтэн жилээр үнэлж, үнэлгээнд тулгуурлан холбогдох албан хаагчдыг сургалтад хамруулах, урамшуулах, сануулах арга хэмжээг авч, төрийн албан хаагчдын мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна.</p> <p>Энэ онд нийт 59 байгууллагад 244 төрийн албан хаагч ёс зүйн зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд Боловсрол, шинжлэх ухааны газрын дэргэд аймгийн багш нарын “Ёс зүйн зөвлөл”-ийг 9 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгууллаа.</p> <p><b>Хэрэгжилт-100 хувь</b></p>
142	Төрийн албаны сонгон	-	Төрийн албан	2021	-	Төрийн	Тайлант хугацааны байдлаар төрийн жинхэнэ албаны удирдах албан

	шалгаруулалт, хүний нөөцийн томилгоо, сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой шийдвэрийг бүх байгууллагад ил тод, нээлттэй болгоно.		хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын зөрчлийн үзүүлэлтийг бууруулсан байдал (тоо)			захиргааны байгууллагын тоогоор	<p>тушаалын 7 (давхардсан тоогоор) сул орон тоо, төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын 204 (давхардсан тоогоор) сул орон тоог нөхөх тусгай шалгалт, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 10 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт тус тус зарлагдсан.</p> <p>Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд нөөцөд бүртгэгдсэн 43 иргэн тусгай шалгалт өгч тэнцэн төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон.</p> <p>Ёс зүйн зөвлөлийн чадавхжуулах 3 удаагийн цахим сургалтад ёс зүйн зөвлөлийн гишүүд, хүний нөөцийн мэргэжилтнүүдийг хамрууллаа.</p> <p>Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсэн талаар 1 иргэн, цалин бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан нь хууль бус шийдвэр хэмээн 2 төрийн албан хаагч гомдол, маргаан ирүүлснийг хуулийн хугацаанд холбогдох журмын дагуу шийдвэрлэн, зөрчлийг арилгууллаа.</p> <p>Энэ онд нийт 25 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан бөгөөд холбогдох дүрэм, журмын хүрээнд ёс зүйн зөвлөлөөс 3 албан хаагчид уучлал хүсэх, 10 албан хаагчид сануулах дүгнэлт гаргасан бол 2 албан хаагч сайн дураараа албан тушаалаас чөлөөлөгдөх ёс зүйн хариуцлага хүлээсэн.</p> <p>Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, багшийн ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журмын дагуу 10 албан хаагчид сануулах, цалин бууруулах ёс зүйн зөрчлийн хариуцлага хүлээлгэсэн.</p> <p>Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчлийн мэдээг Өвөрхангай аймгийн uvurkhangai.mn цахим хуудаст байршуулж, Авлигатай тэмцэх газар болон Төрийн албаны зөвлөлд тайланг хүргүүлэн ажиллаж байна.</p> <p style="text-align: center;"><b>Хэрэгжилт-100 хувь</b></p>
143	Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаатай холбоотой шийдвэрийн эрх зүйн үндэслэлд тогтмол хяналт тавьж, зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.	-	Зөрчилтэй шийдвэрийн тоо буурсан эсэх	2021	-	Зөрчилтэй шийдвэрийн тоог 70 хувиар бууруулна.	<p>Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаатай холбоотой шийдвэрийн эрх зүйн үндэслэлд холбогдох чиг үүрэг бүхий бодлогын хэлтсээс тогтмол хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд зөрчилтэй болон эрх зүйн үндэслэлгүй шийдвэрийн төслийг дахин хянаж, зөрчлийг арилгасны дараа эцэслэн баталгаажуулах үүрэг чиглэлийг холбогдох байгууллагад өгч байна. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, гэрээ байгуулах, хөдөлмөрийн дотоод журмыг боловсруулахад анхаарах асуудлаар төрийн байгууллагуудын хүний нөөцийн мэргэжилтнүүдэд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудалд тухай бүр арга зүйн зөвлөгөө мэдээллээр ханган ажиллаж байна. Арвайхээр, Бат-Өлзий, Баян-Өндөр, Бүрд, Нарийнтээл, Сант, Өлзийт нийт 7 сумын 568 шийдвэр, аймгийн Насан туршийн боловсролын төв, Гэр бүл, хүүхэд,</p>

							залуучуудын хөгжлийн газар, Статистикийн хэлтэс, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Арвайхээр сумын сургуулийн өмнөх боловсролын байгууллага нийт 23 төрийн байгууллагын 1273 шийдвэрт хяналт үнэлгээ хийж, шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг хангуулах зөвлөмж, чиглэлийг хүргүүлэн ажиллалаа. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>3.2. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулж, төрийн үйлчилгээг хялбаршуулан, зардал хэмнэх тогтолцоонд шилжүүлж, төрийн албан хаагчийн ажиллах орчинг сайжруулна.</b>							
144	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд "Call center" үйлчилгээг бүрэн нэвтрүүлж, төрийн байгууллагуудын интернэтийн хурд, чанарыг сайжруулан, мэдээлэл технологийн ажилтныг чадавхжуулна.	20,0 сая төгрөг	-Төрийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн цахим үйлчилгээний тоо -Цахимаар үйлчилгээ авсан иргэдийн тоо	2021	2020 e-mongolia, операторын 185 үйлчилгээ	Цахим шилжилт, тоног төхөөрөмжийн шинэчлэлт	"Call Center" үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд 2022 онд системийн суурин компьютер, тус бүрийн чихэвч, микрофон, дуудлага хүлээн авах утасны аппарат зэрэг техник, тоног төхөөрөмжийг худалдан авч угсарсан бөгөөд програм бичигдэх шатандаа явж байна. Тайлант онд төрийн байгууллагуудын интернэтийн хурд, чанарыг сайжруулахад сумдын Засаг даргын Тамгын газарт орон нутгийн төсвөөс 34,2 сая төгрөгийг хуваарилж, эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, соёлын төв зэрэг төсөвт байгууллагуудын интернетийн хурдыг 10mbps болгон нэмэгдүүлж, үйлчилгээний чанар, үр дүнг сайжрууллаа. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Үндэсний дата төв, "И-Монгол" академитай хамтран сумдын Засаг даргын Тамгын газрын оператор ажилтнууд, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлагийн мэдээлэл технологийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр үе шаттай зохион байгуулж, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэв. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
145	Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтлөлт, албан бичгийг цахимаар солилцох системийг нэвтрүүлэн, сум, багийн иргэдэд e-mongolia болон бусад цахим үйлчилгээг сурталчлан таниулах сургалт, өдөрлөг зохион байгуулах	10,0 сая төгрөг	-Систем ашиглалтын хувь -Сургалт, өдөрлөг оролцсон иргэдийн тоо	2021	-	Программ ашиглалтын хувь 80-аас дээш Бүх сумдад зохион байгуулсан байна.	Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн egr.e-mongolia.mn системийг ашиглаж, аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид байгууллагын мэдээллээ цахимжуулан, дээд шатны байгууллагатай албан бичгийг шуурхай солилцон ажиллаж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу төрийн байгууллагын цахим шууданг албан харилцаанд ашиглаж хэвшлээ. Нутгийн захиргааны 15 байгууллагын 67 үйлчилгээг E-Mongolia системд нэвтрүүлж, 184 үйлчилгээ үзүүлээд байна. Цахим системд шилжсэн төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай авах нөхцөл, боломжийг бүрдүүлэх зорилгоор Аюуш баатрын талбайд "Цахим Өвөрхангай" нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, уг өдөрлөгт 17 төрийн байгууллага оролцож, цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээгээ иргэд, олон нийтэд танилцуулж, зөвлөгөө мэдээлэл өгсөн.

							Е-Mongolia цахим үйлчилгээний системийг хэрхэн ашиглах талаар заавар, зөвлөгөөг өгөх, мэдээллийн технологийн ур чадварыг олгох сургалтад нийт 800 гаруй иргэнийг хамруулав. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
146	Төрийн байгууллагуудын засвар шинэчлэлт, албаны автомашин, компьютер, техник хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	100,0 сая төгрөг	Ашиглалтад орсон барилга, техник хэрэгслэлийн хангалтын хувь	2021	-	Шийдвэрийн тоогоор	Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/281 дүгээр захирамжаар Орон нутгийн төсвийн байгууллагуудын засвар шинэчлэлд 230,0 сая төгрөг төсөвлөж Төгрөг, Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар, Хайрхандулаан сумын 6 дугаар баг, Баян-Өндөр сумын 3 дугаар баг, Арвайхээр сумын багийн нэгдсэн төвийн засварыг хийж гүйцэтгүүлэв. Улсын төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр Сант сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажлыг хийж гүйцэтгүүлэв. Орон нутгийн 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянгол, Богд, Хужирт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Арвайхээр, Хархорин сумдын Засаг даргын Тамгын газрыг автомашинаар хангав. Орон нутгийн 256,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 112 багийн засаг дарга нарыг зөөврийн компьютероор хангаж, улсын төсвийн 150,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын тоног төхөөрөмжийн шинэчлэл”-ийн ажлыг хийж, ажиллах нөхцөлийг сайжирууллаа. <b>Хэрэгжилт -100 хувь</b>
147	Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа сурталчлах зардлыг жил бүр төсөвтөө тусган, мэдээллийн ил тод байдлыг хангахад хяналт тавьж, иргэдэд үнэн бодит мэдээлэл түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч, “Нэг цонхны мэдээлэл” үйл ажиллагааг үр дүнтэй нэвтрүүлнэ.	20,0 сая төгрөг	-Хамтран ажилласан хэвлэл мэдээллийн байгууллагын тоо -Ил тод байдлын үзүүлэлт	2021	-	Хэвлэл мэдээллийн зардлыг тусган хэрэгжүүлэх	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлаг, 19 сумаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээ, аймаг, орон нутгийн бодлого чиглэлийг олон нийтэд мэдээлж сурталчлахад 2022 онд нийт 58,9 сая төгрөгийг зарцуулсан. Тайлант онд төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн 12 байгууллагатай 48,5 сая төгрөгийн хамтран ажиллах гэрээ байгуулж, санхүүжилтийг ажлын гүйцэтгэлээр улирал бүр тооцож, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгэний зардлаас олгов. Аймгийн албан ёсны цахим хуудас uvurkhangai.mn сайттай 22 агентлаг, 19 сумын веб хуудсыг холбож төрийн мэдээллийг нэг цонхноос ил тод, хүртээмжтэй авах нөхцөл боломжийг хангаж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
148	Гадаад улсын хот, мужуудтай тогтоох хамтын ажиллагааг аймаг, сумын түвшинд	-		-	Орон нутгийн төсөв	2-оос доошгүй	Хужирт сум Япон улсын Мацү-Уро хоттой уламжлалт эгч, дүүсийн харилцааг сэргээн, хамтран ажиллах хүсэлтийг Ази Номхон далайн орнуудын газарт албан бичгээр хүргүүлэн хариуг хүлээж байна. Хархорин суманд Бүгд Найрамдах Польш улсаас Монгол улс дахь

	<p>өргөжүүлж, Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай идэвхтэй ажиллагааг өрнүүлнэ.</p>					<p>элчин сайдын яамнаас Ромын Пап IV Иннокентийн элчээр 1246 оны 7 дугаар сарын 22-нд Хархорумд хотод хүрэлцэн ирж байсан Польш санваартны хөшөөг 10 дугаар сарын 20-ны суурилуулж, 11 дүгээр сарын 21-ний өдөр Польшийн соёлын өдөрлөгийг Өвөрхангай аймагт зохион байгуулж, ингэснээр хоёр улсын хамтын ажиллагаа, аялал жуулчлал хөгжих боломж бүрдлээ.</p> <p>Японы хүүхдийг ивээх сан, Дэлхийн банк, Тайваны хүүхэд гэр бүлийг дэмжих сан, Америкийн элчин сайдын яам, Азийн хөгжлийн банк, Каркорп Монголиа ХХК, Холт интерэйшил, Ядуурлыг бууруулах Японы сан зэрэг байгууллагын олон улсын болон гадаадын хөрөнгө оруулалтаар боловсрол, байгаль орчин хөдөө аж ахуйн салбарт 8,1 тэрбум төгрөг бүхий 10 гаруй төсөл хэрэгжиж байгаагаас тухайн онд 3,6 тэрбум төгрөгийн 5 төсөл шинээр хэрэгжиж эхлээд байна.</p> <p><b>Хэрэгжилт-100 хувь</b></p>
149	<p>Хамтын ажиллагаатай гадаад орнуудын хот, мужуудтай хийх соёл, эдийн засгийн харилцааг өргөжүүлж, эдийн засаг, нийгмийн салбарт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.</p>	Орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр	Эхэлсэн төслийн хэрэгжилтээр		2-оос доошгүй төслийг эхлүүлэх	<p>Польш улсаас Монгол Улсад суугаа элчин сайд 3 удаа, АНУ-ын Элчин сайд, Энхтайвны корпусын захирал, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтын ажиллагааны газрын дарга, Австралийн элчин сайдын 1 дүгээр нарийн бичгийн дарга, Оросын соёл, шинжлэх ухааны төвийн дарга нарыг оролцуулсан уламжлалт харилцаатай гадаад орнуудын төлөөллүүдийг хүлээн авсан. Энэ хүрээнд дээрх гадаад орнуудын соёл, аялал жуулчлалын өдөрлөг, арга хэмжээ, бизнес форум болон уулзалтуудыг 2 талд харилцан зохион байгуулах, аж үйлдвэрийн салбарт харилцан туршлага судалж, төрөл бүрийн технологи нэвтрүүлэх, нутагшуулах үйл ажиллагааг хөгжүүлэх, боловсрол, эрүүл мэндийн салбарт багш, эмч нарын солилцоог урт, богино хугацааны сургалтад хамруулах зэрэг санал солилцож, хамтын ажиллагааны санал, хүсэлтүүдийг хүргүүлсэн.</p> <p>Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, Оросын холбооны улсын Красноярскийн хязгаар мужтай хамтран ажиллах санал солилцон санамж бичгийг байгуулаад байна.</p> <p>БНСУ-ын Зүүн Өмнөд Азийн Нутгийн захиргаадын холбоо олон улсын байгууллагаас 5 орны 54 гишүүн орон нутаг, 1 ажиглагч оронг оролцуулан зохион байгуулсан олон улсын цахим хуралд орон нутгийн төлөөллийг оролцууллаа.</p> <p><b>Хэрэгжилт-100 хувь</b></p>
150	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим программыг нэвтрүүлэх, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын хяналт-</p>	20,0 сая төгрөг	Цахим программыг нэвтрүүлсэн эсэх	2021	-	<p>Нутгийн захиргааны байгууллагуудын хяналт-шинжилгээ үнэлгээний цахим программыг нэвтрүүлэх чиглэлээр холбогдох байгууллагаас санал авч, 2012 оноос хойш Засгийн газартай хамтран ажиллаж байгаа Ухаалаг засаглал ТББ-ын саналыг үндэслэн орон нутагт хэрэгжүүлэх боломжийг судалж байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд Хууль</p>

	шинжилгээ, үнэлгээний сүлжээг бий болгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.					н байна.	тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг сар бүрээр, Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг 7 хоног бүрээр, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг журамд заасан хугацаанд тайлагнаж байна. <b>Хэрэгжилт -90 хувь</b>
151	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж, зөвлөмж гарсан эсэх	2021	-	Орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж, зөвлөмж гарсан байна.	Энэ оны нэгдүгээр улиралд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 88,2 хувийн хэрэгжилттэйгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнасан бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хэрэгжилтийг 82,5 хувиар дүгнэж, дүгнэлт зөвлөмжийг ирүүлсэн байна. Мөн аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд нийт 157 заалтын хэрэгжилтийг 88,6 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан бөгөөд 82,1 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн байна. Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж байна. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
<b>ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ</b>							
<b>ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛТОЙ ИРГЭН, ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАСАН НИЙГЭМ</b>							
<b>Зорилт 3.3. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулна.</b>							
152	Сумдад эрх зүйн танхимыг байгуулж, тэдгээрт түшиглэн цахимаар эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх, сургалт сурталчилгаа зохион байгуулах хүртээмжийг нэмэгдүүлнэ.	8,5 сая төгрөг	Сумдад байгуулагдсан эрх зүйн танхимын тоогоор	2021	Эрх зүйн хөтчүүдийг цахимаар ажиллах чадавхыг сайжруулсан	Эрх зүйн танхим сумдад байгуулагдсан тоо, эрх зүйн хөтөч ажиллах боломж нөхцөл бүрдсэн байх.	Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа 48 эрх зүйн хөтчийг чадавхжуулах ажлыг “Эрх зүйн хөтөч”-ийн нэгдсэн цахим группээр өдөр тутам мэдээллээр ханган хэрэгжүүлж, тайлант хугацаанд Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран 2 удаа сургалт, туршлага судлах өдөрлөгийг зохион байгуулав. “Эрх зүйн хөтчийн булан” ажиллуулах тухай сумдын Засаг дарга нарын гэрээнд тусгаж, одоогийн байдлаар Арвайхээр, Хархорин, Бүрд, Зүүнбаян-Улаан, Сант, Хужирт, Богд, Уянга, Нарийнтээл зэрэг 9 сум нийт 10 сая төгрөгийн санхүүжилтээр эрх зүйн танхимыг байгуулан, иргэдэд шаардлагатай хууль зүйн тусламж, үйлчилгээг үзүүлэн ажиллалаа. Сумдын “Эрх зүйн хөтчийн булан”-гаар 2022 онд нийт 1300 гаруй иргэн хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл авсан байна. Энэ нь сумдын эрх зүйн хөтчүүдээр дамжуулан иргэдээс хууль зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл авах, сургалт хийх, хууль хяналтын байгууллагууд руу өргөдөл, гомдол гаргах зэрэг асуудлаар ихэвчлэн хандсан байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>



153	Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээнд орон нутгийн иргэд, олон нийт, залуучууд, зорилтот бүлгийн оролцоог ханган, хөгжлийн бэрхшээлтэй болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээг бий болгоход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулна.	3.2 сая	Сургалтын тоогоор	2021	15 сургалт арга хэмжээ зохион байгуулсан.	Тухай бүр зохион байгуулсан арга хэмжээний тоо	<p>Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан "Харилцан хүндэтгэе" аянд салбар хорооноос орон нутгийн байгууллагууд, сумдыг уриалан, үйл ажиллагааг идэвхжүүлж, амжилттай оролцлоо. Аянд албан ёсоор нэгдэж, жендэрийн хэвшмэл, ташаа ойлголтоос татгалзах агуулга бүхий нөлөөллийн үйл ажиллагааг эрчимтэй давалгаалж, 58 байгууллага, 24 аж ахуйн нэгж, 19 сум идэвхтэй оролцлоо. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бодлого зохицуулалтыг хэрэгжүүлж, 82 байгууллагад 37 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг танхимаар зохион байгуулж, иргэд, албан хаагчид, эцэг эхийн төлөөлөл 1800 орчим хүн хамрагдсан байна. Мөн цахим орчинд байршуулсан нөлөөллийн үйл ажиллагаа 13,000 орчим хүнд хүрсэн байна.</p> <p>Сумдын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон иргэд, олон нийтэд чиглэсэн жендэрийн мэдлэг олгох сургалтыг үе шаттай зохион байгуулж, жендэрийн тухай ойлголт 4 цаг, ажлын байрны дарамт ба ажлын байран дахь бэлгийн дарамт 4 цаг, хүний эрхийн тухай ойлголт сэдвээр 4 цаг, нийт 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. Мөн мэргэжилтнүүд Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан цахим сургалт, хэлэлцүүлэгт 2 удаа хамрагдаж мэдлэг мэдээлэл авсан байна.</p> <p>"Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал" дэд хэлэлцүүлгийг цахим хэлбэрээр зохион байгуулж, асуумж боловсруулан судалгаа авч нэгтгэлээ. Судалгаанд 115 хүн хамрагдаж, үндэсний чуулганд санал хүргүүллээ. Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан аймгийн НАМЭХ-ноос зохион байгуулсан Зууны түүчээ эмэгтэйчүүд чуулга уулзалтад 19 сумын 200 эмэгтэй оролцож, "Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт" лекц сонсож, хэлэлцүүлэгт оролцож санал бодлоо илэрхийллээ.</p> <p>Арвайхээр, Хархорин сумдын зорилтот бүлгийн эмэгтэйчүүд, төрийн албан хаагч 132 эмэгтэйд Хөөрхөн зүрх төрийн бус байгууллагатай хамтран "Өөрийгөө хайрлахуй" сургалт зохион байгууллаа.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт-100 хувь</b></p>
<b>АВЛИГАГҮЙ ЗАСАГЛАЛ</b>							
<b>Зорилт 3.4. Олон нийтийг соён гэгээрүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.</b>							
154	Авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэргийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх аян, нөлөөллийн арга хэмжээг	15,0 сая төгрөг	Зөрчлийн тоо буурсан үзүүлэлтээр	2021	Байгууллага уд авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй болсон.	Нөлөөллийн арга хэмжээний үр дүнг тооцон ашиг сонирхлын	Авлигатай тэмцэх газар болон аймгийн Прокурорын газартай хамтран ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэргийн сүүлийн 2 жилийн тоон судалгаа гаргуулан, аймгийн төрийн албан хаагчдын авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчилд холбогдож буй шалтгаан нөхцөлийг тогтоох, судалгаанд үндэслэн тусгайлсан сургалт мэдээлэл өгч, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа авч хэрэгжүүлэв.

	үе шаттайгаар зохион байгуулна.				зөрчлийн тоо буурсан үзүүлэлт	<p>Авлигатай тэмцэх газарт 2022 онд гэмт хэргийн шинжтэй 10, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй 3 бүртгэгдэн, үүнээс хэрэг нээн шалгаж буй 6 гомдол байна. Урд онтой харьцуулахад гэмт хэргийн шинжтэй гомдол 11-ээр, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй гомдол 7-оор тус тус буурсан байна.</p> <p>Аймгийн Засаг даргаас баталсан сумдын Засаг дарга, агентлагийн дарга буюу төсвийн шууд захирагч нарын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг тооцон ажиллаж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын удирдамжаар, аймгийн хэмжээнд 2022 онд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулах, орон нутаг дахь төрийн байгууллага, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор тодорхой санхүүжилтийг шийдвэрлэн, “Авлигын эсрэг миний-бидний оролцоо” сэдэвт 45 хоногийн аян зарлан, нийт 9 ажил арга, хэмжээг төлөвлөн, Сум, агентлагуудад хүргүүлж, аяны үйл ажиллагааг дүгнэн ажиллалаа. Аяны хүрээнд Аймгийн ГХУСАЗСЗ-тэй хамтран аймаг дахь хууль, хяналтын байгууллагуудын үйлчилгээ үзүүлэх өдөрлөгөөр “Авлигын эсрэг миний-бидний оролцоо” арга хэмжээг зохион байгуулав. Өдөрлөгөөр Авлигатай тэмцэх газраас зарласан “Зөв зөвд шударга зөв, Таны эрх таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье” аянд нийт 12 байгууллагын 180 гаруй төрийн албан хаагчид нэгдсэн.</p> <p>Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хот хооронд болон Арвайхээр сумын төв зам дагуу хулдаасан 2 самбар байршуулав.</p> <p>Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, шилэн дансны тухай хууль, хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зэрэг нийт 5 хуулиар тараах материал бэлтгэн, нийт давхардсан тоогоор 310 гаруй иргэдэд гарын авлага материал түгээж, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан ажиллалаа.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт-100 хувь</b></p>
--	---------------------------------	--	--	--	-------------------------------	--

**ХҮНИЙ ЭРХ, НИЙГМИЙН АМАР ТАЙВАН БАЙДАЛ**

**Зорилт 3.5. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг сайжруулна.**

155	“Онги гол”-ын хяналтын постыг түшиглэн камерын хяналтыг нэмэгдүүлэх, тээврийн хэрэгслийн стандартын	-	Нэмэгдсэн камерын тоо, зөрчлийн тоо буурсан үзүүлэлтээр	2021	“Камержуула лт-1,2” нэгдсэн арга хэмжээ зохион	Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн	Улсын болон орон нутгийн чанартай авто замд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор холбогдох газруудад хандан, Тээврийн цагдаагийн албанаас Олон улс болон улсын чанартай авто замд байрлах байнгын
-----	---	---	---	------	--	---------------------------------------	---

	бус нэмэлт гэрэлтүүлгийн зөрчлийг бууруулна.				байгуулагдсан.	нэгжүүдийн камерын хяналтыг нэмэгдүүлсэн байдал, зөрчлийн тоо буурсан үзүүлэлтээр	хяналтын цэгийн жишиг зогсоол, хяналтын камер, зарим тохижилтын ажлын төсөвт өртөг, 3 хэмжээст зураглалыг гаргуулсан. Замын хяналтын чиглэлээр тээврийн хэрэгсэл, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлын нэгдсэн хуваарь гарган “Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгслийн бүрэн бүтэн байдал” хэсэгчилсэн арга хэмжээг 2022 оны 05 дугаар сард зохион байгуулав. Уг арга хэмжээний хүрээнд Замын хөдөлгөөний дүрмийн 18.7-д заасан “Гэрэлтүүлийг суурин газарт тээврийн хэрэгсэлд суурилуулахыг хориглоно” гэснийг зөрчиж тээврийн хэрэгслийн бүхээг, урд гупер, нүүр, копут дээр нэмэлтээр туузан лед, өндөр чадал бүхий тусгалтай, ангийн болон аяллын зориулалттай гэрэлтүүлүүр суурилуулсан тээврийн хэрэгсэл бүрийг шалгаж, зөрчилтэй явсан 75 жолоочид 1,5 сая төгрөгийн төгрөгийн торгууль ногдуулж мөн жолооч бүрд дүрмийн заалтыг тайлбарлан өгч, зориулалтын хаалт углаа, хамгаалалт хийж замын хөдөлгөөнд оролцох талаар санамж сэрэмжлүүлэг өгч ажилласан байна. <b>Хэрэгжилт-50 хувь</b>
156	Аймгийн Цагдаагийн газарт насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө өгөх, мэдүүлэг авах зориулалтын өрөөг тохижуулна.	7,5 сая төгрөг	Өрөө тохижуулсан эсэх	2021	Насанд хүрээгүй хүүхдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйл ажиллагааны хүртээмжийн судалгаа хийгдсэн	Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, хохирсон, гэрч хүүхдүүдтэй ажиллах, тэдний нас сэтгэл зүйн онцлогт тохирсон арга хэмжээ авагдсан байдал	Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2017 оны А/57 дугаар тушаалаар батлагдсан “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”-д заасны дагуу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 7,5 сая төгрөгийн санхүүжилтээр “Насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах” өрөөг тохижуулан, 03 дугаар сард ашиглалтад оруулаад байна. Мэдүүлэг авах өрөөг зориулалтын дагуу тохижуулснаар гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, хохирсон, гэрч хүүхдүүдтэй ажиллах, тэдний нас, сэтгэл зүйн онцлогт тохирсон арга хэмжээ авч ажиллахад чухал ач холбогдолтой байна. Жилийн эцсийн байдлаар дээрх мэдүүлэг авах өрөөгөөр насанд хүрээгүй 33 сэжигтэн, яллагдагч, гэрч хүүхдээс тайлбар, мэдүүлэг авч бусад хууль хяналтын байгууллагаас дээрх хүүхдүүдтэй уулзаж, хууль зүйн туслалцаа авах орчин нөхцөлийг бүрдүүлэв. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
157	Олон нийтийн цагдаагийн урамшуулал болон хувцас хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлнэ.	-	Урамшуулал, хувцас хэрэгслээр хангагдсан эсэх	2021	-	Урамшуулал, хувцас хэрэгслээр хангагдсан байна.	Олон нийтийн цагдаагийн орон тоог нэмэгдүүлэн, ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 07/07 дугаар тогтоолоор олон нийтийн цагдаагийн тоог 27 болгон 2 оор нэмэгдүүлж, урамшууллын дүнг 480,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. Тухайлбал Арвайхээр сум 7, Хархорин сум 4, Бат-Өлзий сум 1, Уянга сум 3, Сант сум 1, Нарийнтээл сум 4, Бүрд сум 1, Богд сум 1, Баруунбаян-Улаан сум 1, Баянгол сум 1, Төгрөг сум 1, Хужирт сум 1, Есөнзүйл суманд 1 тус тус олон нийтийн цагдаа ажиллаж байна. Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаанд өдөр тутмын мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үйл ажиллагааг идэвхжүүлэхээр сумдын Гэмт хэргээс урьдчилан

						сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран нийт 11 удаагийн сургалт, аянг зохион байгуулав. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
158	Үндэсний аюулгүй байдал, террозимтой тэмцэх үйл ажиллагааг идэвхжүүлэх, төрийн тусгайлсан чиг үүргийн байгууллагуудын хамтарсан хяналтыг нэмэгдүүлнэ.	19,0 сая төгрөг	Бууруулсан арга хэмжээний тоогоор	2021	Тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудыг нэгдсэн бодлого зохицуулалт аар хангасан.	Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй нөхцөл байдлыг бууруулсан арга хэмжээний тоо “Үндэсний аюулгүй байдлыг орон нутгийн түвшинд хангах бодлогын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны нэгдсэн төлөвлөгөөг баталж, Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргын 2022 оны 1/211 дүгээр албан бичгээр 19 сум, тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудад хүргүүлэв. Холбогдох тайлан, мэдээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журам шинэчлэн батлах тухай” 54 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтад заасан мэдээ тайланг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэн ажиллаж байна. Сумдын химийн бодис ашиглаж байгаа болон хадгалагдаж байгаа байгууллагуудад химийн хортой болон аюултай бодисын тооллогын ажлыг хийж, орон нутгаас шаардагдах зардал 18,9 сая төгрөгийг шийдвэрлэн устгалын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулав. Нийт 19 сумын Ерөнхий боловсролын 24 сургуулийн химийн кабинет, аймгийн БОЭТ, Мал эмнэлэгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон Хужирт сумын Жем Хужирт ХХК-ийн лабораториудад хадгалагдаж байсан ашигладаггүй, хугацаа дууссан химийн хортой болон аюултай давхардсан тоогоор 1584 нэр төрлийн 407,5 литр шингэн бодис, 462,3 килограмм хатуу болон нунтаг бодис, 30 гаруй тонн газар тариалангийн хортонтой тэмцэх химийн болон бактерийн бордоог нэгдсэн журмаар цуглуулж аюултай хог хаягдал устгах эрх бүхий мэргэжлийн байгууллага болох Түмэн эгшиг ХХК-тай гэрээ байгуулж, хүлээлгэн өгөх ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Тагнуулын хэлтэстэй хамтран зохион байгууллаа. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>Зорилт 3.6 Хууль сахиулах болон хяналтын байгууллагууд, тэдгээрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.</b>						
159	Зарим хууль, хяналтын байгууллагын албан хэрэгцээнд автомашин, бусад шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	-	Нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчлийн тоо буурч, албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирсан	2021	Жилд 3-4 байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.	Нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчлийн тоо буурч, албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирсан Шүүхийн шинжилгээний албаны албан хаагчдын ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэн 72,8 сая төгрөгийн 2 өрөө албаны орон сууцны асуудлыг шийдвэрлэв. Мөн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын өрөөний засварын зардалд 4,3 сая төгрөг, Мэргэжлийн хяналтын газрын албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор улсын төсвөөс 39,0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 4,0 сая төгрөг, нийт 43,0 сая төгрөгөөр УАЗ Фургон автомашин, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд хоригдож буй хоригдогч нарын

			үзүүлэлтээр			байна.	эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах зардалд 6,0 сая, Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох насанд хүрээгүй хүүхдээс тайлбар, мэдүүлэг авах тусгай өрөөг тохижуулах зардалд 10,0 сая төгрөг, Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн өрөөнд тоног төхөөрөмж суурилуулах, засварын зардалд 4,3 сая төгрөгийг тус тус шийдвэрлэсэн. Аймгийн Засаг даргаас Өлзийт, Баруунбаян-Улаан сумын хэсгийн төлөөлөгчид Toyota kluger автомашиныг шийдвэрлэн өгч, Баруунбаян-Улаан сумын Засаг даргаас автомашинд 5,0 сая төгрөгөөр засвар үйлчилгээ хийж, сумын хэсгийн төлөөлөгчид хүлээлгэн өгсөн, Өлзийт сумын Засаг даргаас 18,0 сая төгрөгийг шийдвэрлэн Toyota Probox маркийн автомашин худалдан авч албан хэрэгцээнд ашиглаж байна. Хайрхандулаан суманд 2,9 сая төгрөгөөр Мустанг-5 маркийн мотоциклыг шийдвэрлүүлэн албан хэрэгцээнд ашиглаж байна. Аймгийн Цагдаагийн газрын нийт сумдын хэсгийн төлөөлөгч нар албаны автомашинтай үүрэг гүйцэтгэж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
160	Хархорин сумын Аврах гал Унтраах ангийн барилгыг эхлүүлнэ.	2,9 тэрбум төгрөг	Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувиар	2021	-	Барилгын ажил эхэлсэн байна.	Улсын төсөвт 2,9 тэрбум төгрөг тусгагдсан бөгөөд магадлалын дүнгээр 4,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй байхаар батлагдсан. Хархорин сумын Онцгой байдлын хэлтсийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч шалгаран гэрээ байгуулж, суурийн болон гадна дулааны ажлыг хийж энэ онд санхүүжихээр тусгагдсан 200,0 сая төгрөгийн санхүүжилтээ аваад байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>

**БАТЛАН ХАМГААЛАХ**

**Зорилт 3.7. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

161	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу Төгрөг, Гучин-Ус, Баруунбаян-Улаан сумдын удирдах болон томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй сургалт, бэлтгэлийг зохион байгуулна.	6,0 сая төгрөг	Сургалт, дадлага зохион байгуулсан эсэх	2021	2021 онд томилгоот нэгжид томилгоожсон бүрэлдэхүүний 5,5 хувьд сургалт бэлтгэлийг зохион байгуулсан.	2022 онд томилгоот нэгжид томилгоожсон нийт бүрэлдэхүүний 10 хувийг хамруулан сургалт бэлтгэлийг зохион байгуулна.	Хангайн бүсийн Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Хужирт, Хархорин, Уянга сумдын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнээс хээрийн нэгдсэн дадлагад оролцох бүрэлдэхүүнийг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нартай хамтран сонгон авч томилгоот үүрэг гүйцэтгэх бэлтгэлийг хангуулсан. Энэ оны 09 дүгээр сарын 02-09-ний хооронд томилгоот бүрэлдэхүүнтэй хээрийн дадлага, үзүүлэх сургуулийг Өвөрхангай аймгийн Хужирт сумын Цагаан залаа зуслангийн районд зэвсэг, техниктэйгээр зохион байгуулж явуулсан. Хээрийн дадлага, үзүүлэх сургуульд нийт 15,4 сая төгрөгийг зарцуулсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
162	Цэргийн дайчилгааны даалгаврын дагуу сумдын цэргийн дайчилгааны төлөвлөгөөг	1.5 сая төгрөг	Төлөвлөгөө, даалгавар боловсруулсан эсэх	2021	Аймгийн цэргийн дайчилгааны даалгаврын	2022 онд 19 сумын цэргийн дайчилгааны	Энэ оны 1 дүгээр улиралд сумдын цэргийн дайчилгааны даалгаврыг шинэчлэн боловсруулж батлуулсан. Шинэчилсэн дайчилгааны даалгаврын дагуу 19 сумын цэргийн дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулахаар бэлтгэл ажлыг хангуулан

	боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангана.				дагуу аймгийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан.	төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангана.	ажиллаж байна.  <b>Хэрэгжилт-90 хувь</b>
163	Хархорин сум болон зарим сумдын ЗДТГ, ерөнхий боловсролын сургуультай хамтран ахлах ангийн сурагчдад цэрэг эх оронч хүмүүжил олгох танхимыг тохижуулна.	3,8 сая төгрөг	Тохижуулсан ангийн тоогоор	2021	2021 онд Арвайхээр сумын 2 дугаар сургууль, Хайрхандулаан сумын ЕБС-ийн 1, 1 хичээлийн танхимыг тохижуулж,хүлээлгэн өгсөн.	2022 онд аймгийн хэмжээнд 6 дахь Ерөнхий боловсролын сургуульд цэрэг-эх оронч хүмүүжлийн танхим тохижуулна.	Хархорин сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн хичээлийн 1 танхимыг цэрэг-эх оронч хүмүүжлийн танхим болгон тохижууллаа.  <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>3.8. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ.</b>							
164	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг Гучин-Ус суманд, команд штабын сургуулийг Богд, Төгрөг, Бүрд сумдад зохион байгуулна.	15,0 сая төгрөг	Дадлага сургууль зохион байгуулсан эсэх	2021	2021 онд Сант, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Баянгол сумдад Команд штабын сургуулийг зохион байгуулсан.	Дадлага сургууль зохион байгуулсан сумдын тоогоор	Гучин-Ус суманд гамшгаас хамгаалах “Иж бүрэн” сургууль, Бүрд, Богд, Төгрөг зэрэг сумдад гамшгаас хамгаалах “Команд штаб”-ын дадлага сургуулийг зохион байгуулж, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн хуулийн этгээд, сайн дурын хэсгийн алба хаагчид зэрэг 284 мэргэжлийн ангийн алба хаагчид, 130 гаруй иргэн, аж ахуйн нэгжийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж дадлагажуулан, бэлэн байдлыг дээшлүүлж ажилласан. Сумдын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг түшиглэн 2022 онд “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг”-ийг байгуулсан 19 сумын судалгааг авч нэгтгэн, чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, холбогдох баримт мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
165	Сумдад гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг объектын гал түймэр, ой хээрийн түймэр, зуд, ган, үер, малын гоц халдварт өвчин, газар хөдлөлт гэсэн аюулын төрөл тус бүрээр эрх бүхий байгууллагаар	20,0 сая төгрөг	Эрсдэлийн үнэлгээ хийгдсэн эсэх	2021	Гамшгийн эрсдэлийн судалгааг сум бүрээр гаргаж, эрсдэлийн зэргийг тооцох нөхцөлийг бүрдүүлсэн	Эрсдэлийн үнэлгээ хийгдсэн байна.	Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг Гучин-Ус, Төгрөг, Богд сумдад объектын гал түймэр, үер, ган, зуд, ой хээрийн түймэр, хүн малын гоц халдварт өвчин гэсэн байгалийн гаралтай аюулын төрөл тус бүрээр хийхэд гамшгийн эрсдэлийн түвшин “Дунд” эрсдэлтэй гарч эрсдэлийг бууруулах төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>

	гүйцэтгүүлнэ.				байна.		
166	Гамшгаас хамгаалах шуурхай удирдлагын хяналтын төв байгуулах.	-	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувиар	2021	16*12 харьцаатай барилгын суурийг цутгаж, өрлөгийн ажлын гүйцэтгэл 20 хувьтай явагдаж байна.	Барилгын ажил дууссан байна.	Гамшгийн шуурхай удирдлагын хяналтын төвийн барилгын ажлын төсөвт шаардагдах 150,0 сая төгрөгийг 2022 оны орон нутгийн төсөвт тусгуулсан боловч, төсвийн тодотголоор хасагдсан тул хэрэгжих боломжгүй болсон.  <b>Хэрэгжилт-0</b>
167	Өсвөрийн аврагч 2022 тэмцээнийг зохион байгуулна.	10,0 сая төгрөг	Тэмцээн зохион байгуулсан эсэх	2021	Ковид-19 цар тахлын халдварын улмаас 2020, 2021 онд зохион байгуулагда агүй.	Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад аюулгүй амьдрах арга ухааны мэдлэг эзэмшүүлэх, гамшигт нэрвэгдэгсдийг аврах, өөртөө болон бусдад анхны тусламж үзүүлэхэд сургаж дадлагажуулсан байна.	Аймгийн Засаг даргын 2022 оны А/457 дугаар захирамжаар 5,3 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэн, аймгийн аварга шалгаруулах “Өсвөрийн аврагч” 2022 тэмцээнийг Арвайхээр суманд нийт 6 төрлөөр, 19 сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 300 гаруй хүүхдийг хамруулан зохион байгуулсан. Уг тэмцээнээр өсвөрийн аврагч хүүхдүүдэд гамшгийн тухай ерөнхий ойлголт өгч, эмнэлэегийн анхан шатны тусламж үзүүлэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх зэрэг мэдлэг чадварыг эзэмшүүлж, бүлгийн үйл ажиллагааг чадавхжуулсан.  <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>Бүлгийн дүн 96,07 хувь</b>							
<b>ДӨРӨВ. НОГООН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧИН</b>							
Зорилго: Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, байгалийн баялгийг зүй зохистой ашиглан, нөхөн сэргээж, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.							

## НОГООН ХӨГЖИЛ

**Зорилт 4.1. Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, доройтсон газрыг нөхөн сэргээх чиглэлээр шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, байгалийн нөөцийг зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.**

168	Булаг шанд, рашааны эхийг хамгаалах	14,0 сая төгрөг	Хашиж хамгаалсан булгийн эхийн тоо хэмжээ	2021	336 булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалсан	10-аас доошгүй булгийн эхийг хашиж хамгаална.	Нэн тэргүүнд хашиж хамгаалах шаардлагатай булаг, шанд, рашааны судалгааг гаргаж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Нарийнтээл, Баянгол, Өлзийт, Хайрхандулаан, Баян-Өндөр сумдуудад нийт 13, хувийн хэвшлийн хөрөнгөөр 20 нийт 33 булаг, шанд, рашааны эхийг хашиж хамгаалан нутгийн иргэдэд хариуцуулсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
169	Орон нутгийн чанартай, бүрэн судлагдаагүй рашааны чанар найрлагыг тодорхойлох судалгаа хийлгэнэ.	15,0 сая төгрөг	Рашааны чанар найрлагыг тодорхойлсон эсэх	2021	Хужирт рашааны нөөцийг 2018 онд тогтоосон.	Рашааны физик-химийн найрлагыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгосон байна	Орон нутгийн чанартай бүрэн судлагдаагүй Бат-Өлзий сумын Хуст, Ар хятруун, Могойт, Үүртийн тохой, Баруунбаян-Улаан сумын Хүрэн хад, Уянга сумын Өвөр хятруун, Тарагт сумын Хүрэмт, Эмт, Арвайхээр сумын Дэлгэрэх, Бурхи зэрэг рашаануудын физик, химийн найрлагыг тодорхойлох судалгааны ажлыг 2022 оны 06 дугаар сараас 09 дүгээр сарын хугацаанд МУ-ын усны чанарын зөвлөх инженер, гидрохимич Ч.Жавзан доктороор ахлуулсан судалгааны багаар гүйцэтгүүлж микробиологи, бичил элементийн 86 үзүүлэлтээр нарийн тодорхойлуулж, тайланг хүлээн авч иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулсан. Судлагааны дүнгээр бохирдолтой гарсан рашаан булгийг хашиж хамгаалахаар 2023 оны төлөвлөлтөд оруулаад байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
170	Аймгийн томоохон голуудын урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах	-	Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн холбогдох газарт санал хүргүүлсэн эсэх	2021	Улсын тусгай хамгаалалтад авсан газрын хэмжээ 341542 га	Аймгийн томоохон голуудын урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэлийг боловсруулан аймаг, сумын ИТХ-ын саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн байна	<b>Хэрэгжилт-70 хувь</b>



Зорилт 4.2. Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, доройтсон газрыг нөхөн сэргээх чиглэлээр шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, байгалийн нөөцийг зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.							
171	Хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	-	Хог хаягдлын менежментийг сайжруулах урт хугацааны бодлогын баримт бичиг батлуулсан эсэх	2021	-	Хог хаягдлын менежментийг сайжруулах мастер төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.	Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй Арвайхээр хотын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн хүрээнд “Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги төлөвлөгөө”-г 2021 оны 12 сард Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 09/09 дүгээр тогтоолоор батлуулсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
172	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагааг дэмжих, сумдыг дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх боломжоор хангах	140,0 сая төгрөг	Хоёрдогч түүхий эд нягтруулах төхөөрөмжөөр хангагдсан байдал	2021	2021 онд 4 суманд хоёрдогч түүхий эд нягтруулж, пресслэх төхөөрөмж нийлүүлсэн.	Зарим сумдад хоёрдогч түүхий эд нягтруулж, пресслэх төхөөрөмж нийлүүлсэн байна.	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг айл өрхүүдэд нэвтрүүлж, дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх зориулалтын техник, тоног төхөөрөмжийг сумдад нэвтрүүлэх ажлын хүрээнд Есөнзүйл, Гучин-Ус, Баян-Өндөр, Уянга сумдууд пресслэгч төхөөрөмж худалдан авч дахивар хүлээн авах цэг бий болгосноор хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломж бүрдсэн. Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн санхүүжилтээр Арвайхээр сумын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн хүрээнд Арвайхээр суманд шинээр хоёрдогч түүхий эд хүлээн авах 5 цэгийг байгуулж Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн. Хог хаягдлын менежментийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Өнгө нэм ТББ-тай гэрээ байгуулж, хийгдэх ажлын төлөвлөгөөний дагуу хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах зориулалт бүхий хогийн савны жишиг загварыг бий болгох, Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг боловсруулах, хог хаягдлын чиглэлээр сургагч багш бэлтгэх зэрэг ажлууд хийгдэж байна. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
173	Ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээнэ.	450,0 сая төгрөг	Төлөвлөсөн талбайд нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хийсэн байна	2021	300 га	100-аас доошгүй га	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч АУМ-Алт, Өгөөмөр-Өрөө, Баярсгоулд ХХК-иуд нийт 69,4 га талбайд нөхөн сэргээлт хийхээр 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусгаж техникийн нөхөн сэргээлт 55,33га, биологийн сэргээлт 10,5га нийт 65,83га талбайд нөхөн сэргээлтийг гүйцэтгээд байна. Мөн бусад хууль бусаар үйл ажиллагаа явуулж, байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн сэргээлтийн зардал төлөхөөр болсон иргэдээс авах төлбөрийг барагдуулж, нөхөн сэргээлт хийлгэхээр аймгийн Прокурорын газартай хамтран ажиллаж байна. Гар аргаар ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж нөхөн сэргээгдээгүй орхигдсон 81,29 га газрыг нөхөн сэргээх зорилгоор бичил уурхайн зориулалтаар аймгийн

						иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 10/06 дугаар тогтоолоор тусгай хэрэгцээнд авсан. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
174	Нэн ховор, ховор амьтан ургамлын тархац нөөцийн судалгааг өргөжүүлж, хамгаалалтын менежментийг сайжруулах.	10,0 сая төгрөг	Шаардлагатай газруудад биотехникийн арга хэмжээ авагдсан байх	2021 онд аймгийн ургамлын тархац нөөцийн судалгааг гүйцэтгүүлсэн.	Нэн ховор, ховор амьтдад биотехникийн арга хэмжээ авсан байна.	Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2022 оны 3, 4 дүгээр саруудад нэн ховор, ховор амьтад болох аргаль, янгир, халиун буга, бор гөрөөс зэрэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулж, нийт 10 сумын 36 цэгт 5 тонн хужир тавьж, тус ажилд сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид, нөхөрлөлийн гишүүд оролцсон. Аймгийн байгалийн ургамлын тархац, нөөцийн судалгаа хийлгэх ажлыг 2021 онд шинжлэх ухааны академийн Ботаникийн хүрээлэнгээр гүйцэтгүүлж, судалгааны үр дүнгээр 61 овгийн 238 төрлийн 517 зүйл ургамал бүртгэгдэж, нэн ховор ургамлын 12 овгийн 13 зүйл ургамлын 48 тархцын цэг, ховор ургамлын 17 овгийн 31 зүйл ургамал, эмийн болон хүнсний ашиглалтад өртөж буй 111 зүйл ургамлын 1059 тархцын цэгийг тогтоосон. Өвөрхангай аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн 2018-2022 оны төлөвлөгөөг 2018 онд “Аргаль, агнуур судлалын төв” төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн бөгөөд хугацаа дуусаж байгаа тул 2023 онд шинэчилж хийлгүүлэхээр төлөвлөөд байна <b>Хэрэгжилт-100 хувь</b>
175	Төрийн үйлчилгээний чанар бүтээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчны хууль, дүрэм, журам, стандарт, тэрбум мод тарих ажлыг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	10,0 сая төгрөг	Байгаль орчны сургалт сурталчилгаа болон сургалтад хамрагдсан иргэдийн тоо хэмжээгээр	Нийт 60 эх бэлтгэл сурталчилгааны постер, 23 удаагийн мэдээ, сурвалжилга, шторк, нэвтрүүлэг, зочны ярилцлага 3, сэдвийн сурвалжлага 2, онцлох мэдээ 10-г хийлгэж иргэд олон нийтэд хүргэсэн.	Байгаль орчны хууль тогтоомж, дүрэм журам, тогтоол шийдвэр, мод тарих ажлыг иргэд олон нийтэд сурталчлах сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулсан байна.	Байгаль орчны хууль тогтоомж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг иргэд олон нийтэд сурталчлах зорилгоор орон нутгийн Соёмбо болон МҮОНРТ, ӨВ live.mn сайт, эх бэлтгэлийн Оюунана брэнд ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, 78 эх бэлтгэл, сурталчилгааны постер, 32 удаагийн мэдээ, 2 сэдвийн сурвалжилга, 2 шторк, шууд live нэвтрүүлгүүдийг хийлгэж байгууллагын пэйж хуудас болон вэйб сайтаар иргэд олон нийтэд хүргэсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын газраас Арвайхээр сумын ерөнхий боловсролын Мэргэд, 1, 2, 4, 5 дугаар сургуулиудын 8-12 ангийн сурагчдад Өвөрхангай аймгийн нэн ховор, ховор амьтан ургамлын талаар танин мэдэхүйн сургалтыг зохион байгуулж 500 гаруй сурагчид хамрагдсан. “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах” зорилтот жилийн хүрээнд аймгийн хэмжээнд шилдэг тохижилт, ногоон байгууламжтай сум, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийг шалгаруулах болзолт уралдааныг зарласан. Мөн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Супер анги” шалгаруулах уралдааныг зохион байгуулж, Арвайхээр сумын лаборатори Мэргэд сургуулийн 116 анги, Баян-Өндөр сумын 126 анги, Арвайхээр сумын 5 дугаар сургуулийн 10а анги, Богд сумын 126 анги,

							Бат-Өлзий сумын 12а анги хамт олон тэргүүн байруудад тус тус шалгарлаа Хүүхэд багачуудад байгаль орчныг хамгаалах талаар мэдлэг мэдээлэл олгох, байгаль орчинтой зөв харьцах дадал хэвшүүлэх зорилгоор 26 сургуульд эко клубыг ажиллуулж тэднээр дамжуулан нөлөөллийн ажлууд зохион байгуулж байна. Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд “Ан амьтад” гэрэл зургийн үзэсгэлэн, “Тарьц суулгацны үзэсгэлэн худалдаа”, “Тэрбум” мод тарих үндэсний хөдөлгөөний нээлт зэрэг арга хэмжээг зохион байгуулж, байгаль орчны мэдээ мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын пэйж хуудас болон <a href="https://nature.ov.gov.mn/">https://nature.ov.gov.mn/</a> сайтаар дамжуулан сурталчиллаа.
<b>Хэрэгжилт-100 хувь</b>							
<b>Зорилт 4.3. Ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойн хомсдол, доройтлыг бууруулах, ойг нөхөн сэргээх, ойжуулах замаар ойг тогтвортой ашиглахад чиглэсэн менежментийг хэрэгжүүлнэ.</b>							
176	Ойжуулалт, ойн зурвас байгуулна.	УТ 90,0 сая төгрөг	Ойжуулалт, ойн зурвас байгуулсан талбайн хэмжээгээр	2021	2021 онд ойгоос мод бэлтгэсэн 7 аж ахуйн нэгж, 15 нөхөрлөл 24 га талбайд өөрийн хөрөнгөөр, орон нутгийн төсвөөр 20 га ойжуулалтын ажил хийгдсэн.	Байгалийн сэргэн ургалтад туслах ажил 40 га  Өөрийн хөрөнгөөр ойжуулалт 25 га  Ойн зурвас байгуулах 10 га	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шийдвэрээр улсын төсвөөр хийгдэх байгалийн сэргэн ургалтад туслах ажил цуцлагдсан. Бат-Өлзий сумын ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх 10 га талбайд ойжуулалтын ажил гүйцэтгэснээс гадна сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайд 9000 ширхэг модыг тарьсан байна. Улсын төсвөөр гүйцэтгэх газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан суманд хамгаалалтын ойн зурвас байгууллаа. Нийт 8 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж 3500 ширхэг мод бут тарьсан байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн зорилтот жилийн хүрээнд Арвайхээр, Хархорин, Хужирт сумдад автозам дагуу 3 км газарт хамгаалалтын ойн зурвас байгуулсан.
<b>Хэрэгжилт-90 хувь</b>							
177	Ойн хөнөөлт шавжтай тэмцэх устгал тэмцлийн ажлыг зохион байгуулна.	86,0 сая төгрөг	Сумдад хортон устгал хийсэн талбайн хэмжээгээр	2021	2021 онд 4700 га талбайд хортон устгалын ажил хийгдсэн.	Үүргийн шүршигч багаж ашиглан химийн аргаар тэмцэх ажлыг 2000 га-д гүйцэтгэнэ.	Тус аймагт ойн хөнөөлт шавжийн тархалт ой бүхий 5 сумын 30,0 мянга орчим га талбайг хамарсан. Шинэсний шилмүүс хуйлагч, яacobсоны төөлүүрч эрвээхэйн хөнөөлийн голомт илэрсэн Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Хужирт, Хархорин сумдын ойн сан бүхий газруудаар ойн хөнөөлт шавжтай механик аргаар тэмцэх ажлыг 2022 оны 06 дугаар сарын 18-28-ны хугацаанд хийлээ. Бат-Өлзий суманд 1000 га, Хужирт суманд 500 га, Зүүнбаян-Улаан суманд 500 га, Хархорин суманд 500 га талбайд тус тус гүйцэтгэж хортон устгалын ажилд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас нийт 86,0 сая төгрөгийн санхүүжилт олголоо. Мөн Бат-Өлзий, Хужирт сумын Засаг даргын Тамгын газар, Их сумт хайрхан ХХК, Мөнгөн хүрхрээ жуулчны бааз, иргэдийн хандив тусламжаар нэмэлт хөрөнгө гаргаж 1300 га

						талбайд устгалын ажил хийгдсэнээр аймгийн хэмжээнд нийт 3800 га талбайд ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил хийгдсэн. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
178	“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.	1,5 тэрбум төгрөг	-Төлөвлөгөө боловсруулж батлуулсан эсэх -Тарьсан модны хэмжээ	2021	2021 онд аймгийн хэмжээнд 40,5 мянган мод бут тарьсан	Аймгийн хэмжээнд 200,0 мянган ширхэг мод, бут тарина. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг зорилтот жилийн ажлын төлөвлөгөөтэй хамтатган төлөвлөж батлуулсан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдээр аймгийн хэмжээнд 320,0 мянга орчим мод тарьсан байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
179	Хужирт сумын Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилгыг барина.	450,0 сая төгрөг	Барилга угсралтын ажлын гүйцэтгэлээр	2021	-	Хужирт суманд Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга баригдсан байна. Хужирт сумын Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга угсралтын ажил дуусаж, байнгын ашиглалтад хүлээн аваад байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>

#### АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

#### Зорилт 4.4. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

180	Аялал жуулчлалын гол маршрут дагуу эко ариун цэврийн байгууламжийг аялал жуулчлалын бүс нутагт байршуулна.	17,5 сая төгрөг	Эко ариун цэврийн байгууламжтай болсон эсэх	2021	2021 онд 4 байршилд эко ариун цэврийн байгууламж байгуулсан.	Аялал жуулчлалын бүс нутагт 5-аас доошгүй эко ариун цэврийн байгууламж байгуулсан байна. Аялал жуулчлалын гол маршрут дагуу эко ариун цэврийн байгууламжийг байгуулах зорилтын хүрээнд 17 суултуур бүхий 3 ширхэг зөөврийн эко ариун цэврийн байгууламж худалдан авч ашиглалтад оруулаад байна. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
181	Аймгийн аялал жуулчлалын бүс нутгийн онцлогт тулгуурлан аялал жуулчлал эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулж, “ITM” ОУ-ын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцоно.	60,0 сая төгрөг	Зохион байгуулсан эвент арга хэмжээний тоогоор	2020	2 эвент (2020 он)	Уламжлал болон зохион байгуулагдд аг эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна. Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хужирт, Бат-Өлзий сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн “Дэлхийн өв-Орхон голын нүүдэлчид” аялал жуулчлалын холбоо хамтран бүс нутгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын эвент арга хэмжээ “Монгол эсгийн урлалын баяр”-ыг Хужирт суманд 7 дугаар сарын 22-ны өдөр, “Сарлагийн баяр”-ыг Бат-Өлзий суманд 2022 оны 7 дугаар сарын 23-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, уг эвент арга хэмжээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Баттулга оролцсон. Эвент арга хэмжээнүүдийг үзэж сонирхохоор Франц, Польш, Герман, Япон, Швейцар зэрэг орны жуулчид, дотоодын аялагчид нийт 1000 гаруй жуулчид үзэж

						сонирхлоо. Байгаль орчин, аялал жуулчлалын яам Солонгос улстай аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллах хүрээнд Солонгосын үндэсний EBS телевизийн “Дэлхийгээр аялцгаая” нэвтрүүлгийн багийнхан манай аймагт дээрх эвентүүдийн үеэр ажиллаж 2 удаагийн нэвтрүүлгийг бэлтгэсэн. Ай Ти Эм-2022 олон улсын аялал жуулчлалын зөвөлгөөнд 40 аж ахуйн нэгж, байгууллага оролцсон. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
182	Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалт зохион байгуулна.	15,0 сая төгрөг	Сургалтад хамрагдсан иргэдийн тоогоор	2021	150 иргэн /2020 он/	Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтуудыг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан байна. Аймгийн Политехник коллежтой хамтран аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа нутгийн иргэдийг чадавхжуулах сургалтыг Бат-Өлзий суманд зохион байгуулж, зочид буудлын үйлчилгээний ажилтны ангид 28 иргэн, аяллын хөтчийн ангид 22 иргэн тус тус хамрагдлаа. “Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын зочлох үйлчилгээний чанарыг сайжруулах нь” сэдэвт аймгийн зөвлөгөөнийг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулж, аймгийн хэмжээнд аялал жуулчлал эрхлэгчдийн төлөөлөл 40 аж ахуйн нэгж оролцлоо. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг сайжруулах зорилгоор тохирлын үнэлгээ хийх аймгийн ажлын хэсэг 2022 оны 6 дугаар сарын 30-наас 7 дугаар сарын 06-ны хооронд гэст хаус (гэр буудал), жуулчны баазуудад тохирлын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. <b>Хэрэгжилт-90 хувь</b>
183	Тусгай хамгаалалттай газар нутгийн нөөцөд тулгуурлан эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	-	Эко аялал жуулчлал эрхлэгчдийн тоо	2021	75 өрх (2019)	Эко аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийн тоог өмнөх оноос 30-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ. Орхоны хөндийн тусгай хамгаалалттай газар нутагт зөв менежменттэй эко аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Орхоны хөндийн тусгай хамгаалалттай газар нутгийн хог хаягдлын менежментийг сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлгийг Хужирт суманд зохион байгуулж, зөвлөмж гарган холбогдох газруудад хүргүүлж ажилласан. Хэлэлцүүлэгт тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төр хувийн хэвшил, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл оролцсон. Уянга сумын Хүйсийн найман нуур орчим 16, Бат-Өлзий сумын Хүрхрээ, Хойд агуйт, Хустай, Төвхөн хийд орчимд 46, Бүрд сумын Элсэн тасархайд 4, Богд сумын Сэрвэн хайрханд 1 нийт 67 өрх тус тус эко гэр ажиллуулж байна. <b>Хэрэгжилт-70 хувь</b>
184	Аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлуулах	-	Дэд хөтөлбөрийг шинэчлэн батлуулсан эсэх	2021	Аялал жуулчлалын дэд хөтөлбөр 2018-2022 онд хэрэгжиж дуусна.	Аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг боловсруулж аймгийн Аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн шинэчилсэн төсөлд Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Дэлхийн өв соёлын дурсгалт газрын хамгаалалтын газар, аймгийн аялал жуулчлалын холбоо зэрэг байгууллага аж ахуйн нэгжээс санал авч, бэлтгэл ажил хийгдэж байна.

						иргэдийн Төлөөлөгчди йн Хурлаар батлуулсан байна.	<b>Хэрэгжилт-50 хувь</b>
<b>Бүлгийн дундаж 87,0 хувь</b>							
<b>ТАВ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</b>							
<b>Зорилт 5.1. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана</b>							
185	Коронавируст халдварын батлагдсан тохиолдолд хэрэглэгдэх вирусийн эсрэг эм, сонгомол антибиотик, үрэвслийн эсрэг эм, тарианы нөөцийг бүрдүүлнэ.	-	Вирусийн эсрэг эмийн хангалтын хувь  АБ хангалтын хувь  Шингэн бэлдмэлийн хангалтын хувь	2021	70  85  70	80  90  70	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийн мэдээг <a href="http://www.burtgel.mn">www.burtgel.mn</a> , <a href="http://www.mohs.mn">www.mohs.mn</a> программд 7 хоног бүр оруулж, нөөцийн үлдэгдэлд хяналт тавин, дүгнэлт хийн ажиллаж байна.  Энэ оны 9 дүгээр сарын байдлаар вирусын эсрэг эмийн хангалт 80 хувьтай байна. Антибиотик эмийн хангалт 90 хувь, Шингэн бэлдмэлийн хангалт 70 хувьтай байна. Энэ онд нэмэлтээр 150 гаруй сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл урвалж бодис, халдваргүйтгэлийн бодисийн нөөц бүрдүүлэн ажиллаж байна. Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг, бусад сумын Эрүүл мэндийн төвүүдэд антибиотик эмийн нөөц 1-2 сар, вирусын эмийн нөөц 3 сар, шингэн сэлбэх эмийн нөөц 3 сар, бусад эм, халдваргүйжүүлэх бодисын нөөцийг 3-аас дээш, эмнэлгийн хэрэгсэл 6-аас дээш сараар бүрдүүлж ажиллаж байна.
<b>Хэрэгжилт-100 хувь</b>							
186	Тархвар судлал, зоонозын өвчний эмч бэлтгэж чадавхжуулна.	-	Халдварт өвчний чиглэлээр нарийн мэргэшил шинээр эзэмшсэн их эмчийн тоо  Шинээр ажилд орсон тархвар судлаачийн тоо	2021	0  1	2  1	Зоонозын өвчин судлалын төвд зооноз өвчин судлалаар 1 их эмч ариутгагч 2-ыг улсын төсвийн санхүүжилтээр сурган бэлтгээд байна. Аймгийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд Тархвар судлаач 1, Халдвартын их эмч 1-ийг нэмэгдүүлснээр одоо нийт аймгийн хэмжээнд халдвартын их эмч 5, тархвар судлаач 4 ажиллаж байна. Ирэх онд нэг их эмчийг зооноз өвчин судлалаар сургахаар төлөвлөөд байна.  Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран Коронавируст халдвар (ковид-19)-ын тандалтын тогтолцоог томуу, томуу төст өвчний харуулдан тандалтын тогтолцоонд нэгтгэх сэдэвт сургалтад Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 40 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж сургаж чадавхжуулсан. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран “Коронавируст халдвар, томуу, томуу төст өвчний тандалт, хариу арга хэмжээний чадавхыг сайжруулах нь сэдэвт аймгийн анхны зөвлөгөөнийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 8.8 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулсан. Тус

							зөвлөгөөнд аймаг, сумын Засаг дарга, БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нийт 60 гаруй хүн хамрагдсан. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
187	Цар тахлын үед ажиллах тусгаарлан эмчлэх болон тусгаарлан ажиглах байрыг томилгоожуулж, бэлэн байдлыг хангана.	-	Тусгаарлах эмнэлгийн орны тоо  Тусгаарлан ажиглах байрны орны тоо	2021	500  1000	500  1000	Аймгийн Засаг даргын 2021 оны 8 дугаар сарын 19-ний “Коронавируст халдвар” (ковид-19)-ын үед нэмэлтээр ор дэлгэх төлөвлөлтөд тодотгол хийх тухай” А/389 дүгээр захирамжаар Коронавируст (ковид-19) халдварт цар тахлын үед ажиллах тусгаарлан эмчлэх байрыг Арвайхээр суманд Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, хувийн хэвшлийн 386 ор, бусад сумдад 388 ор нийт 774 ор дэлгэж ажиллуулахаар төлөвлөн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэн бэлэн байдлыг хангасан. Цар тахлын халдвар хэвийн горимд шилжсэн тул 2022 оны эхний 9 сарын байдлаар тусгаарлан ажиглах байранд Коронавируст халдварын тохиолдол аваагүй байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
188	Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалтын төв, Онцгой байдлын газрын Сургалт дадлагын төв, ЭМГ-ын Хээрийн эмнэлгийг нэгтгэн зохион байгуулж, барьж эхлүүлнэ.	-	Ажлын гүйцэтгэлийн хувиар	2021	Байхгүй	Эхлүүлсэн байна	Аймгийн гамшгаас хамгаалах нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд гамшгийн үеийн цуглах цэг буюу Ямаатын хонхорт хээрийн эмнэлэг дэлгэхээр тусгагдсан. Цар тахлын өвчлөл буурч, хэвийн горимд шилжсэн тул хээрийн эмнэлгийг нэгтгэн зохион байгуулж, барих ажил хийгдээгүй байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
189	Халдварт өвчний үед дэлгэх 300 орны нөөц бүрдүүлнэ.	50,0 сая төгрөг	Нөөц орны орны тоо	2021	0	300	Гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах сангаас 27 ширхэг, орон нутгийн нөөц хөрөнгөөс 27 ширхэг, нийт 45 сая төгрөгийн 54 ширхэг ор, хөнжил, гудасны нөөцийг бүрдүүлэн, халдварт өвчний үед нэмэлтээр дэлгэхээр бэлэн байдлыг ханган ажиллаж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
<b>Зорилт 5.2. Цар тахлын үед боловсролын үйлчилгээг тасралтгүй тэгш, хүртээмжтэй явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.</b>							
190	Цар тахлын үед сургалтын байгууллагын орчинд халдваргүйтгэл хийж, багш ажилчдыг халдвар хамгааллын хувцас хэрэгслээр хангаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	-	халдваргүйтгэл хийж хэвшсэн байгууллагын эзлэх хувиар	2021	100	100	Ерөнхий боловсролын 32 сургууль, 45 цэцэрлэг, 34 дотуур байранд ариутгал, халдваргүйтгэлийг улирал тутамд 1-2 удаа 100 хувь хийж хэвшсэн. Мөн анги танхимын өдөр тутмын ариутгал, цэвэрлэгээг тогтмол хийж, сургууль, цэцэрлэгийн эмч нар сурагчид, эцэг эхчүүдэд халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, сургалт, үйл ажиллагааг хүргэн ажллаж байна. <b>Хэрэгжилт-100 хувь</b>
191	Сургууль, цэцэрлэг бүр цахим, теле хичээл бэлтгэн, технологийн сан	-	Цахим, теле хичээлийн тоо,	2021	70	120	Энэ онд Боловсрол, шинжлэх ухааны яамны Мэдээллийн технологийн газартай хамтран Шинэ зуун бүсийн сургуулийн багш, сургалтын менежерүүдэд "Ээлжит хичээлийн цахим контент" боловсруулах арга

	<p>бүрдүүлж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл сургалтыг тасралтгүй үргэлжлүүлж, танхимын болон танхимын бус, хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл, оролцоог дэмжин, тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулж, хоцрогдол арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.</p>		<p>технологийн сан бүрдүүлсэн эсэх</p>				<p>зүй" сургалтыг 29 сургуулийн 8 судлагдахууны 79 багшийг хамруулан танхимаар зохион байгуулж цахим контент боловсруулах арга зүйд суралцаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлээд байна. Аймгийн 31 сургуулийн 65 сургалтын менежерүүдэд "Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах хүрээнд цахим модуль сургалт, "10 дугаар ангийн сонгон судлах хичээлийн цахим сургалт" зэрэг агуулгаар онлайн сургалтуудыг тус тус зохион байгуулж чадавхжууллаа. Үндэсний "Мэдлээ.мн" цахим платформд 21 сургуулийн 39 багш бие даан, багаараа, сургууль хамт олноороо 34 нэгжийн 129 ээлжит хичээлийг бэлтгэн боловсруулж байршуулсан, арга туршлагаа түгээн дэлгэрүүлж, танхимын болон танхимын бус сургалтын үйл ажиллагааг хөгжүүлж, ажиллаж байна. Мөн 10 дугаар ангийн үндэсний хэмжээний онлайн хичээлийн сургагч багшаар 10 багш бэлтгэгдэж үндэсний хэмжээнд онлайн хичээлийг зааж байна.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт-100 хувь</b></p>
<b>Бүлгийн дүн 100 хувь</b>							
<b>ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ-91,0 ХУВЬ</b>							

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН